

Ногоон хөгжлийн төлөө

EMONGOLIAN ECONOMY



2011. Тавдугаар сар. №004

Уул уурхайн хэрэгцээг эрчим
хүчээр хэрхэн хангах вэ?

Төвбанкуудыг заналхийлсэн
аймшигт инфляци

Бэлгэдэл төдий ТУЗ минь баяртай

Монголын эдийн засаг, бизнесийн сэтгүүл



Эрчим хүч ирээдүй рүү

EMONGOLIAN ECONOMY

ШИНЭ ДУГААР



Сэтгүүлийн захиалгыг редакцид авч байна.

Утас: 70110064, 88800825, 99015476
Хаяг: Улаанбаатар, СБД VI хороо, Бага-Тойруу
37Б, Байр - 206 тоот

Професи Ресурс Корпораци нь Монголд нүүрсний хайгуул олборлолтын чиглэлээр Улаан-Овоогийн болон Чандганы талбайд үйл ажиллагаа явуулж байна.

Канададхь офис:

Хаяг: 2060-777 Hornby street (20th floor)
Vancouver, BC Canada, V6Z 1T7
Утас: +1.800.459.5583
Факс: +1.604.642.2629
И-мэйл: info@prophecyresource.com
Вэб: www.prophecyresource.com

Монгол дахь офис:

Хаяг: 201, 203-205, Амбасадор офис,
Энх тайвны өргөн чөлөө, 15А-5,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар
Утас: +976.11.331669
Факс: +976.11.312721
Вэб сайт: www.prophecy.mn
И-мэйл: info@prophecy.mn



Бид чанарыг эрхэмлэдэг



Дэлхийн эрчим хүчний салбарт тэргүүлэгч **ABB group** болон **МонХорус Интернэшнл ХХК** хамтран **CUSTOMER DAY** арга хэмжээг зохион байгууллаа.

Дэлхийн эрчим хүчний салбарт тэргүүлэгч 120 гаруй жилийн түүхтэй ABB group нь Монгол улс дах өөрийн албан ёсны түншлэгч “МонХорус Интернэшнл”ХХК-тай хамтран 2011 оны 04 сарын 20,21-ны өдрүүдэд ABB Group-ийн Customer Day буюу хэрэглэгчийн өдрийг Улаанбаатар хотноо зохион байгууллаа.



Хаяг: Монхорус Интернэшнл ХХК
УБ хот, СБД, 2-р хороо, Нарны зам-15
Утас: 7732 0700, 7732 8498
Факс: 7732 0082
И-мэйл: info@monhorus.mn
Вэб: www.monhorus.mn

Эрхлэгчийн зурвас

Үүсгэн байгуулагч,

Эрхлэгч: Д.Бэхбаяр
9999 4248

Үүсгэн байгуулагч,

Орлогч Эрхлэгч:
И.Отгонжаргал
8800 6228

Англи хэлний редактор:
J.Itofo

Сэтгүүлч:

Д.Мөнхчимэг
9191 3154
Х.Хулан
9975 7862

Орчуулагч:

Э.Өлзийлхам
9980 0723

Дизайнер:

Э.Чингүүн

Маркетингийн менежер:

Д.Бариянжав
8880 0825
Б.Энхцэцэг
9901 5476

Утас/Факс: 976 - 7011 0064

Вэб: www.mongolianeconomy.mn

И-мэйл: info@mongolianeconomy.mn

Хаяг:

Улаанбаатар, СБД VI хороо,
Бага-Тойруу
37Б, Байр - 206 тоот

15160 Улаанбаатар,
Төв шуудан, ш/ х-2762

Борлуулах цэгүүд:

"Интер ном"

"Majestic" их дэлгүүр

"Цэцэг төв"

"Зиг заг" автосервис

"Мир" номын дэлгүүрийн

"Grand plaza" дахь салбар

"Мир" номын дэлгүүрийн

"Metro mall" дахь салбар

"Минж плаза"

"Sky" супермаркет

"Алтантүлхүүр" номын дэлгүүр

“Улаанбаатар принт”
ХХК-д хэвлэв



Манай сэтгүүл шинэ дугаартаа улс орны амин чухал асуудал болсон эрчим хүчний салбарын тулгамдсан асуудал хийгээд ирээдүйн бодлого чиглэлийн талаар түлхүү хөндлөө. Өдгөө монголчууд бид том ордууд, уурхайнууд, их мөнгө, эдийн засгийн хурдтай өсөлтийн тухай ихээхэн ярьдаг болсон. Харин хөгжлийн гол түлхүүр эрчим хүчний талаар тэгтлээ ач холбогдол өгч ярьж байгаа бил үү? Монголчуудын төдийгүй дэлхийн томчуудын арааны шүлсийг асгаруулсан томоохон орд, уул уурхайн баялгийнхаа ашгийг эрчим хүчгүйгээр хэрхэн хүртэж, эдийн засгийн эргэлтэд оруулах билээ, бид. Эрчим хүч түрүүлж очсон газарт хөгжил ирдэг гэдэг. Эрчим хүч хөгжил авчирдаг нь үнэн.

Өнөөдөр Оюутолгой, Тавантолгойн эргэн тойрны асуудлаар амаа чилтэл ярьж буй. Гагцхүү энэхүү арвин ашиг орлого авчрах ордууддаа эрчим хүч хэрхэн хүргэх вэ гэдэг талаар тийм ч тодорхой зүйл алга. Дэлхий нийтийн анхаарлаа хандуулж буй сэргээгдэх эрчим хүчний бодлого манайд ямар байна вэ? Цахилгаан эрчим хүчний үнэ тариф, эрчим хүчний шинэ эх үүсвэрийг хэзээ барьж эхлэх вэ? гэсэн олон асуудлыг бид энэ дугаартаа хөндөхийг хичээлээ. Гэхдээ эрчим хүчний салбар болохгүй бүтэхгүй байна гэхээсээ илүүтэй хөгжлийн шинэ бодлого, зорилтыг олон нийтэд эн түрүүнд хүргэхийг эрмэлзэв.

“Монголын эрчим хүч-2011: Бодлого-хөрөнгө оруулалт-технологи” сэдэвт олон улсын чуулга уулзалтын үеэр төрөөс сүүлийн үед тус салбарт хэрхэн анхаарч, асуудлыг нь шийдэхийн төлөө ажиллаж байгааг илүү тодорхой харж болох нь. Энэхүү уулзалтаар эрчим хүчний салбарынхан ирээдүйн бодлого чиглэлээ хөрөнгө оруулагчдын өмнө дэлгэж, энэ чиглэлээр хамтран ажиллах төслөө танилцуулах юм. Тиймээс манай сэтгүүл улс орны гал голомт гэгддэг салбарын хөгжлийг дэмжих зорилгоор дээрх томоохон хурлын мэдээллийн түншээр оролцож буй юм.

Мөн энэ дугаартаа шатахууны импорт, инфляцийн галзуурал зэрэг олон нийтийн санааг зовоогоод зогсохгүй улс орны хэмжээнд сэтгэл түгшээсэн асуудалд анхаарал хандууллаа. “SOS биш ээ, зүгээр л сануулга...”, “Төв банкуудыг заналхийлсэн аймшигт инфляци” гэсэн гарчигтай нийтлэлүүд уншигч танд олныг өгүүлнэ. Институционал хөрөнгө оруулагчдыг хөгжүүлэх, малчин Доржийн хувьцааг хэрхэн хүргэх вэ гээд хөрөнгийн зах зээлтэй хобоотой мэдээллийг ч орхигдуулсангүй.

Түүнчлэн манай сэтгүүлийн сонирхол татам өгүүлдэг дэлхийд нэртэй бизнесмэн, компанийн түүхийг салж чадахгүй уншдаг уншигчид маань энэ удаа оргүй хоосноос өнөөгийн гайхамшигт Сингапур орныг бий болгож, тус улсын төрийг 50 гаруй жил барьсан Ли Гуан Югийн тухай болон амтархан унших болно. Үүнээс гадна бидний шинээр нээж байгаа “Хууль” булан маань компанийн захирлуудад таалагдана гэдэгт итгэлтэй байна.

Д.Бэхбаяр

6-27 Эрчим хүч

- 6 Эрчим хүч ирээдүй рүү
- 8 Монгол Улсын эрчим хүчний салбарын өнөөгийн байдал, хөгжлийн чиг хандлага
- 11 Уул уурхайн хэрэгцээг эрчим хүчээр хэрхэн хангах вэ?

13 Т.Цэрэнпүрэв: Эрчим хүчний салбар татаасаар амь зогоодог биш, улсын төсвийн орлого бүрдүүлэгч салбар болно

18 Шинэ хөгжил-ДЦС-5

20 Өрийн сүлжээнээс гарч, гялалзаж явах цаг ойртжээ

23 Ч.Даваахүү: “Ухаа худаг” цахилгаан станцад усны алдагдал гарахгүй

24 Та компанийнхаа одоогийн байдлыг хэрхэн үнэлж дүгнэж байна вэ? Мөн компанийн ирээдүйг хэрхэн харж байна вэ?

25 Б.Заяабал: Эрчим хүчний салбарт дэвшилт технологийг нэвтрүүлэх боломжтой

28-33 Ногоон эдийн засаг

28 Импортыг орлох “удирдлага”

30 Гурван хавцлын гайхамшиг

34-42 Эдийн засаг

34 SOS биш ээ! Зүгээр л сануулга...

37 Төвбанкуудыг заналхийлсэн аймшигт инфляци

38 Худалдагч нарт ёс зүй, худалдаанд хууль хэрэгтэй

41 Засуул төрийн эрэлд

42 Монголын хөгжлийг тэтгэх банк үүдээ нээлээ

43-47 Глобал эдийн засаг

43 Луугийн өсөлт

44 Доминик Стросс-Каныг хэн орлох вэ?

45 “Сингапур гайхамшгийн эцэг” шинэ үедээ зай тавьж өгөв үү?

48-53 Хөрөнгийн зах зээл

48 Б.Болд: Институционал хөрөнгө оруулагчдыг хөгжүүлмээр байна

51 Малчин Доржийн хувьцаа ба брокерийн үйлчилгээ

54-56 Уул уурхай

54 Алдагдсан боломж буюу алтны ралли

57-61 Бизнес

57 Бэлгэдэл төдий ТУЗ минь баяртай

59 Улаанбаатар хот ба PPP

62-65 Market Data



...Шар мөрний Жиан жин бүсэд аж төрдөг 15 сая хүн болон газар тариалангийн 1.5 сая га талбайг үерээс хамгаалж чадахаар болсон... (30)



...Газрын тос болоод нүүрсээ түүхийгээр нь асар хямд үнээр гаргачихаад... (34)



...Сингапурын бэлгэ тэмдэг болох “Merlion”-ыг мэдэхгүй хүн дэлхийд үгүй болжээ... (45)



Онцлох сэдэв

Эрчим хүч ирээдүй рүү

Д.Бэхээ

Хонгилын үзүүрт гэрэл харагдаж байна гэдэг шиг Эрчим хүчний салбарын хөгжил шинэ шатанд гарах алхмаа хийлээ. Олон жил дуншсан эрчим хүчний шинэ эх үүсвэрийн асуудлыг шийдвэрлээд байна. Тавдугаар эх үүсвэрийг барьснаар Монгол Улсын хөгжил шинэ шатанд гарах төлөв харагдаж байгаа талаар мэргэжилтнүүд хэдийнэ тэмдэглэсэн. Уул уурхай болон өсөн нэмэгдэж буй орон сууцнуудын эрчим хүчний хэрэглээг хэрхэн хангах талаар төрийн бодлого, хөтөлбөрүүд тодорхой болж байна. Одоо цаасан дээрх асуудлуудыг амьдралд цаг алдалгүйгээр буулгах, хэрэгжүүлэх шаардлагатай. Хэн нэгэнтэй би чи гэж маргахгүйгээр, намын хагаралд автахгүйгээр, зөвхөн улс орныхоо эрх ашгийн төлөө явбал болохгүй бүтэхгүй зүйлгүй билээ. Дэлхийн

хөгжил асар хурдтай явж байхад манай улсынх мэлхийн хурднаасаа салахгүй байгааг энд анхааруулах юун.

Түүх үнэнийг өгүүлнэ. 1990-ээд оны эрчим хүчний салбарыг Та эргэн санахыг хичээгээрэй. Эрчим хүчний хязгаарлалт, харанхуй хот суурин газрууд, ус дулаангүй орон сууцнууд, үлгэн салган ажиллах эрчим хүчний үйлдвэрүүд. Тухайн үеийн төр, засаг болоод салбарын үнэнч ажилтнуудын хичээл зүтгэл, донор орнуудын хандив тусламж, зээлээр монголчууд байнгын гэрэл гэгээ, дулаантай залгасан билээ. Гаднын зээл тусламжийн ихэнх хувийг эрчим хүчний салбар мангас шиг авч залгисан хэмээн зарим нэг хүн шүүмжилдэг. Үнэхээр тухайн үеийн бодит байдал их хэмжээний зээл авах нөхцөлийг бүрдүүлсэн шүү дээ. Тэр олон хаалгаа барьсан, техник

технологийн доройтолд орсон үйлдвэрүүдийн үйл ажиллагааг сэргээхийн тулд маш их мөнгө шаардлагатай болсон. Үүний дүнд ч тус салбар хөл дээрээ өндийн босож, бид ч гэрэл гэгээтэй дулаан өвөлждөг болсон нь үнэн ажгуу. Өнгөрсөн шинэ мянганаас хойш ялангуяа Улаанбаатар хотын иргэн Та цахилгааны хязгаарлалтад өртөж, гэрэл, дулаангүй өнжсөн өдрөө санаж байна уу. Хэрэв ийм зүйл тохиосон бол Та эвэртэй туулай үзсэн юм шиг аашилж, загнаж, уурлаж бухимдах байсан биз ээ. Гэхдээ сүүлийн үед энд тэнд дулааны шугам хагарлаа, эрчим хүч тасалдлаа гэсэн үг мэр сэр сонсогдох болсон.

Одоо

Таны худалдаж авсан машин олигтой засвар үйлчилгээ хийхгүйгээр хэр удаан явах бол. 15-

► 20 жил явж чадах уу. Дорвитойхон засвар үйлчилгээ, шинэчлэл хийлгүй 20 орчим жил зүтгүүлсэн эрчим хүчний үйлдвэрүүдийн техник технологи ямар байхыг Та төсөөлөөд үзээрэй. Уг нь техник технологийг байнгын тордож, засаж, сэлбэж, шинэчилж байж хэдэн жил явуулдаг шүү дээ. 1990-ээд оноос хойш зүтгүүлсэн үйлдвэрүүдийн техник технологи өнөөдөр хуучирч муудаж, зэвэрч, үйл ажиллагаа нь доройтох нь ойлгомжтой. 2000-гаад онд жилдээ цөөхөн удаа эрчим хүч тасардаг байсан бол 2009 оны байдлаар нэлээд олон удаа тасарсан гэсэн тоон баримт байна. Ерөнхийдөө 90-ээд оны байдал руугаа эргэн явж байна гэдгийг салбарын мэргэжилтнүүд анхааруулсаар ирсэн юм. Яагаад ийм байдал үүсэв.

Станц, үйлдвэр, уурхайнууд мэдээж их засварыг тодорхой хэмжээнд хийж ирсэн боловч үйлдвэрүүдийн удирдлагууд тухайн технологийг санасан хэмжээндээ хүртэл их засвар хийж чаддаггүйд л гол учир орших. Эрчим хүчний үйлдвэрүүд алдагдалтай ажиллаж байна, зардлаа хас, хэмнэ, алдагдлаа бууруул, өр, авлагаа багасга, цахилгаан, дулааны үнэ нэмэхгүй гэсэн захиргаадалтын шийдвэрүүд өнөөдөр энэ салбарыг хүнд байдалд оруулахад хүргэсэн хэрэг. Зах зээлийн жамаараа явах үнэ тарифыг албадан барьж, төр юмаа мэдэж байна гэсэн байдлаар хандсан нь адаг сүүлд нь эдийн засгийн суурь гэгддэг салбараа хүнд байдалд оруулсан гэж хэлж болох үндэстэй. Тиймээс үйлдвэрүүдийн удирдлага алдагдалтай бүтээгдэхүүн үйлдвэрлэж, дээр нь төрөөс үнийг нь зах зээлийн тарифаас доогуур барихаар тэд техник технологидоо төлөвлөсөн хэмжээндээ хүртэл их засвар хийж чадах уу. Засварын мөнгөө ханаж танаж, өөрөөр хэлбэл, гурван турбин засах мөнгөө танаад хоёр болгоно, дараа жил хоёрыгоо нэг болгоно.

Өнөөдөр үнэндээ эрчим хүчний салбар л зах зээлийн харилцаанд ороогүй үлдсэн бараг ганц салбар болж байна. Бүх асуудлыг нь төр мэддэг. Төрийн төмөр нударга, шийдвэрээр л урагшилж яваа манай онцгой салбар.

Сүүлийн үед энэ салбарт

улстөр нэлээд орох болсон талаар мэргэжилтнүүд санаа зовнигуй ярих. Учир нь бусад бүх үйлдвэр аж ахуйн нэгж хувьд очсон тул улстөрчдийн хошуу болон гар дүрэх ганц салбар нь эрчим хүч болжээ. Утас цохиод л хэрэгтэй хэрэггүй зүйл шахаж, арын хаалгын хүмүүсийг ажилд авдаг онцгой объект биш л баймаар. Жинхэнэ мэргэжил, ур чадвар шаардагдах газар арын хаалганы толгой хоосон хүмүүсээр дүүрвэл энэ салбарын ажил юу болж хувирах вэ? Дээр нь чадварлаг боловсон хүчнээ уул уурхайнханд алдаад эхэлсэн нь салбарын хувьд аюулын харанга дэлдэх боллоо. Улс орны эрчим хүчний манаанд зогсдог ажилтнуудын цалин хангамж уг нь социализмын үед бусад салбараас хамаагүй дээгүүр байсан бол өнөөдөр энэ байдал алдагдсан. Хуучирч, муудсан техник технологийг засаж, сэлбэж, шинэчилж болох ч мэргэжлийн чадварлаг хүмүүсээ алдах нь салбарын төдийгүй, улс орны хөгжилд ч нөлөөлөх том асуудал юм. УИХ-ын гишүүд нь хүртэл жил бүрийн улсын төсөв батлах үеэр өөрсдийн сонгогдсон тойрогтоо нэр нүүр олж авах зорилгоор тийм ч эрчим хүчний шугам барина, татна гэх мэтчилэн мөнөөх төсвийн хэдэн бор төгрөгийг ийш тийш нь чангааж эхэлдэг нь бас л нууц биш. Энэ байдал маргааш хэрхэн өөрчлөгдөх бол...(ирээдүй)

Салбарыг зах зээлийн харилцаанд шилжүүлэх тухай ярьж байна. Үйлдвэрүүдийг хувьчилснаар өдгөөгийн улсаас хувийнх болсон компаниуд шиг үйл ажиллагаа, маркетинг, нүүр царайны хувьд гялалзаад ирнэ гэдэг. Бодох л ёстой асуудал. Улсын онцгой, үндэсний аюулгүй байдалтай холбоотой аж ахуйн нэгжүүд тул хувьчлалд тун анхааралтай хандах ёстой гэдгийг амьдрал дээр харуулсан туршлага, алдаа онооны шийдвэрүүд буй. Тухайлбал, Багануурын дулааны станцыг хувьчлаад төр аргагүйн эрхэнд өөртөө эргүүлэн авсан гашуун туршлага бий. Хоёрдугаарт үнэ тариф. Үнэ тарифыг зах зээлийнх нь жамаар чөлөөлөх нь зөв гэсэн байр суурь төрд яваа. Гэхдээ үүнийг ард иргэдийнхээ амьжиргаа, улс орны хөгжилтэй

холбон авч үзэх нь ойлгомжтой. Цаашдаа дэс дараатай үнийг нэмэх замаар эрчим, хүч, нүүрсний үнийг чөлөөлөх тухай төрийн тогтоол шийдвэр журмууд ч гарсан байгаа. Мөн эрчим хүчний шинэ эх үүсвэр, улмаар томоохон чадлын усан цахилгаан станц барьснаар дотоодын хэрэглээгээ хангаад зогсохгүй эрчим хүчээр хойд хөршөөс хараат байдлыг халж, экспортлох замаар эрчим хүчний салбарын хөгжлийг хурдасгах, баталгаажуулах ирээдүй харагдаж байгаа юм. Мөн дэлхийн хөгжлийн чиг хандлага болсон сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх томоохон зорилт, бодлого ч яваа. Энэ бүх асуудлыг чухам ямар бодлогоор, яаж хэрэгжүүлэх талд манай сэтгүүл гол нийтлэлүүдээ чиглүүллээ. ■



Илтгэл

“Монголын эрчим хүч-2011: Бодлого-Хөрөнгө оруулалт-Технологи” хөрөнгө оруулагчдын чуулга уулзалт

Монгол Улсын эрчим хүчний салбарын өнөөгийн байдал, хөгжлийн чиг хандлага

Д.Зоригт / ЭБЭХ-ний сайд/

Эрчим хүчний салбарын өнөөгийн байдал

Монгол улсад 1924 оноос анх үндэс суурь нь тавигдсан манай эрчим хүчний салбар өнөөдрийн байдлаар улс орны эдийн засаг, нийгмийн бүх салбарт үйлчилж, өргөн уудам газар нутгийнхаа хүн ам суурьшсан суурин газууд болон айл өрх бүрт хүрсэн том салбар болон хөгжиж ирлээ. Манай салбар Баруун бүсийн эрчим хүчний систем, Алтай-Улиастайн эрчим хүчний систем, Дорнод бүсийн эрчим хүчний систем, Төвийн эрчим хүчний систем гэсэн 4 бие даасан систем ба Даланзадгадын ДЦС, бусад дизель станцууд болон зарим сэргээгдэх эрчим хүчний үүсвэрүүдээс бүрддэг.

Эрчим хүчний төв, баруун, зүүн бүсийн системийн дүнгээр 2010 онд дулааны цахилгаан станцууд 4256,1 сая кВт.ц, усан цахилгаан станцууд 31 сая кВт.ц болон нар, салхины эх үүсвэрээр 0,6 сая кВт.ц, дизель станцаар 13,2 сая кВт.ц цахилгаан үйлдвэрлэж, импортоор **214.1** сая кВт.ц цахилгаан эрчим хүч худалдан авч, экспортод 20.7 сая кВт.ц цахилгаан гарган, **3023,5** сая кВт.ц цахилгаан эрчим хүч, 6474,4 мян.Гкал дулааны эрчим хүчийг хэрэглэгчдэд түгээлээ.

Цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх хүчин чадлын 95хувь шахам хувийг дулааны цахилгаан станц, 4,7хувь хувийг импортын эрчим хүч, үлдсэнийг нь дизель станц, усан цахилгаан станц, бусад сэргээгдэх эх үүсвэр тус тус эзэлж, сүүлийн жилүүдэд төвийн бүсийн хэмжээнд гарсан хэрэглээний өсөлтийг үндэсний үйлдвэрлэлтээр үндсэнд нь хангаж чадсан байна. Харин ОХУ-аас тодорхой хэмжээний цахилгаан эрчим хүчийг импортоор авч төвийн хэрэглээний их ачааллын үеийн эрчим хүчний ачааллыг болон Баруун бүсийн хэрэглээний 60-70хувийг хангаж байна.

Эрчим хүчний компаниудын үйл ажиллагааны орлогын нийт дүн 280,5 тэрбум төгрөг болсон ба томоохон компаниуд улсын болон орон нутгийн төсөвт 66,3 тэрбум төгрөгийн татвар, шимтгэл төлсөн байна. Хэрэглэгчид болон бэлтгэн нийлүүлэгчдээс авах авлага 2010 онд 25,4 тэрбум төгрөг болж 17,5 хувиар, өглөг 29,3 тэрбум төгрөг болж 44,5хувиар тус тус өнгөрсөн жилээс буурчээ. 2008-2010 онд улсын төсөв болон Монгол улсыг хөгжүүлэх



сангаас Эрдэс баялаг, эрчим хүчний салбарт 105,5 гаруй тэрбум төгрөг хөрөнгө оруулсан ба үүний ихэнх нь үндсэндээ эрчим хүчний салбарт ноогдож байна.

Эрчим хүчний салбар 1990-2008 онд гадаад орон, олон улсын банк, санхүүгийн байгууллагаас 575,3 сая ам.долларын зээл, тусламж авсан ба үүний 347,9 сая ам.доллар нь зээл, 227.4 нь тусламж гэсэн ангилалд хамрагдаж байна. Эдгээр зээл тусламжийн хөрөнгөөр нийт 67 төсөл хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлсэн ба зарим нь одоо үргэлжилж байна.

Эрчим хүчний салбарын эрх зүй, зах зээлийн загварыг боловсронгуй болгож, гэрээт зах зээлийн загварыг нэвтрүүлэх ажлын хүрээнд 2010 оны 12 сард гарсан УИХ-ын 72-р тогтоолоор эрчим хүчний салбарын үйлдвэр компаниудын санхүү эдийн засгийн чадавхийг сайжруулах, эрчим хүчний үнийг индексжүүлэх, улмаар 2014 оноос зах зээлийн арилжааны хэлбэрт шилжих арга хэмжээг хэрэгжүүлэхийг заасан бөгөөд үүний дагуу яамнаас төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх ажил хийгдэж байна. Ийнхүү, манай орны эрчим хүчний салбар нь хэвийн тогтвортойгоор ажиллаж, улс орны эрчим хүчний хэрэглээг өнөөгийн түвшинд найдвартай, тасралтгүй ханган ажиллаж байна.

Хөгжлийн чиг хандлага

Салбарын хөгжлийн талаар баримталж буй бодлого зорилт, тэдгээрийн хэрэгжилт

Монгол улсын Их хурал, Засгийн газраас эрчим хүчний салбарын хөгжлийн хэтийн төлөвийг тодорхойлсон

» “Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн систем хөтөлбөр”, “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний хөтөлбөр”, “Буман нарны гэрэл хөтөлбөр” зэргийг батлан гаргасны зэрэгцээ “Үндэсний хөгжлийн цогц бодлого”, Засгийн газрын мөрийн хөтөлбөрүүдэд салбарын хөгжлийн ойрын болон урт хугацааны стратегийг тодорхой заан тусгасан байдаг.

Төвийн, Баруун бүсийн, Дорнод бүсийн, Алтай-Улиастайн Эрчим хүчний системүүд болон одоогийн Даланзадгадын ДЦС буюу Говийн бүсийн эрчим хүчний систем нь 2040 он гэхэд хоорондоо өндөр хүчдлийн цахилгаан дамжуулах агаарын шугамаар холбогдож Монголын Эрчим хүчний нэгдсэн системийг бүрэн бүрдүүлэх бөгөөд Тавантолгой, Шивээ Овоо, Багануур, Хөшөөт, Нүүрст хотгор, Адуунчулуун болон Могойн голын зэрэг нүүрсний уурхайнуудыг түшиглэсэн ДЦС-ууд, түүнчлэн Эг, Орхон, Сэлэнгэ зэрэг гол мөрөн дээрх УЦС-ууд, Говийн болон төвийн бүсэд баригдах том чадлын нар, салхины эх үүсвэрүүд, Дорнод бүсэд барих боломжтой цөмийн цахилгаан станц зэрэг эх үүсвэрүүдээс цахилгаан эрчим хүч үйлдвэрлэн өөрийн орны өсөн нэмэгдэж буй хэрэглээг бүрэн хангах, мөн хөрш орнуудад экспортлох чадамжтай байхаар салбарын хөгжлийн болон бодлогын баримт бичгүүдэд төлөвлөгдсөн юм.

“Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн систем хөтөлбөр”-ийн хэрэгжилт:

Монгол улсын 21 аймаг, 333 сум суурин газрын 318 сум суурин газрыг төвлөрсөн эх үүсвэрээс, 15 сумыг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр болон дизель хосолсон эх үүсвэр ашиглан эрчим хүчээр хангаж байна. “Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн систем хөтөлбөр”-ийн нэгдүгээр үе шат буюу ойрын хугацааны (2007-2012 он) төлөвлөгдсөн арга хэмжээнүүд хэрэгжилтийн шатандаа байна.

“100000 нарны гэрэл”, “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилт:

Өнөөдрийн байдлаар Монгол оронд сэргээгдэх эрчим хүчний зориулалтаар ашиглах ажил бодит биелэлээ олж өнөөдөр манай орны 100000 гаруй малчин айл өрх, 15 сум сэргээгдэх эрчим хүч ашиглан цахилгаантай болсон. “100000 нарны

гэрэл” үндэсний хөтөлбөр нь 2011 онд сүүлийн 20000 нарны эрчим хүчний үүсгүүрийг хөдөөгийн малчид, хэрэглэгчдэд хүргэснээр бүрэн хэрэгжиж дуусах юм.

Эрчим хүчний төвлөрсөн системээс алслагдсан сумдын төвийг бие даасан нар, салхи, усны эрчим хүч ашиглан эрчим хүчээр хангах, мөн бусад эх үүсвэртэй хослон ажиллуулах зорилтыг тавьж одоогийн байдлаар 11 жижиг оврын УЦС, таван нар, салхи хосолсон цахилгаан станц, найман нарны цахилгаан станц, нэг салхин цахилгаан станцууд сум, багийн төвийн цахилгаан хангамжид ашиглагдаж байна. Түүнчлэн, Дөргөн, Тайширын дунд чадлын УЦС-ууд ашиглалтад орж баруун аймгуудын хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр хангах эх үүсвэр болж байна.

Салбарын хөгжлийг үе шаттайгаар дүгнэж үзвэл, 2000-2008 он хүртэл салбарт бүтцийн өөрчлөлт хийгдсэн, улс орныг цахилгаанжуулахад чиглэгдсэн төрийн бодлого хэрэгжиж, хөдөөгийн бүх аймаг, сум суурингууд төвлөрсөн цахилгаан хангамжид холбогдон, малчин айл өрхүүд бага оврын сэргээгдэх эх үүсвэрүүдээр хангагдсан цахилгаанжуулалтын үе, он жилүүд байсан.

2008-2011 онуудад эрчим хүчний системийн найдваржилтыг хангах зорилгын үүднээс тоног төхөөрөмж, технологийн өргөтгөл, шинэчлэлийг хийж хэрэгжүүлсэн ба бүс нутгийн эрчим хүчний системүүдийг эх үүсвэрээр хангах зарим бэлтгэл ажил хийгдэж буй үе шат билээ.

2011-2016 онуудад манай орны өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хангах эрчим хүчний системийн томоохон эх үүсвэрүүд, дамжуулах өндөр хүчин чадалтай гол шугамауд шинээр баригдаж Эрчим хүчний нэгдсэн систем бүрэлдэн бий болох хөгжлийн шинэ үе шат эхэлж байна гэж бид үзэж байгаа болно. Энэ үе нь Монголын эрчим хүчний салбарт байгаль орчинд халгүй, орчин үеийн үр ашиг бүхий шинэ техник технологитой эх үүсвэрүүд бий болсон салбарын хөгжлийг шинэ шатанд гаргасан технологийн дэвшлийн үе байх болно гэж тооцож байна.

Ойрын хугацааны стратеги, зорилтын талаар

Ойрын хугацаанд шинэ эх үүсвэр барихгүй тохиолдолд Улаанбаатар хотын өсөн нэмэгдэж буй хэрэглээ, Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай хууль болон “Шинэ

Бүтээн Байгуулалт” хөтөлбөрийн хүрээнд хийгдэх ажил, хэрэгжих үйл ажиллагаатай холбогдон гарах эрчим хүчний нэмэлт хэрэгцээ, Уул уурхай, ашигт малтмалын томоохон төслүүдийн эрчим хүчний хангамжийг яаралтай шийдвэрлэх зэрэг асуудалд хүндрэл бий болж яваандаа эрчим хүчний чадлын дутагдалд орох төлөв ажиглагдаж байна. Хэдийгээр шинэ эх үүсвэр барих тухай асуудал салбарын бодлого, төлөвлөлтийн хүрээнд үе шаттайгаар хэрэгжихээр төлөвлөгдөж ирсэн боловч хөрөнгө санхүүгийн дутагдал болон бусад нөхцөл, шалтгаанаар хэрэгжилгүй өнөөг хүрч, одоо цаг хугацааны хувьд нэн тулгамдсан асуудал болсон байна. Шинэ эх үүсвэртэй холбоотой асуудлыг нэг мөр, цогц байдлаар шийдвэрлэх шаардлага өнөөдөр бидэнд тулгараад байна.

Түүнчлэн, эрчим хүчний салбарт хувийн хэвшлийн оролцоог дэмжих, салбарыг зах зээлийн харилцаанд бүрэн шилжүүлэх үнэ тариф, эрхзүйн орчинг нь бүрдүүлэх, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, түншлэлийг хөгжүүлэх зэрэг нь салбарын шийдвэрлэвэл зохих асуудлууд бөгөөд дээрх тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх гарцуудын нэг хэсэг байж болох юм гэж үзэж байна.

Монголын эрчим хүчний салбарт ойрын хугацаанд шийдвэрлэвэл зохих эдгээр асуудлууд нь манай салбарын бодлогын үндсэн баримт бичгүүдэд тодорхой шинэчлэл, тодруулгыг хийх шаардлагыг бий болгож байгаа бөгөөд ЭБЭХЯ-ны зүгээс 2011 онд багтаан бодлогын үндсэн бичиг баримт болох “Монгол улсын Эрчим хүчний нэгдсэн систем хөтөлбөр”, Эрчим хүчний салбарын Мастер төлөвлөгөө”-нд шинэчлэл, тодотголыг хийхээр төлөвлөн ажиллаж байна. Эдгээр хөтөлбөр, төлөвлөгөөний тодотголын хүрээнд хийгдэх судалгаа, тооцоогоор салбарын эрчим хүчний хэрэглээний өсөлт, түүнийг хангах бодлого, төлөвлөлт нь илүү тодорхой, нарийвчлалтай боловсрогдож, энэхүү Монгол орны эдийн засаг, нийгмийн хөгжлийн чиг хандлагад нийцсэн, олон улсын жишигт хүрсэн, үндэслэл сайтай бичиг баримт нь хөрөнгө оруулагч нарын сонирхолд нийцэх, улмаар хөтөлбөрийн хүрээнд төлөвлөгдсөн төслүүд бодит амьдралд хэрэгжих боломж нөхцөл бүрдэнэ гэж үзэж байна.

Улаанбаатар хотын хөгжлийн

» ерөнхий төлөвлөгөөнд үндэслэн гаргасан 2020 хүртэлх ЦЭХ-ний хэрэглээний таамаг, Азийн хөгжлийн банкны Зөвлөх компанийн Улаанбаатарын ДЦС-5 төслийн техникийн судалгааны хүрээнд тооцоолсон Монголын ТЭХС болон Говийн уул уурхайн бүсийн ЦЭХ-ний ачааллын таамаг, “Шинэ бүтээн байгуулалт” хөтөлбөрийн хүрээнд шаардагдах болон “Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай” хуулинд тусгагдсан нийслэлийн гэр хорооллын айл өрхийг цахилгаан халаагуураар халаахад шаардлагатай цахилгаан эрчим хүч, “Уорли Парсонс” компанийн хийсэн аж үйлдвэрийн бүсүүдийн эрчим хүчний хэрэглээний тооцоо, 2010 онд ЭБЭХЯ-наас захиалж хийлгэсэн “Говийн бүсийн уул уурхайн томоохон хэрэглэгчдийн эрчим хүчний хангамж” ТЭЗҮ зэрэг аж үйлдвэрийн болон суурингуудаар хэсэгчлэн хийгдсэн судалгаануудын тоо, тооцоог тоймлон нэгтгэн тооцоолж үзвэл, 2015-2030 оны түвшинд эрчим хүчний хэрэглээ 1500-3000 МВт хүртэл өсөх, шинэ нэмэлт хэрэглээ гарахаар байна.

Эрчим хүчний салбарын бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан болон дээр дурьдсан асуудлуудыг шийдвэрлэх зорилтын үүднээс энэхүү нэмэлт хэрэглээний өсөлтийг хангах эрчим хүчний шинэ эх үүсвэрүүдийг үе шаттайгаар барьж байгуулах нь манай салбарын ойрын хугацааны үндсэн зорилт болж байгааг энд онцлон тэмдэглэх байна.

Одоогоор салбарт Ухаа худагийн 18 МВт ДЦС баригдаж, ДЦС-4-ийг 40 МВт-аар өргөтгөсөн ба Дархан ДЦС-ийг 30 МВт-аар, Даланзадгадын ДЦС-ыг 3 МВт-аар өргөтгөх ажил хийгдэж байна, Салхитын 50 МВт-ын салхин парк, Хөшөөтийн 12 МВт ДЦС болон Могойн голын 60 МВт ДЦС баригдах бэлтгэл хангагдаж байна. Түүнчлэн, томоохон эх үүсвэрүүдийн нэг болох Улаанбаатарын ДЦС-5 төслийн ТЭЗҮ хийгдэж дуусан, Засгийн газар, ҮАБЗ-өөр баталгаажин, одоо төслийг яаралтай хэрэгжүүлэхээр хөрөнгө оруулагч та бүхэнд хандаж байгаа билээ.

2015-2030 оны түвшинд дээр дурдсан хэрэглээний өсөлтийг хангах, эрчим хүчний эцсийн бүтээгдэхүүн болох цахилгаан эрчим хүчийг экспортлох манай салбарын зорилтыг ажил хэрэг болгоход Таван толгой, Шивээ Овоо, Багануур, Адуунчулуун, Хотгор, Бөөрөлжүүт, Чандганы

болон бусад нүүрсний ордуудыг түшиглэсэн цахилгаан станцуудыг барьж байгуулах шаардлагатай болж байгаа бөгөөд эдгээр төслүүдийг хэрэгжүүлэхэд олон улсын банк, санхүүгийн байгууллагууд, гадаад дотоодын хөрөнгө оруулагчид, шинэ техник технологи-эрчим хүчний бизнес эрхлэгчид та бүхний санаачлага, идэвхитэй оролцоо, дэмжлэг ихээхэн чухал байна. Манай улсын төрийн бодлого, хууль эрхзүйн орчин нь төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалтыг дэмжсэн таатай нөхцөлтэй байгаа нь Монголд хөрөнгө оруулж үйл ажиллагаа явуулж байгаа компаниудад биенесээ өргөтгөх нөхцөлийг бүрдүүлэх ач холбогдолтой юм.

Түүнчлэн, манай орны эрчим хүчний үйлдвэрлэлийн хүчин чадлыг тодорхой хувиар нэмэгдүүлэхэд Сэргээгдэх эрчим хүчний талаар баримталж буй бодлогын хүрээнд хэрэгжүүлэх томоохон чадлын УЦС, салхин паркууд, нарны эх үүсвэрүүдийн төслүүд мөн хамаарна.

Ойрын хугацааны хэрэглээний өсөлтийг хангах эдгээр эрчим хүчний эх үүсвэрүүд, ЦДАШ-ын талаархи асуудлыг 2010 оны 4 дүгээр сард Засгийн газар, 5 дугаар сард ҮАБЗ-өвлөлд тус тус танилцуулж зарчмын хувьд дэмжлэг аваад байна. Ойрын хугацаанд эрчим хүчний салбарыг хөгжүүлэхэд дараахь үндсэн зарчим, стратегийг манай яам баримтлана. Үүнд:

- Эрчим хүчний хэрэглээний таац, прогнозыг үндэслэл сайтай хийж, түүнд үндэслэсэн төлөвлөлтийг боловсруулах,

- Эх үүсвэрүүдийг эхний ээлжинд барьж байгуулах болон эрчим хүчний салбарыг түрүүлж хөгжүүлэх санхүү, эдийн засгийн боломжийг бүрдүүлэх,

- Хувийн хэвшлийн эрчим хүчний эх үүсвэрүүдийг барьж ашиглах явдлыг дэмжиж, үнэ тариф, эрхзүйн орчинг нь бүрдүүлэх, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, түншлэлийг хөгжүүлэх,

- Төрийн мэдлийн дамжуулах сүлжээг хэрэглээ, эх үүсвэрийн төлөвлөлттэй уялдуулан хөгжүүлэх, шинэчлэн өргөтгөх,

- Эрчим хүчний салбарын үр ашгийг нэмэгдүүлэх, санхүүгийн тогтвортой байдлыг хангах, эдийн засгийн үндэслэлтэй зохицуулалтыг хэрэгжүүлэх, үнийг чөлөөлөх, салбарыг зах зээлийн харилцаанд бүрэн шилжүүлэх

Эрчим хүчний үнэ тариф, эрхзүйн орчинг хөрөнгө оруулагчид таатай байдлаар бүрдүүлэх, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, түншлэлийг хөгжүүлэх, эрчим хүчний шинэ эх үүсвэрүүдийг хувийн хэвшлийн оролцоотойгоор барьж байгуулах, ашиглах зэрэг нь эрчим хүчний салбарыг зах зээлийн харилцаанд шилжүүлэх угтвар нөхцөл нь болно. Одоогийн байгаа эх үүсвэрүүд, цахилгаан түгээх сүлжээнүүдийг хувьчлах асуудал нь салбарыг зах зээлийн харилцаанд шилжүүлэх нөхцлийн нэг хэсэг нь болж байгаа юм. Түүнчлэн, хувийн хэвшлийн эх үүсвэрүүд бий болсноор салбар зах зээлийн харилцаанд бодит утгаараа шилжих, өрсөлдөөн үүсэх нөхцөл бас бүрдэх юм.

Харин төрийн зүгээс хуулийн дагуу өөрийн мэдэлд байх Дамжуулах сүлжээг шинэчлэн сайжруулах, өргөтгөх, шинээр барих үйл ажиллагааг шинээр баригдах эх үүсвэрүүдийг байгуулах явцтай уялдуулан хөгжүүлэх шаардлага гарч байна.

Ийнхүү шинээр баригдах эх үүсвэрүүд болон цахилгаан дамжуулах сүлжээ, түүнчлэн уламжлалт болон сэргээгдэх эрчим хүчний зөв зохистой харьцаа бүхий системийг бий болгосноор манай орны Эрчим хүчний нэгдсэн систем хөтөлбөр үндсэн утгаараа хэрэгжиж улсын хэмжээнд цахилгаан эрчим хүчний хангамжийн найдвартай, аюулгүй байдлыг хангах, улмаар хөрш орнуудад эрчим хүч экспортлох боломж нөхцөлөөр хангагдах билээ. Шинэ техник, технологи бүхий Эрчим хүчний нэгдсэн систем байгуулагдсанаар Монгол Улсад цахилгаан хангамжийг үр ашигтай, хэмнэлттэй горимоор ажиллуулах нөхцөл бүрдэж, улмаар улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийг бүхэлд нь түргэтгэх, эдийн засгийн аюулгүй байдлыг баталгаажуулахад манай салбарын оруулах хувь нэмэр өндөр ач холбогдолтой байх болно гэж үзэж байна.

Энэхүү “Монголын эрчим хүч-2011” хөрөнгө оруулалтын чуулга уулзалтын үеэр бизнес эрхлэгч, ажил хэрэгч хүмүүс та бүхэн холбогдох мэдээллээ олж авч, бизнесийн холбоо тогтоон Монголын эрчим хүчний салбарт хөрөнгө оруулах, хэрэгжүүлэх ажил, төсөл хөтөлбөрийн бодитой саналтай болно гэж найдаж байна. Та бүхэнд амжилт хүсье. ■



Тулгамдсан асуудал

Уул уурхайн хэрэгцээг эрчим хүчээр хэрхэн хангах вэ?

Оюутолгой, Тавантолгойн ачаар үсрэнгүй хөгжилд хүрнэ хэмээн монголчууд хөөрөх. Монгол оронд 80 төрлийн ашигт малтмалын 1170 орд, 8000 орчим илрэл бүртгэгдсэн хэмээн баясах. Гэхдээ гэрэл, цахилгаангүйгээр эрдэс баялгийн үйлдвэрлэл, их бүтээн байгуулалтын тухай мөрөөдөөд ч хэрэггүй ээ. Социализмын үед эрчим хүчний салбараа түрүүлж хөгжүүлнэ гэж ярьдаг байсныг Та мэдэх байх. Харин өнөөдөр стратегийн ач холбогдол бүхий энэхүү салбар маань түрүүлэх нь битгий хэл, хоцрох байдалд ороод явж буй нь хатуу үнэн билээ.

Эргэн тойрноо ажиглахуй

Уул уурхайн салбар гадаадын шууд хөрөнгө оруулалтын 80 гаруй хувийг дангаараа “залгиж”, ДНБ-ий 30, экспортын 85 хувийг бүрдүүлэх болов. Гэвч саалиа бэлдэхээр саваа бэлд гэж монголчууд ярьдаг даа. Ашиглагдаагүй зэсийн хамгийн том нөөц гэсэн тодотголтой Оюутолгойн төсөл үйлдвэрлэл эхлэх хугацаагаа наашлуулж, 2012 он болгосон билээ. Олны дунд баяр хөөр дагуулж буй энэ мэдээ эрчим хүчний салбарынхны хувьд “шүдний өвчин” болсон нь мэдээж. Учир нь өнөөдөр 24 МВт-ын дизель станцаар л дулаан, цахилгаанаа залгуулж буй Оюутолгойн үйлдвэрлэл жигдрээд ирэх үед 280 МВт-ын эрчим хүчний хэрэгцээ гараад ирнэ гэсэн тооцоо бий. Манай ТЭЦ 3-ын хүчин чадлыг хоёр дахин нэмэгдүүлээд ч хүрэлцэхгүй энэ хэрэгцээг яаж хангах билээ? Арай ашигт малтмалаа урд хөрш рүүгээ гаргаад, оронд нь эрчим хүч байнга импортлох юм биш биз? Харамсалтай нь яг ингэж байгаа жишээ мундахгүй бий.

Өмнөговь аймгийн Гурвантэс суманд эдүгээ Монгол-Хятадын хамтарсан “Чинхуа-МАК-Нарийн сухайт”, “Монголын алт” корпораци (МАК) болон “Саусгоби Сэндс” компани нүүрс олборлож буй.

Ийшээ 2006 онд 35 кВ-ын шугам Хятадаас татаж авчраад, уурхайн хэрэгцээг төдийгүй Өмнөговь аймгийн Ноён, Сэврээ, Гурвантэс сумыг эрчим хүчээр хангаж байгаа юм. Гэтэл өнөөдөр 35 кВ-ын шугамаар орж ирж буй гэрэл, цахилгаан нь хаанаа ч хүрэхээ байснаас “Саусгоби Сэндс”, МАК хоёр энэ шугамаар тохиролцож, чадвал энэ ондоо багтаад 110 кВ болгохоос өөр замгүй болсон юм билээ. Ийм нөхцөлд нүүрсээ боловсруулах, нэмүү өртөг шингээх талаар санасны ч хэрэггүйг мэргэжилтнүүд тайлбарлаж байна. Цаашдаа МАК нүүрс баяжуулах үйлдвэр барих зорилготой байгаа ч Нарийн сухайтад цахилгаан станц барихаас нааш энэ нь амьдралд хэрэгжихгүй ажээ. Ийнхүү бид нүүрсээ Хятадад гаргаад, оронд нь цахилгаан авч суух нь энгийн хэрэг болоод удаж байна. Уул уурхайн их бүтээн байгуулалт өрнөж буй говийн бүсийн эрчим хүчний хангамжийн байж байгаа царай ийм л байна. Уг нь дизель станц, импортоор голоо зогоож буй уул уурхайн компаниуд эрчим хүчний найдвартай эх үүсвэртэй холбогдож л байвал хөрөнгө, мөнгөө хайрлахгүй нь лавтай. Манай энэ салбарыг олигтойхон дэмжиж, хөгжүүлэх боломжийг олгож байсан бол уул уурхайн өсөн нэмэгдэж буй хэрэгцээг “толгойны өвчин” биш, “түрийвч түнтийлгэх эх үүсвэр” мэтээр харж болох буюу.

Ямар төлөвлөгөө байна вэ?

Тавантолгой ордыг түшиглэн дулааны цахилгаан станц барьж, түүгээрээ говийн бүсийг эрчим хүчээр хангах төрийн бодлого уг нь бий. Гэхдээ судалгааны шатанд явж байгаа энэ ажилд 4-5 жил шаардлагатайг мэргэжилтнүүд ярьж байна. Тэрнээс өмнө нийслэлээс Тавантолгой, Оюутолгой руу 220 кВ-ын шугам татах тендер зарлаж, “М-Си-Эс Интернэйшнл” компани гүйцэтгэх болсон билээ. Өөрөөр хэлбэл, Чойр, Мандалговь, Тавантолгой руу татах шугамын ажлыг хэрэгжүүлж, дотоодын эх үүсвэрээс томоохон

» уурхайнуудыг цахилгаанаар хангаж таарах нь. Төвийн эрчим хүчний систем өөрийгөө яая гэж байж юун Тавантолгой, Оюутолгойг хангах манатай гэж Та гайхаж магадгүй. 2015 он гэхэд ТЭЦ 5-ын эхний үе шат хэрэгжсэнээр 450 МВт цахилгаан, 500 Гкал дулаан боловсруулахаар байгаа нь авралын дохио болж байгаа юм.

Харин Тавантолгойн цахилгаан станц босоод ирэх цагт дээрх шугам эсрэгээрээ, говийн бүсээс төвийн бүсээ эрчим хүчээр хангах үүрэг гүйцэтгэх юм билээ. Товчхондоо, бид нэг сумаар хоёр туулай буудах гэж байгаа нь энэ. Харин тэр сайхан цагийг хүртэл Оюутолгойн төсөл БНХАУ-аас эрчим хүч импортлохоос өөр арга алга даа.

Түүнчлэн Цагаан суваргын ордыг Багануураас Чойроор дамжуулан цахилгаанаар хангах ажил зураг төслийнхөө шатанд явж байна. Зөвхөн энд л гэхэд 70 МВт-ын хүчин чадал хэрэгтэй гэх тооцоо гарсныг “Монголын алт” корпорацийн дэд ерөнхийлөгч Г.Цогт тайлбарлав. Тодруулбал, Багануур Чойрын 110 кВ-ын шугамыг хоёр хэлхээ болгож, Чойроосоо 220 кВ-ын шугам татах замаар л Цагаан суваргын зэс-молибдений ордыг эдийн засгийн эргэлтэд оруулж болох юм. Үүнийг концессын дагуу МАК өөрөө хийх төлөвтэй. Цогцоор нь авч үзвэл говийн бүсийн эрчим хүчийг шугам, цахилгаан станц гэсэн хоёр замаар хангахад төрийн бодлого чиглэж буй ажээ.

Хувийн хэвшлийнхэн наашиллаа

Сүүлийн үед эрчим хүчний салбарт хувийн хэвшлийнхэн хүч түрэн орж ирэх болов. Ухаж үзвээс уул уурхайн компаниуд энэ салбарт хөрөнгө оруулахаас өөр ямар ч аргагүй болоод байгаа юм. “Энержи ресурс” компани Ухаа худагт 18 МВт-ын хүчин чадал бүхий цахилгаан станц ашиглалтад оруулахад бэлэн болсон. Түүнчлэн Хөшөөтийн уурхайд үйл ажиллагаа явуулж буй “Мо Эн Ко” компани ч 12 МВт-ын дулааны цахилгаан станц барих зөвшөөрлөө авчихаад байгаа юм. Энэ мэтээр хувийн компаниуд эрдэс баялгийн салбарт үйл ажиллагаа явуулахын тулд эрчим хүчний асуудлаа өөрсдөө зохицуулах шаардлагатай тулгарч буй.

Гэхдээ хувийн хэвшлийн оролцоог дэмжиж, тэдэнд боломж олгохын зэрэгцээ төрийн ачааг хөнгөлөх бодлого хэрэгжиж эхэлснийг сануулах нь зүйтэй болов уу. 2010 оны хоёрдугаар сард Концессын тухай хууль гарснаар эрчим хүчний салбар дахь хувийн хэвшлийн оролцоо нэмэгдэх, ялангуяа гадаад дотоодын хөрөнгө оруулагч нарыг дэмжих эрх зүйн нөхцөл бүрдэж эхэлсэн гэж ойлгож болно. Засгийн газраас баталсан концессын жагсаалтад эрчим хүчний холбогдолтой 16 объектыг хувийн хэвшилд шилжүүлнэ гэсэн чиглэл ч бий. Энэ хүрээнд эхнээсээ 60 МВт-ын Могойн голын станцын төсөл хэрэгжээд явж байх жишээтэй. Түүнчлэн ТЭЦ 5, Тавантолгойн станц ч гэсэн концессын дагуу хэрэгжих төлөвтэй. Сэргээгдэх эрчим хүчний эрх зүйн орчин ч сайжирсан тухай дурдахгүй өнгөрч болохгүй биз. Тухайлбал, “Клинтек” компани Өмнөговь аймгийн Ханбогд сумд 250 МВт-ын салхин парк барих зорилт тавин ажиллаж байна шүү дээ.

Эцэст нь...

Уул уурхайн өсөн нэмэгдэж буй хэрэгцээний зах зухаас нь л дурдахад ийм байна. Ер нь 2015-2030 оны түвшинд эрчим хүчний 3000 МВт орчим нэмэлт хэрэглээ гарахаар байгааг Эрдэс баялаг, эрчим хүчний яамныхан тооцоолсон байна билээ. Манай ДЦС-уудын нийт хүчин чадал 856.3 МВт байгаатай харьцуулахад энэ бол тэнгэрийн тоо юм.

Уг нь дээрх хэрэгцээг хангаад, хангалттай их ашиг олох сайхан төслүүд цаасан дээр бичээстэй л байдаг. Тухайлбал, Нялга-Чойрын бүсэд 4800 МВт хүчин чадалтай Шивээ-Овоогийн цогцолбор боссоноор дотоодын хэрэгцээнд 7.6 хувь буюу 273 МВт-ыг нийлүүлж, үлдсэнийг нь БНХАУ руу экспортлох боломж бий. Түүнчлэн 300 МВт-ыг Өмнөговийн бүсийн уурхайнуудын эрэлт хэрэгцээг хангахад зарцуулна гэсэн тооцоо ч байв. Харамсалтай нь энэхүү төслөөс одоо хүртэл үр дүнг нь гаргаж чадаагүй байна. Энэ мэтийн төсөл урагшлахгүй байгаа шалтгаан нь үнэ тарифын буруу бодлого, хөрөнгө оруулалтын таагүй орчинтой холбоотойг мэргэжилтнүүд тайлбарлаж буй.

Эрчим хүчний салбар нь их хэмжээний хөрөнгө оруулалт шаарддаг бөгөөд өгөөжөө өгөх хугацаа нь урт байдгаараа хүндрэлтэй билээ. Үүний зэрэгцээ Монголд эрчим хүчний үнийг төрөөс зохицуулдаг нь хөрөнгө оруулалтыг үргээж буй нь нууц биш. Өртгөөсөө доогуур үнэтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэж борлуулдаг алдагдалтай салбарт хөрөнгө оруулах сонирхолтой хүн хаанаас олдох билээ? Харин 2010 оны арванхоёрдугаар сарын 9-нд “Түлш, эрчим хүчний салбарын талаар авах зарим арга хэмжээний тухай” УИХ-ын 72-дугаар тогтоол гарсан нь салбарын хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах суурь болсон хэмээн мэргэжилтнүүд үзэж байна. Дээрх бичиг баримтын хүрээнд нүүрсний болон эрчим хүчний үнийг 2014 он хүртэл үе шаттайгаар нэмэгдүүлж, цаашдаа зах зээлийн зарчимд шилжүүлэх боломж бүрдсэн билээ.

Олон жилийн турш хөрөнгө оруулагчдыг татах зүйлгүй шахам ирсэн эрчим хүчний салбарын ирээдүй одооноос өөрчлөгдөж эхлэх нөхцөл ийнхүү бүрджээ. Энэ эрчээрээ урагшилж, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулж чадваас уул уурхайн хэрэглээ өсөх тусам баярлах биз ээ. Цаашилбал эцсийн бүтээгдэхүүн болох цахилгаан эрчим хүч экспортлох зорилгыг төр, засаг өвөртөлж буй. Үүнийгээ л биелүүлж чадвал бид үсрэнгүй хөгжилд жинхэнэ утгаараа хүрэх буюу. ■



Эх сурвалж: ЭХЗГ-аас гаргасан “Эрчим хүчний статистик үзүүлэлтүүд 2010” эмхтгэл

Албаны хүний яриа

Т.Цэрэнпүрэв: Эрчим хүчний салбар татаасаар амь зогоодог биш, улсын төсвийн орлого бүрдүүлэгч салбар болно

Эрдэс баялаг, эрчим хүчний яамны Эрчим хүчний бодлогын газрын дарга Т.Цэрэнпүрэвтэй ярилцлаа.

-Эрчим хүчний салбарын өнөөгийн байдлыг Та юу гэж дүгнэж байгаа вэ?

-Бид хэрэглэгчдийг цахилгаан, дулаанаар найдлагатай хангах үндсэн үүргээ биелүүлээд явж байна. Гэхдээ салбарт шинэ эх үүсвэр барих, техник технологийн шинэчлэл хийх, эдийн засгийн чадавхитай болгох цаг болсон нь үнэн. Одоо ажиллаж байгаа станцуудынхаа насжилт, техник технологийн байдлыг эргээд нэг авч үзэхэд бид 1960-1970-аад оны технологи, объектуудаа одоо хүртэл ашиглаж байна шүү дээ. Аль 1995 онд үйлдвэрлэлээс хасагдсан “Excel” загварын машиныг монголчууд засаж, янзлаад унаад л яваа. Гэтэл тухайн машины дараагийн гурван үеийн шинэ загвар гарчихсан байдаг. Түүн шиг л бид 40-50 жил ашигласан станцуудаа энд тэнд нь засаад, хэсэгчлэн засварлаад зүтгүүлээд байгаа юм. Станцуудаас хамгийн “залуухан” нь болох 1984 онд ашиглалтад орсон ТЭЦ-4 маань л гэхэд 27 дахь жилтэйгээ золгож байна.

Дэлхийн хөгжилтэй орнуудын туршлагаас үзэхэд цахилгаан станцыг 30 орчим жил ашиглаад л дараагийн үеийн шинэ техник, технологи нэвтрүүлээд явчихдаг юм билээ. Манай орны хувьд хөрөнгө мөнгө, эдийн засгийн бололцоо талаасаа тийм боломж нь хараахан гарч ирэхгүй өнөөдөртэй золгож байгаа юм. Гэхдээ бид гар хумхин сууж байгаа юм биш ээ. Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн систем хөтөлбөрийн хүрээнд ч бид энэ асуудлыг сөхөн тавьж, тодорхой хийж байгаа зүйл ч цөөнгүй бий. Жишээлбэл, Дарханы дулааны цахилгаан станцыг 30 МВт-аар өргөтгөж байна, ТЭЦ 4-ийн 80 МВт-ын турбиныг манай үндэсний инженерүүд Харбины үйлдвэртэй хамтраад 100 МВт болгож, хоёр машин дээр буюу нийт 40 МВт-аар хүчин чадлыг нь нэмэгдүүлчихлээ. Нөгөө талаас “Энержи ресурс” компани Ухаа худагт 18



МВт-ын станц ашиглалтад оруулж байна, яваандаа хүчин чадлыг нь өргөтгөхөөр төлөвлөж байгаа юм билээ. Түүнчлэн Завхан, Говь-Алтайн хэрэглэгчдийг найдвартай эх үүсвэрт холбоно гэсэн Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн хүрээнд Могойн голын уурхайг түшиглэсэн станц барих шийдвэрийг яам, Засгийн газар гаргаад, концессын гэрээг баталгаажуулснаар 60 МВт нэмэгдэх нь тодорхой болж байна. Даланзадгадын станц гэж их тааруу ажилладаг, өвөлдөө нэлээд хүндрэл учруулдаг цахилгаан станцад гурван МВт-ын хүчин чадал бүхий шинэ блок барих, зуух турбины ажлыг энэ оноос эхэлж, намар гэхэд дуусгахаар ажиллаж байх жишээтэй. Ингээд яриад байвал эрчим хүчний салбар бүүр болохоо байчихсан ч юм биш, чадах чинээгээрээ хүчин чадлаа нэмэгдүүлээд, өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хаах талаар тодорхой ажлууд хийж байна. Энд усан цахилгаан станцуудын (УЦС) талаар ч мөн дурдах нь зүйтэй болов уу. Дөргөний 12 МВт-ын станц болон Тайширын 11 МВт-ын хүчин чадалтай станц ашиглалтад орж хэрэглэгчдээ эрчим хүчээр хангаад явж байна.

-Манай эрчим хүчний салбарт хувийн хэвшлийнхэн сүүлийн үед нэлээд орж ирэх тухай ярих болсон нь юутай холбоотой вэ?

-Ер нь эрчим хүчний салбарт хувийн хэвшлийн оролцоо одоо ч байгаа шүү дээ. Тухайлбал, “Дархан, Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ” компани 2003 онд хувьчлагдсан, мөн онд Шарын голын уурхай ч мөн онд хувьчлагдсан байгаа. Гэхдээ 2010 оны хоёрдугаар сард Концессын тухай хууль гарснаар эрчим хүчний салбар дахь хувийн хэвшлийн оролцоо нэмэгдэх, ялангуяа гадаад дотоодын хөрөнгө оруулагч нарыг дэмжих эрх

» зүйн нөхцөл бүрдсэн гэж ойлгож болно. Засгийн газраас баталсан концессын жагсаалтад эрчим хүчний холбогдолтой 16 объектыг хувийн хэвшилд шилжүүлнэ гэсэн чиглэл ч байгаа. Энэ асуудлын хүрээнд эхнээсээ Могойн голын станцын төсөл хэрэгжээд явж байх жишээтэй. Түүнчлэн ТЭЦ 5, Тавантолгойн станц зэрэг нь мөн концессын хуулийн дагуу хэрэгжих болов уу.

-Хувийн хэвшлийн оролцоо эрчим хүчний салбарт нэмэгдсэнээр олон давуу талтай гэж мэргэжилтнүүд ярьдаг. Энэ талаар тайлбарлахгүй юу?

-Үр ашиг, менежмент, боловсон хүчин, зардал талаасаа илүү хэмнэлттэй бодлого явагдана гэж ойлгож болно. Энэ нь эргээд өртөг зардлаа хэмнэхэд тодорхой хэмжээний хөшүүрэг болох учиртай. Ер нь Засгийн газрын нуруун дээрх ачаа, хүлээж байгаа хариуцлагын бололцоотой хэсгийг нь хувийн хэвшилд шилжүүлэх төрийн бодлого байгаа шүү дээ. Нөгөө талаас үүгээрээ хувийн хэвшлийнхэнд боломж олгож байгаа юм. Мэдээж хэрэглэгчдийг цахилгаан, дулаанаар хангах, дааруулчихгүй, байнгын гэрэл цахилгаантай байлгах ёстой гэдэг утгаараа эрчим хүчний салбарыг авъя гэсэн болгонд нь өгчихгүй. Мэргэжлийн чадавх, боловсон хүчин, техник технологи, хөрөнгө мөнгөний бололцоо, туршлага зэргийг нь харгалзан үзэх ёстой. Энэ асуудлыг Төрийн өмчийн хороо, яам, агентлаг болон холбогдох байгууллагууд хамжиж дэмжээд шийдэх болно. Ер нь бүх зүйлийг төрийн нуруун дээр байлгадгаа болихньзүйтэй. Гэхдээ стратегийн чухал ач холбогдолтой станцууд, дамжуулах шугамаа мэдээж төрийн мэдэлдээ авч үлдэнэ шүү дээ. Харин орон нутгийн чанартай, хэсэгчилсэндулаан, цахилгаанаар хангадаг зарим хуучирсан, эдийн засгийн хувьд үр ашиггүй, өртөг өндөртэй объектуудыг концессын дагуу хувийн хэвшилд шилжүүлэх бодлого барьж байгаа.

-Хувийн компаниуд энэ салбарт орж ирэхдээ нэлээд үлгэр дууриал үзүүлэх хандлагатай байна. “Энержи ресурс” л гэхэд цахилгаан

станцаа маш хурдан барихдаа говийн хөрсөнд таарсан дэвшилт технологи нэвтрүүлж байх жишээтэй. Шинэ технологи нэвтрүүлэх тал дээр төр яагаад хойрго байна вэ?

-Төр хойрго байна гэж хэлж болохгүй л дээ. Хөрөнгө мөнгөний бололцоо, нөхцөл нь бүрдэнэ гэж ярьдаг шүү дээ. Тэр боломж нь гарч ирэхгүй байна. 100 МВт-ын цахилгаан станц барихын тулд 100-150 сая ам.доллар хэрэгтэй байлаа гэхэд тэр хөрөнгө нь тухайн үед манай улсын эдийн засаг, Засгийн газруудын бололцоонд байгаагүй. Мэдээж XXI зуунд эрчим хүчний салбарт шинэ шинэ технологиуд гарч байна. Үр ашигтай, хэмнэлттэй, ус бага зарцуулдаг, цөөхөн боловсон хүчин ажилладаг, өндөр хүчин чадалтай станцууд баригдаж байна. БНСУ, Хятад, Япон зэрэг оронд очоод харахад манай ТЭЦ-4 шиг 600-1200 МВт-ын хүчин чадалтай станцад нь 200 орчим хүн л ажиллаж байх жишээтэй. Гэтэл манай ТЭЦ 4-т одоо 1400 хүн ажиллаж байна. Өөрөөр хэлбэл, шинэ техник, технологийн үр шимээр ажилчдын цалин, нийгмийн асуудал зэргээс эхлээд олон зардлаа нэлээд хэмнэж байна гэсэн үг. Одоо бид ТЭЦ 4 станцад 200 хүн ажиллуулна гэвэл бүтэхгүй зүйл ш дээ. Технологи, горим нь ч болохгүй. Гэхдээ бид алхам алхамаар боломжоо дайчлаад, тэр үр ашигтай, хэмнэлттэй эх үүсвэрийг барих зорилго өвөртөлж явах ёстой. Бидний өнөөдөр

хийж байгаа ажлууд, “Монголын эрчим хүч 2011” чуулга уулзалтын бодлогыг ч мөн тийш нь хандуулах чиглэлд явж байна. Товчхондоо, хуучин технологи маань хийдгээ хийгээд, ашиглах боломжоо дээд хэмжээгээр ашиглачихжээ. Үүнийгээ боломжоор нь үргэлжлүүлэхийн зэрэгцээ шинэ технологи нэвтрүүлэх тал дээр анхааръя, байгаль орчин, үр ашгаа ч бодъё гэдэгт л анхаарлаа хандуулах үүднээс энэ хурлыг зохион байгуулж байгаа юм.

-Одоо бид үсрэнгүй хөгжлийн гараан дээр байна, их бүтээн байгуулалтын шан татлаа гээд л том том яриад байгаа. Уул уурхайн нүсэр төслүүд, 100 мянган айлын орон сууц хөтөлбөр хэрэгжиж эхэлж байна. Гэтэл тоггүй, галгүй бол энэ бүхэн яаж урагшлах юм бэ?

-ТЭЦ-5 станцын талаар үнэндээ 2004 оноос л ярьж эхэлсэн. Гэхдээ миний өмнө нь хэлсэнчлэн Засгийн газруудын хөрөнгө мөнгөний бололцоо, яг энэ станцыг барих хэрэгцээ, шаардлага тулгамдаж байна уу гэдэгт хандаж байгаа хандлага зэргээс шалтгаалаад өнөөдрийг хүрсэн болов уу. 2008 онд ТЭЦ 5-ын төслөөр тендер зарласан боловч ганцхан компани оролцсон, тэр нь шаардлага хангаагүй баримт бүрдүүлсэн учир хүчингүй болсон. Энэ төслийн ТЭЗҮ-ийг ч хийгээгүй байсан болохоор оролцож байгаа компани нь тодорхой юм олж харж, баримжаа авч чадахгүй байжээ.

Нөгөө талаас Монголд эрчим



» хүчний үнэ тариф дэлхийн дунджаас бага. Хөрөнгө оруулагч мөнгөө зарцуулчихаад буцааж авах боломж нь хангагдахгүй байсан гэж зарим нь ярьж байсан. Тиймээс үнэ тарифыг үе шаттайгаар нэмэх замаар хөрөнгө оруулагчдыг татах нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай болж байгаа юм.

Хэрэглээний өсөлтийн хувьд 2008 оноос л илүү мэдрэгдэж байна шүү дээ. Оюутолгойн гэрээ байгуулагдсанаар л тэнд 280 МВт-ын эрчим хүч зайлшгүй авна гэдэг нь тодорхой болж байна. Түүнээс биш өмнө нь хэрэглээ ингэж огцом өсдөггүй, жилдээ гурав орчим хувиар л нэмэгддэг байсан. Тэрийг нь өнөөгийн суурилагдсан хүчин чадал маань бүрэн хаагаад явж байлаа. 100 мянган айлын орон сууц хөтөлбөр ч сүүлийн хоёр жилийн хугацаанд л эрчимтэй яригдах болсон. Өмнө нь 40 мянган айлын орон сууц хөтөлбөрийн хэрэгцээг суурилагдсан эрчим хүчээрээ хаагаад явах бололцоо байсан. Гэхдээ энэ нь ирээдүй рүү чиглэсэн шинэ эх үүсвэрийн асуудлыг огт бодохгүй байсан гэсэн үг биш л дээ.

ТЭЦ 5-ыг 2020 он хүртэл хойш тавьчихсан юм байхгүй. Энэ нь хоёр үе шаттайгаар хэрэгжих төсөл. Эхний үе шат нь бууруу 450 МВт цахилгаан, 600 орчим Гкал дулааныг 2015 оны түвшинд хангачихаар байгаа. 2020 онд хоёрдугаар үе шат нь дуусахад ТЭЦ 5 төсөл маань 820 МВт-ын хүчин чадалтай, 1100 Гкал-ын дулааны чадалтай станц болох юм.

-Одоогийн суурилагдсан хүчин чадлаар 100 мянган айлын орон сууц баригдахад яаж ийгээд дулаан, цахилгаанаар хангаж чадах уу?

-100 мянган айлын орон сууц хөтөлбөрийн хүрээнд бид Зам тээвэр, барилга хот байгуулалтын яам, Улаанбаатар хотын захиргаатай удаа дараа уулзаж ярьж байгаа. Дулааны хувьд шинэ хорооллуудыг яаж хангах вэ гэдэг дээр асуудал байгаа нь үнэн. Шинэ Яармаг хорооллын дулааны асуудлыг хэрхэн шийдэх талаар бид хувилбар судалж удахгүй шийднэ. Бусад нь бол тодорхой байдлаар болно гэсэн шийдэл гарсан. Цахилгааны хувьд Улаанбаатар хотын 110 кВ-ын кольцог шинээр

барих ёстой. Энэ хүрээнд 200-210 кВ-ын дэд станцууд мөн шинээр бий болох шаардлагатай. Үүний хөрөнгө мөнгөний асуудлыг Хөгжлийн банкны эх үүсвэрээс гаргана гэж Засгийн газар шийдэх шатандаа орчихсон явж байгаа. Тэгэх юм бол цахилгаан, дулааны асуудлыг 2015 онд ТЭЦ 5 ашиглалтад орох хүртэл болгочихно.

...2010 оны хоёрдугаар сард Концессын тухай хууль гарснаар эрчим хүчний салбар дахь хувийн хэвшлийн оролцоо нэмэгдэх, ялангуяа гадаад дотоодын хөрөнгө оруулагч нарыг дэмжих эрх зүйн нөхцөл бүрдсэн гэж ойлгож болно. Засгийн газраас баталсан концессын жагсаалтад эрчим хүчний холбогдолтой 16 объектыг хувийн хэвшилд шилжүүлнэ гэсэн чиглэл ч байгаа...

-Эрчим хүчний үнэ тарифыг төрөөс хянадаг шүү дээ. Манай хойд хөрш ч бас тэгэж байгаад үе шаттайгаар үнийг өсгөж, энэ оноос зах зээлийн зарчимд бүрэн шилжиж байна. УИХ-ын 72 дугаар тогтоолын хүрээнд Монгол Улс ч мөн эрчим хүчний үнийг чөлөөлөх тал руугаа явж байна гэж ойлгож болох уу?

-Мэдээж энэ нь нийгмийн асуудалтай салшгүй холбоотой, хэрэглэгчдэд дарамт учруулахгүй гэсэн үүднээс л Засгийн газар цахилгаан, дулааны үнийг огцом өсгөхгүй байлгах бодлогыг барьж байсан гэвэл үнэнд илүү дөхнө. Гэхдээ хэрэглэгчдэд нэг их дарамт учруулахгүйгээр, хажуугаар нь эрчим хүчний салбараа унагаачихгүйгээр

үүнийг яаж шийдэх вэ гэдэг асуудал яах аргагүй тулгамдажирсэн. Ингээд яам, манай салбараас гарсан УИХ-ын гишүүдийн дэмжлэгтэйгээр 2010 оны арванхоёрдугаар сард УИХ-ын 72 дугаар тогтоол гарсан байгаа. Энэ нь сард 150 кВт.ц хүртэл хэрэглээтэй айл өрхөд борлуулах цахилгааны үнийг зөвхөн индексжүүлсэн түвшинд үлдээж, харин үйлдвэр аж ахуйн нэгж зэрэг их хэрэглээтэй байгууллага болон айл өрхийн хувьд эрчим хүчний үнэ зах зээлийн шаардлагын дагуу үе шаттайгаар нэмэгдэх хэлбэрээр зохицуулах шийдвэр юм л даа. 2014 он гэхэд ямар ч байсан эрчим хүчний салбар алдагдалгүй ажиллах боломж, нөхцөлийг бий болгох түвшинд хүрсэн байна гэж ойлгох нь зүйтэй болов уу.

-Байгаль орчинд хал багатай гэдэг утгаар нь сэргээгдэх эрчим хүчийг дэлхийн улс орнууд нэлээд дэмжиж, хөгжүүлж байгаа. Монгол Улс энэ тал дээр ямар бодлого барьж байгаа вэ?

-Сэргээгдэх эрчим хүчний үндэсний хөтөлбөр гэж бий. Мөн Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийг 2007 онд баталсан. Энэ хүрээнд Дөргөн, Тайширын УЦС-ыг байгуулсан. Өнөөдөр 10 орчим сум сэргээгдэх эрчим хүчээр цахилгааны хэрэгцээгээ хангаж байна. 2007 онд шууд гэрээгээр хийсэн сэргээгдэх эрчим хүчний зарим ажилд мэргэжлийн бус компаниудад энэ ажлыг даалгаснаар бизнесийн зориулалтаар хямд, чанаргүй тоноглол авчирч суурилуулсан, тэр нь хүчин чадлаараа ажиллахгүй байх тохиолдол олон гарсан. Монголын эрс тэс уур амьсгалд нийцэхгүй, нөгөө талааст технологийн шаардлага хангахгүй тэдгээр объект байнга эвдэрч, хүмүүс, ялангуяа хөдөө орон нутгийн иргэдийн дунд сэргээгдэх эрчим хүч гэж бүтэхгүй юм байдаг гэх буруу ойлголт түгээсэн. УИХ-ын зарим гишүүн ч тийм юм яриад явж байх жишээтэй. Энэ нь сэргээгдэх эрчим хүчний талаар сөрөг ойлголтыг нийгэмд түгээж байгаа юм. Гэтэл амьдрал дээр эсрэгээрээ. Мэргэжлийн чадвартай компани, мэргэжилтнүүд зөв тооцоо судалгаанд суурилан хийх юм бол энэ чинь баталгаатай, ямар ч ашиглалтын үеийн зардалгүй, байгаль орчинд халгүй, үр ашигтай

► эрчим хүчний эх үүсвэр. Дизель түлш, нүүрс, хий зэрэг зардал шаардлагагүйн зэрэгцээ боловсон хүчин талаасаа ч байнга хүн ажиллаад байхгүйсэнталтай. Тийм ч учраас сэргээгдэх эрчим хүч гэдэг нь дэлхий нийтийн эрчим хүчний хөгжлийн нэг чиг хандлага болоод байна. Олон улсын сэргээгдэх эрчим хүчний ассоциаци өнгөрсөн онд байгуулагдан ажиллаж эхэлсэн бөгөөд 100 гаруй орон гишүүнээр орсон байдаг. Монгол Улс тэр байгууллагыг Парламентаараа дэмжсэн эхний 20 гишүүн орны нэг нь.

-Эрчим хүчний салбарын ажилчид уул уурхай руу олноороо “урваад” байна гэх юм. Онцгой салбар гэдэг утгаараа ажилчдын нийгмийн хангамжийн тал дээр яамнаас ямар бодлого барьж байгаа вэ?

-Тийм байдал үүссэн нь бодитой зүйл. Зарим станцын дарга нар Манай хамаг сайн инженерүүд Өмнөговь руу явчихлаа. Сайн гагнуурчин, цахилгаанчин, инженерүүдэд өндөр цалин амлаад, тэднийг урвууллаа гээд л байгаа. Тэр хүмүүс сонголтоо хийгээд явж байгааг бид хуулиар хориглож болохгүй шүү дээ. Гэхдээ ер нь өөрсдөө бэлдсэн чадварлаг ажилтан, инженер техникийн мэргэжилтнүүдээ алдахгүйн тулд нөгөө талаас онцгой салбар гэдэг утгаараа хүмүүстээ цалинг нь боломжийн хэмжээнд өгч, нийгмийн асуудлыг нь ч анхаарах хэрэгтэй байгаа. Эрчим хүчний үнэ, тарифын өсөлттэй уялдуулж л цалинг өсгөхгүй бол өөр боломж бидэнд алга байна. Салбарын ажилчдын дундаж цалинг үе шаттайгаар өсгөж, уул уурхайн салбарынхны хэмжээнд дөхүүлье гэсэн бодлого яаман дээр байгаа, “хөнжлийнхөө хэрээр хөлөө жий” гэдэгчлэн боломжоороо л шийдвэрлээд байгаа. 2014 он гэхэд гайгүй болох болов уу л гэж найдаж байна.

-Засгийн газар эрчим хүчний компаниудад татаас өгч эхэлсэн. Тэгэхээр салбарын өрийн дарамт буурч байна уу?

-Салбарын эдийн засгийн асуудлыг харахад нааштай зүйл гарч байгаа. 2009 онд салбар 60 гаруй тэрбум төгрөгийн өртэй байсан бол 2010 онд 20 гаруй тэрбум болж буурсан. Энд Засгийн

Концессын анхны төслийг хэрэгжүүлэхээр боллоо



Завхан аймгийн Тэлмэн сумын нутагт Могойн голын н□□рсний ордыг т□шиглэн, дулааны цахилгаан станц барих концессын гэрээнд Т□рийн □мчийн хорооны дарга Д.Сугар, “Шинэ Азия майнинг” ХХК-ийн захирал Л.Т□рбаяр нар гарын □сэг зурлаа. Энэх□□ гэрээ нь Концессын тухай хуулийн дагуу хийж байгаа анхны гэрээ б□г□д концессын барих-ашиглах- шилж□□лэх т□рл□□р 22 жилийн хугацаатай байгуулжээ. Дулааны станцыг хоёр жилийн дотор барьж байгуулна, харин 20 жилийн хугацаанд ашиглаж □йл ажиллагаа явуулах эрх олгожээ.

Гэрээний хугацаа дуусахад дулааны цахилгаан станцыг т□рийн □мчид □нэ т□лб□рг□йгээр шилж□□лэх н□хц□лтэй. М□н энэ хугацаанд улсын т□св□□с санх□□гийн дэмжлэг, баталгаа гаргах□й, концесс эзэмшигчээс нийт 110 сая ам.долларын х□р□нг□ оруулалт шаардагдах б□г□д ашиглалт, □йл ажиллагаанаас гарах эрсдэлийг концесс эзэмшигч □□р□□ б□рэн хариуцааж. Тус дулааны цахилгаан станц нь эрчим х□чний салбарт анх удаа хувийн хэвшлийн х□р□нг□ оруулалтаар хийгдэж буй томоохон т□с□л гэдгээрээ онцлог б□г□д □йлдвэрлэсэн эрчим х□чээ Монгол Улсын Эрчим х□чний тухай хуулинд заасны дагуу зохицуулалттай □нээр орон нутгийн хэрэглэгчдэд х□ргэхээр т□л□вл□жээ.

Энэх□□ дулааны цахилгаан станц ашиглалтад орсноор 300 орчим ажлын байр шинээр бий болж, Могойн голын н□□рсний уурхайн борлуулалт жилд 15,000 тн байсан бол 200,000 тн болж нэмэгдэн, дэд б□тэц сул х□гжс□н Завхан, Говь-Алтай аймгийн хэрэглэгчдийг цахилгаан эрчим х□чний найдвартай эх □□свэрээр хангах боломжтой болж байна.

газраас эрчим хүчний компаниудад 15 тэрбум төгрөгийн татаас өгсөн нь үүргээ гүйцэтгэсэн гэж ойлгож болно. Нөгөө талаас манай зарим компанийн удирдлага ч гэсэн үр ашиг, хэмнэлт талаасаа дажгүй сайн менежмент хийж ажиллаж байгаа. Мөн Засгийн газрын 284 дүгээр тогтоолын хүрээнд салбарын компаниудын зээлийн хүүг бууруулж, төлөх хугацааг хойшлуулж компаниудад очиж байгаа өрийн

дарамтыг багасгасан. Энэ нь эдийн засгийн утгаараа нааштай үр дүн өгч байгааг тэмдэглэх хэрэгтэй.

-Эрчим хүчний нэгдсэн хөтөлбөрийн үр дүн ямаршуу байгаа вэ?

-2002 онд анх батлагдсан Эрчим хүчний нэгдсэн хөтөлбөрийг таван жилийн дараа буюу 2007 онд тодотгож, шинэчилсэн. Манай орны нийгмийн амьдрал эрчимтэй хөгжиж энэ хөтөлбөрийг дахин шинэчлэх

» шаардлагыг бий болгож байна. Дахиад таван жилийн дараа буюу энэ онд хөтөлбөрийг тодотгохоор бид ажиллаж байна. Ер нь энэ хөтөлбөр амжилттай хэрэгжиж, бодитой үйл хэрэг болох бодлогын бичиг баримт болсон гэж бид үздэг. Сүүлийн 10 жилийн хугацаанд олон ажил хийлээ шүү дээ. Салбарт бүтцийн өөрчлөлт амжилттай хэрэгжлээ. Бүх аймгийн төв эрчим хүчинд холбогдлоо, дээр нь манай бүх сум ямар нэгэн байдлаар эрчим хүчний эх үүсвэртэй боллоо. Энэ чинь нийгмийн өмнө бидний хийсэн том ажил. 1990 онд Монгол Улсын 86 сум л эрчим хүчтэй байсан, тэгвэл одоо 333 сум бүгд цахилгаанжуулалтаа шийдсэн байна.

-10 жилийн дараах эрчим хүчний салбарыг Та хэрхэн харж байгаа вэ?

-2021 онд эрчим хүчний салбар сайхан болсон байна гэж өөдрөгөөр хэлэх байна. Мэдээж ТЭЦ 5 маань бүрэн хүчин чадлаараа ажиллаад

эхэлчихсэн, Тавантолгойн станц ч мөн ашиглалтад орчихсон, говийн бүс нутгийн цахилгааны хангамжийг хийж байна. Зүүн бүсэд 200 орчим МВт-ын чадал нэмэгдчихсэн, бүсийн хэрэглэгчдээ бүрэн хангаад, цаашаа экспортод гаргах боломж бүрдчихсэн байна гэж найдаж байгаа. Баруун бүсэд Хөшөөтийн болон Хотгорын уурхайг түшиглэсэн станц баригдаад, энэ бүс нутаг импортоор цахилгаан эрчим хүч авдаг биш, харин Хятадын Шиньжан, эсвэр Тува тал руу эрчим хүч экспортолдог болчих болов уу. Говийн бүс мэдээж уул уурхайн үйлдвэрлэлийн оргил үедээ очих байх. Тэр хэрэглээг нь бүрэн хангаад, Улаанбаатар хот, баруун, зүүн бүс болон говийн бүс нутаг өндөр хүчдэлийн шугамаар холбогдсон, Эрчим хүчний бүрэн хэмжээний нэгдсэн систем үүссэн дүр зураг нүдэнд харагдаж байна.

Дээрээс нь сэргээгдэх эрчим хүчний томоохон объектууд ч ашиглалтад орно. 2013 оноос

“Ньюком” компанийн 50 МВт-ын салхин цахилгаан станц ажиллаж эхэлнэ. Сайншандад мөн л 50 МВт-ын станц ашиглалтад удалгүй орчих байх. Ер нь 2021 он гэхэд эрчим хүчний салбар шинэ үе шатандаа гарчихсан, үр ашигтай, шинэ техник технологи бүхий салбар болсон байна гэдэгт итгэлтэй байна. Тэгээд ч Монгол Улс эрчим хүч импортолдог биш, экспортолдог орон болчихсон байна. Эрчим хүчний салбар маань татаас авч амь зогоодог биш, улсын төсвийн орлогын нэлээд хэсгийг бүрдүүлдэг томоохон татвар төлөгч салбар болно гэдэгт итгэдэг. Мэдээж боловсон хүчин нь өндөр боловсролтой, орчин үеийн техник, технологийн нарийн горим, шийдэл бүхий станцуудыг ажиллуулдаг тийм л салбар болчихсон байх болов уу. Түүнчлэн манай орны хөгжил, иргэдийн амьжиргааны нөхцөл улс орны эдийн засгийн хөгжил, уул уурхайн эрчимжилтээ дагаад эрс сайжирч шинэ шатанд гарсан байна гэдэгт эргэлзэхгүй байна. ■



Станц

Шинэ хөгжил- ДЦС-5

Эрчим хүчний шинэ эх үүсвэрийг барихын төлөө төрийн түшээд за гэж хэлэхгүй гээд яах юм бэ. Улс орны хөгжил, цаг үе шаардаж байна шүү дээ. Эхнээсээ ч за хэмээн дуу нэгтэй дуугарч эхлээд байгаа. Харин ч нэлээд удаж байж дуугарч байгаа юм. Үүнд учир шалтгаан бий. Олон жил дуншсан Оюу толгойн төсөл шиг л нэлээд хэдэн жилийн нүүр үзэж байгаа нь үнэн л дээ. 2005 оноос хойш л эрчим хүчний шинэ эх үүсвэрийн тухай ярьж, асуудлыг судалж, шинжилсээр өнөөдрийг хүрсэн билээ. Анхлан тавдугаар дулааны станцыг Улаанбаатар хотын зүүн зүгт буюу Улайстайд барихаар төлөвлөж байсан бөгөөд энэ байрлал нь газрын цэвдэгтэй, нийслэлийн агаарын бохирдлыг улам ихэсгэнэ, усан хангамжид сөрөг нөлөө үзүүлнэ гэсэн мэргэжлийн байгууллагуудын дүгнэлт гарч, өөр газар хайхад хүргэсэн юм. Дараа нь Хонхорын радио станцын орчим байрлалын хувьд Богд ууланд ойрхон тул хотын хориотой бүсэд орно, дулааны шугам сүлжээ хэт алслагдаж 27- 28 км орчим болно, газрын өндөрлөг нь даваа гүвээтэй, хотын түвшингээс 100 орчим метр өндөр байгаа нь дулааны шугам сүлжээний усны эргэлтэд хүндрэл учруулна гэсэн дүгнэлт хийжээ. Энэ мэтчилэн газрууд үзэж судалснаар эцэст Гуравдугаар дулааны цахилгаан станцын суурь баазыг өргөтгөх замаар эрчим хүчний шинэ эх үүсвэрийг барихаар нэгэнтээ шийдвэрлэсэн байна.

Ямар станц байх вэ?

Дулааны чадал нь 1101 Гкал/ц, цахилгааны чадал нь 820 МВт-ын эрчим хүч үйлдвэрлэх хүчин чадалтай томоохон хэмжээний барилга байгууламжийг 2020 он гэхэд бүрэн хүчин чадлаар нь ашиглалтад оруулах аж. Сүүлийн 20-иод жилд ийм хэмжээний бүтээн байгуулалтын ажил монголчууд бид хийгээгүй гэлцдэг. Жилдээ 2,5-3,6 сая тонн нүүрс түлж, одоогийнхоос хоёр дахин илүү цахилгаан, дулаан үйлдвэрлэх юм байна. Мөн технологийн зуунд сүндэрлэх станц гэдэг утгаар мэдээж байгаль орчинд хал багатай байхаас гадна



нүүрснээс ялгарах утааг 100 хувь цэвэршүүлж, үнсийг 99,8 хувь шүүж, барилгын материалд ашиглахаар төлөвлөжээ. Шинэхэн станцын нүүрсний 70 хувийг Шивээ-Овоо, үлдэх 30 хувийг Багануурын уурхайгаас хангахаар төлөвлөж байна. Тэгвэл манай улсын өнөөгийн эрчим хүчний суурилагдсан чадал 850 МВт бөгөөд жилдээ 5-6 сая орчим тонн нүүрс түлж байгаа аж. Тэгэхлээр нүд ирмэхийн зуур өөрчлөгдөн хувьсаж буй дэлхийн хөгжилтэй зэрэгцэх тухай ярихгүй юмаа гэхэд тэртээ алсад хоцорчихгүйн тулд нэгэнтээ цаасан дээр буулгаад засаг төрөөрөө батлуулаад авсан юм хойно их бүтээн байгуулалтын ажилдаа ханцуй шамлан орох ёстой.

Энэхүү төслийг хоёр үе шаттай хэрэгжүүлнэ. 2015 он хүртэлх үе шатанд 450 МВт-ын чадалтай эхний барилга байгууламжийг барьж ашиглалтад оруулах юм. Хоёрдугаар шатанд 370 МВт-ын чадалтай байгууламжийг барих ажээ.

Яагаад ТЭЦ-3 гэж...

Яагаад болохгүй гэж. Харин ч азтай юмаа ТЭЦ-3-ынхан. Шинэ зууны их бүтээн байгуулалтын үндсэн бааз болох нь байна шүү дээ. Хоцрогдол, хөгшрөлтийн элэгдэлд орсон техник технологиудаа шинэчлээд

NEW COMBINED HEAT AND POWER PLANT IN ULAANBAAT



авах нь байна. Гэхдээ бүгдийг нэгэн зэрэг солих тухай биш шүү. 10-аад жилийн дараа гуравдугаар станц танигдахгүй болтлоо өөрчлөгдөнө гэдгийг л хэлж буй хэрэг.

Өнгөрсөн жилүүдэд 1995-1999 онд ДЦС-3-ын тоноглолын шинэчлэл буюу өндөр даралтын зуух, турбин болон дулааны сүлжээний гэсэн гурван үеэс бүрдсэн шинэчлэлийн их ажилд гадаадын зээл тусламжийн 48.8 сая долларыг зориулсан байна. Өндөр даралтын зуухны шинэчлэлийн 39.6 сая долларыг АХБ-ны хөнгөлттэй зээлээр, турбины шинэчлэлийн 5.8 сая долларыг Нордик-ын хөгжлийн сангаас, дулааны сүлжээний шинэчлэлийн 3.3 сая долларын Данида буцалтгүй тусламжаар санхүүжүүлсний хүчинд тус станц нь нийслэлийн тодорхой хэсгийг эрчим хүчээр найдвартай хангаж иржээ. Харин өдгөө дээрх шинэчилсэн технологиудын ашиглалтын хугацаа мөн л дуусаж, элэгдэлд ороод эхэлсэн байна. Тиймээс шинэхэн эх үүсвэрийг барьж байгуулах эдийн засгийн үр ашиг, ач холбогдол талаасаа ТЭЦ-3 байх хамгийн боломжтой гэсэн хувилбарыг гаргаж иржээ. ТЭЦ-3-ын бааз суурийг түшиглэх сонголт хийснээр 100 гаруй тэрбум төгрөг хэмнэх бололцоотой тухай Эрчим хүчний газрын дарга Ц.Баярбаатар ярьжээ.

Тендер хэзээ зарлах вэ?

Одоогоор тус төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг хийж дуусч, тендерийн бэтлгэлийн шатандаа явж байгаа аж. Шинэ эх үүсвэрийг барих, судалгаа шинжилгээ хийх зэрэг өнөөдрийг хүртэлх ажилд АХБ нэлээд хүч тавьж оролцож ирснийг энд онцлон тэмдэглэх нь зүйтэй. Тус банк нь төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд судалгаа шинжилгээний чиглэлээр тавдугаар цахилгаан станцын төслийг хэрэгжүүлэхэд хамтарч ажиллаж байгаа. АХБ нь төслийн зөвлөх компаниар АНУ-ын "H&J" компанийг шалгаруулан гэрээ байгуулж, техник эдийн засгийн үндэслэлийн судалгааг хийлгэж байна. ТЭЗҮ-г дууссаны Төрийн өмчийн хорооны зүгээс концессын төрлийг сонгон, тендерийн бичиг баримт бэлтгэх, уралдаант шалгаруулалтыг зарлах, явуулах, ирүүлсэн тендерүүдийг үнэлэх, тендерт шалгарсан компанитай концессын гэрээний хэлэлцээрийг хийх, улмаар барилга угсралтын ажлыг эхлүүлэх зэрэг олон ажил хийхээр төлөвлөжээ. Энэ удаад хөрөнгө оруулагчдад ойлгомжтой, ашигтай, нээлттэй маш сайн тендерийн санал боловсруулах нь ойлгомжтой. Учир нь ДЦС-5 төслийн анхны тендерийг 2008 онд тухайн үеийн Түлш эрчим хүчний яам боловсруулан зарлаж, 26 оролцогчид тендерийн материалыг сонирхон авснаас ганцхан БНХАУ-ын China Datang Corporation компани л тендер оролцох саналаа ирүүлсэн гэдэг. Гэвч тус компанийн санхүүгийн санал шаардлага хангаагүйгээс энэхүү тендер цуцлагдаж нөхцөл шаардлагыг тодорхой болгон хоёр дахиа зарлах дээрх их ажлын эхлэл тавигдсан байна. 10 жилийн хугацаанд барих энэхүү барилга байгууламж зөвлөх компанийн тойм тооцоогоор нийтдээ 1.4 тэрбум ам.долларын өртгөөр босохоор байгаа. Зөвлөх компанийн зүгээс санхүүжүүлтийн хэлбэрийн хувьд АХБ болон эсвэл бусад донорын хамтарсан санхүүжилттэй, эсвэл бүхэлдээ Засгийн газрын санхүүжилт бүхий төрийн хэвшлийн, нөгөө талаас төр, хувийн хэвшлийн түншлэлийн болон арилжааны төсөл ч байж болохыг судалгааныхаа хүрээнд зөвлөжээ. Мөн тэд АХБ болон доноруудын хөнгөлөлттэй зээлийн санхүүжилт нь хамгийн хямд хөрөнгө оруулалт байх ба энэ нь капиталын хамгийн бага өртөг, хамгийн бага тарифаар илэрхийлэгдэж байгааг судалгаандаа дурдаад харин хувийн хөрөнгө оруулалт болон арилжааны зээлээр санхүүжих төр, хувийн хэвшлийн хувилбарт төслийн өртөг нэмэгдэнэ гэдгийг онцлон тэмдэглэсэн байна. Тэгэхээр энэ төслийг санхүүжилтийн ямар хэлбэрийг сонгож ажиллах үүрэг хариуцлага Төрийн өмчийн хороонд ногдож байна. Ямартаа ч шинэ эх үүсвэрийг барих асуудал цаасан дээр бууж, төрийн бүх шатны хурлаар орж, дэмжигдлээ. Одоо тендер зарлаж, хөрөнгө оруулагчтай гэрээ байгуулж, эхний шатны ажлыг эхлүүлэх л үлдлээ. ■

Өрийн сүлжээнээс гарч, гялалзаж явах цаг ойртжээ

Гэрээс гарахдаа гэрлээ асаалттай орхидог, зурагтаа унтраалгүй зүйрмэглэсээр дуг хийчихдэг хүн Улаанбаатарт цөөнгүй бий. Харин хөгжилтэй орнуудын иргэдийн хувьд эрчим хүчний хэмнэлт гэх ойлголт яс маханд нь шингэчихсэн байдаг юм билээ. Бусад улстай харьцуулахад нэлээд хямд үнээр дулаан, цахилгааны асуудлаа шийдчихдэг монголчууд маань эрчим хүчний хямралдорж, хоолгүй хонох аюулын ирмэгт тун ч ойрхон тулж ирснээ мэдэрсэн болов уу? Аз болж төр, засаг эрчим хүчний салбараа өөд нь татах шийдвэр гаргаснаар бид энэхүү аюулыг дайрч биш, тойрч гарах бололтой.

Нэг кВт.ц цахилгааныг 36.6 центээр авдаг Дани, 28.4 центээр авдаг Итали зэрэг өндөр хөгжилтэй оронтой өөрсдийгөө зүйрлэхээ больё. Гэтэл Камбож, Филиппин зэрэг оронд хүртэл нэг кВт.ц цахилгааны үнэ 10 центээс давчихсан явж байна шүү дээ. Харин Монголд энэ тавдугаар сарын 1-нээс айл өрхөд борлуулах цахилгааны үнийг нэмээд нэмээд 74-84 төгрөгт (ойролцоогоор долоон центэд) л хүрч байгааг сануулах юун. Бид дэлхийн бусад оронтой харьцуулахад хамаагүй хямд үнээр цахилгаан авч байгаагаараа азтай улс.

Бусад орон эрчим хүчний салбараа үр ашигтай, хэмнэлттэй дэвшилт технологиор тордож, хажуугаар нь байгаль орчинд ээлтэй сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэхэд анхаарч байх зуур монголчууд аль социализмын үеийн “хөгшин” станцуудаа зүтгүүлсээр. Нөгөөдүүл нь өөрсдөө хүнд байдалд “аж төрөөд” зогсохгүй нүүрсний уурхайнуудаа хэцүүхэн нөхцөлд унагасаар өнөөдөртэй золгож буй. Нүүрсний уурхай болон эрчим


хүчний компани хоорондын өрийн сүлжээ аалзны тор шиг л эрчим хүчний салбарыг хэрж, хэдэн арван тэрбумаар тоологдох тоо тоймоо алдаж байсан нь саяхан. Яагаад ийм байдалд орсон юм бол оо?

Нэг кВт.ц цахилгааныг 115 төгрөгөөр борлуулж байж л алдагдалгүй ажиллах тооцоо гарчээ. Гэтэл өнөөдөр ийм өндөр өртөгтэй үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ айл өрхүүдэд 71-84 төгрөгөөр, аж ахуйн нэгжүүдэд 88, уул уурхайн компаниудад 100 төгрөгөөр зарж байгаа билээ. Хөдөө орон нутагт тухайлбал, Даланзадгадын дулааны цахилгаан станц нэг кВт.ц цахилгааныг 300 орчим төгрөгөөр үйлдвэрлээд, 79.8 төгрөгөөр зарж байх жишээтэй. Энэ бүх зөрүүг Засгийн газар татвар төлөгчдийн мөнгөнөөс буюу төсвийн хөрөнгөнөөс гаргаж өгсөөр байх гэж үү? Өнгөрсөн онд орон нутагт 19.6 тэрбум, төвийн бүсэд 15 тэрбум буюу нийт 34.6 тэрбум төгрөгийн татаас өгсөн байна шүү дээ. Ийнхүү урд хормойгоороо хойд хормойгоо нөхсөөр ирсний үр дүн юу байв?

Стратегийн ач холбогдол бүхий Багануур, Шивээ-Овоогийн нүүрсний уурхай 1990-ээд онд

Дэлхийн банк, Японы Засгийн газраас авсан хөнгөлөлттэй зээлийн хүүгээ ч төлж чадахгүйд хүрч сууна. Эрчим хүчний нүүрсний 80 гаруй хувийг залгуулдаг төрийн эзэмшлийн дээрх хоёр уурхайн өр шир үндсэн хөрөнгөөс нь хүртэл халиад алга болжээ. Яагаад гэхээр тэртэй тэргүй алдагдалтай ажилладаг дулааны цахилгаан станцууд нь авсан нүүрснийхээ мөнгийг ч төлж дийлэхгүй “луу унждаг”-ын зэрэгцээ нүүрсний үнийг ч мөн засгаас тодорхойлсоор ирсэн ажгуу.

Нэг тонн нүүрсний өртөг 21248 төгрөг байхад 18200 төгрөгөөр л борлуулж байгаагаа “Багануур” ХК-ийн удирдлага онцолж байсан. Өөрөөр хэлбэл, нэг тонн нүүрсийг ухаж гаргах зардал нь борлуулж буй үнээсээ 3048 төгрөгөөр дээгүүр цохиж явна. “Манай техник, тоног төхөөрөмжийн 80 гаруй хувийнх нь ашиглалтын хугацаа дуусч, эвдрэл гэмтэл их гарах боллоо. Нүүрсээ байнга өртгөөс нь бага үнээр борлуулж байснаас хуримтлагдсан алдагдал 41.6 тэрбум төгрөгт хүрсэн. Энэ байдлаар цаашид үйлдвэрлэлийг хэвийн явуулах, цахилгаан станцуудыг нүүрсээр найдвартай



Эх сурвалж: ЭХЗГ-аас гаргасан “Эрчим хүчний статистик үзүүлэлтүүд 2010” эмхтгэл

» хангах ямар ч боломжгүй” хэмээн “Багануур” ХК-ийн гүйцэтгэх захирал Д.Дамбаэлжээ саяхан үнэ нэмэхээс өмнө мэдэгдсэн юм.

Зах зээлийн эрэлт, нийлүүлэлтээр үнэ тогтох учиртай байтал засгаас нүүрс, эрчим хүчний үнийг барьж ирсний “ачаар” дулааны станцууд хамгийн хямд нүүрсээр “гал гаргаж”, иргэд хамгийн хямд үнээр зурагтаа үзэж суухдаа цахилгааны үнийг ялимгүй нэмж байгааг сонсоод дургүй нь хүрч байсан биз ээ.

Бодоод үзье. Өнөөдөр бидний гар утсаараа нэг минут ярих өртөг 50-100 төгрөг шүү дээ. Гэтэл утасны мөнгө, нэгж, интернэтийн төлбөрт гар татаад байдаг хүн бараг үгүй ээ. Тэр хэрээр үүрэн холбоо, мэдээллийн технологийн үйлчилгээ асар богино хугацаанд хөгжин цэцэглэж, Монголын уудам газар нутгийг хэрэхдээ хөдөөгийн ганц сумыг ч үлдээлгүй амжилттай нэвтэрч байгаа нь ойлгомжтой. Харин нэг кВт.ц цахилгааныг айл өрхүүд 71-84 төгрөгөөр л худалдаж авч буй. Зүсэм талх, хэрчим мах ч авч хүрэхээргүй энэ мөнгөөр бид бүтэн өдөр зурагт үзэж болох юм билээ. Ингээд биднийг бага мөнгөөр дулаан оромжтой, халуун хоолтой байлгаж буй төр, засагтаа талархаад өнгөрөх үү? Гэтэл бид сар бүр цахилгаан, дулаандаа төлөх тав, арван төгрөгөөсөө ч илүү ихийг алдаж байгаагаа ухамсарлахгүй л явна шүү дээ.

Дулааны станцууд нь уурхайдаа өрийн данстай, нүүрсний уурхайнууд нь хил гаталсан өрийн данстай учир техник, технологийн шинэчлэл гэдгийг өнгөрсөн хэдэн жилд таг мартсан билээ. Үүний “үр дүнд” 2000 онд төвийн эрчим хүчний системийн цахилгааны хязгаарлалын тоо 12 байсан бол 2010 онд энэ үзүүлэлт 238 болж, бараг 20 дахин нэмэгджээ. Он жил улирах тусам сайжирч байх ёстой атал манай эрчим хүчний салбар өдрөөс өдөрт доройтсоор ирсэн нь



ийм учиртай. Ийм нөхцөлд хөгжил, дэвшил ярих нь бүтэшгүй хэрэг бус уу?

Өнөөдөр бид 100 мянган айлын орон сууц бариад сайхан амьдарна, хот хүрээгээ тэлнэ хэмээн хөөрцөглөж байна. Гэтэл өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хаахын тулд өгөрч хуучирсан дулааны цахилгаан станцууд маань эцсийн хүчээ шавхан зүтгэнэ. Эрчим хүчний шинэ эх үүсвэртэй болж, 40-50 жил ашигласан дулааны станцуудаа амраах цаг ирлээ гэж яриад 10-аад жил боллоо. Харамсалтай нь 100 МВт-ын цахилгаан станц барихын тулд 100-150 сая ам.доллар хэрэгтэй болдог бөгөөд томоохон эх үүсвэр бариад ашиглалтад оруулъя гэсэн санаа байвч сачий хүрэхгүй өдий хүрэв. Аргагүй шүү дээ. Өртгөөсөө доогуур үнэтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэж борлуулдаг алдагдалтай салбарт хөрөнгө оруулах “тэнэг толгой” хайж олоход бэрх буюу. Зах зээлийн нийгэмд өртгөө ч нөхөхгүй бүтээгдэхүүн үйлдвэрлээд байдаг компаниуд эрчим хүчний салбараас өөр хаана ч байхгүй биз ээ.

Уг нь бид эрчим хүчний салбараа эрүүлжүүлээд авах юм бол татаас авч амь зогоодог биш, төсвийн орлогын нэлээд хэсгийг бүрдүүлээд байж чадах гэгээтэй ирээдүй харагддаг гэсэн шүү. Тооцоолоод үзье. 2010 онд

л гэхэд эрчим хүчний томоохон компаниудын төлсөн НӨАТ, ААНБ-ын орлогын албан татвар, Нийгмийн даатгалын шимтгэл 66 тэрбум төгрөгөөс давж байна. Стратегийн ач холбогдол бүхий томоохон уурхайнууд ашиглалтад орж, уул уурхай цэцэглэн хөгжиж буй өнөө үед бид эрчим хүчний салбараа тордоод авах юм бол тэрбум тэрбумаар нь орлого олж, төсвийн түрийвч түнтийх боломж бий ажээ. Гэхдээ эрчим хүчний салбараа алдагдалтай биш, ашигтай ажиллах нөхцөлийг бүрдүүлж байж л бид хөрөнгө оруулагчдыг татаж чадна. Нөгөө талаас уул уурхайн компаниудад өртгөөсөө доогуур биш, дээгүүр үнээр цахилгаан зарж байж л ашиг олох бус уу?

Энэбүхнийгтөр, засгийн эрхмүүд ойлгож, эрчим хүчний салбараа дэмжиж эхэлсэн нь сайшаалтай. 2010 оны арванхоёрдугаар сарын 9-нд “Түлш, эрчим хүчний салбарын талаар авах зарим арга хэмжээний тухай” УИХ-ын 72-дугаар тогтоол гарснаар эрчим хүчний салбарын хүмүүсийн нүүрэнд инээмсэглэл тодорч, нүдэнд нь оч гэрэлтэх болжээ. Дээрх бичиг баримтын хүрээнд нүүрсний болон эрчим хүчний үнийг 2014 он хүртэл үе шаттайгаар нэмэгдүүлэх боломж бүрдсэн юм. Гэхдээ нийгмийн эмзэг бүлгийнхэнд ирэх дарамтыг багасгах чиглэлийг УИХ тогтоолдоо оруулахаа мартсангүй. Сард 150 кВт.ц хүртэлх цахилгааны хэрэглээтэй айл өрхийн цахилгааныг 2014 он хүртэл одоогийн мөрдөх үнээр нь үргэлжлүүлж олгох билээ. Манай эрчим хүчний салбарын нийт орлогын 20 хувийг айл

НҮҮРСНИЙ ТОМООХОН УУРХАЙНУУДЫН НҮҮРСНИЙ ҮНИЙН ӨСӨЛТ (НӨАТ-ГҮЙ) ТӨГРӨГ/ТОНН

| | 2000 | 2001 | 2002 | 2003 | 2004/1 сар | 2004/11 сар | 2005 | 2006 | 2007/10 сар | 2007/11 сар | 2008 | 2009 | 2010/10 сар | 2010/11 сар |
|--------------|------|------|-------|-------|------------|-------------|--------|-------|-------------|-------------|-------|-------|-------------|-------------|
| Багануур | 8050 | 9000 | 9250 | 9250 | 9250 | 10730 | 11500 | 11500 | 12500 | 12500 | 16200 | 16200 | 18200 | 18200 |
| Шарын гол | 8500 | 9500 | 10000 | 10000 | 10000 | 12000 | 13600 | 13600 | 14600 | 16600 | 21400 | 21400 | 22680 | 26275 |
| Шивээ овоо | 5500 | 5800 | 5800 | 5800 | 6000 | 7200 | 7500 | 7500 | 8500 | 8500 | 11400 | 11400 | 13960 | 13960 |
| Таван толгой | 8000 | 8000 | 8000 | 8000 | 8000 | 8000 | 8000 | 8000 | 8000 | 8000 | 8000 | 8000 | 8000 | 8000 |
| Адуунчулуун | 3200 | 3200 | 3200 | 3750 | 3750 | 3750 | 4807.4 | 5100 | 5100 | 6100 | 7500 | 7500 | 8584 | 8584 |

Эрчим хүч

» өрхүүд бүрдүүлдэг бөгөөд тэдний 64 хувь нь 150 кВт.ц хүртэл хэрэглэдэг гэсэн тойм тооцоо ч бий аж. Харин тэрнээс дээш гарч байгаа хэрэглээг болон аж ахуйн нэгжүүдийн авах эрчим хүчний үнийг үе шаттайгаар нэмээд явах боломжийг УИХ тогтоолоороо бүрдүүлсэн гэж ойлгож болох ажээ. Ийнхүү “эхийг нь эцээлгүй, тугалыг нь тураалгүй” гаргасан төр, засгийн шийдвэр эрчим хүчний салбарыг эрүүлжүүлэх суурь болж байгааг мэргэжилтнүүд онцолж буй.


УИХ-ын 72-р тогтоолын буянаар “Нүүрсний уурхай болон эрчим хүчний компани хоорондын өрийн сүлжээ” гэх нэр томъёо алга болно хэмээн салбарын хүмүүс баярлаж байна. Ингэснээр эрчим хүчний компаниудын өр ба нийт хөрөнгийн харьцаа сайжирч, цаашдаа гадаад дотоодын урт хугацаат зээлийн хөрөнгөөр техник технологийн шинэчлэл хийх боломж бүрдэх ажгуу. “Гэхдээ УИХ-ын энэ тогтоолын дагуу үнийг бүрэн чөлөөлнө гэж хэлэхэд бас учир дутагдалтай. 2014 он гэхэд ямар

ч байсан эрчим хүчний салбар алдагдалгүй ажиллах боломж, нөхцөлийг л бий болгох түвшинд хүрсэн байна гэж ойлгох нь зүйтэй” хэмээн Эрдэс баялаг, эрчим хүчний яамны Эрчим хүчний бодлогын газрын дарга Т.Цэрэнпүрэв тайлбарлав. “Тавдугаар сарын 1-нээс үнэ өсгөснөөр бид 2011-2012 оны өвлийн бэлтгэлээ хангах боломж нөхцөл бүрдлээ” хэмээн Эрчим хүчний зохицуулах газрын дарга Н.Мягмарсүрэн тэмдэглээд, 2014 он гэхэд нэг кВт.ц цахилгааны үнийг 115 төгрөгт хүргэх тооцоо байгааг дуулгасан юм.


Гэхдээ зах зээлийн үнэ рүүгээ төвийн бүс л түрүүлж явах найдлага төрүүлж буйг Эрчим хүчний зохицуулах газрын мэргэжилтнүүд онцолж байна. Учир нь Баруун таван аймаг, Дорнод, Даланзадгадыг өртгөө нөхөх хэмжээнд үнээ тогтоо гэвэл хэцүүднэ. Тиймээс удаан хугацаанд Засгийн газар татаас, дэмжлэг өгч байж л алслагдсан сууринг эрчим хүчээр хангаж чадах ажээ.

Ямартай ч “онцгой” хэмээх

тодотголтой энэхүү салбарыг жаахан дэмжихэд л босоод ирэх бололцоотойг мэргэжилтнүүд ярьж байна. Эрчим хүчний компаниудын өр 2008 онд 55 тэрбум төгрөгөөс давж цойлж байсан бол 2010 оны эцэст энэ үзүүлэлт 29.3 тэрбум болтлоо буурчээ. Энэ нь төр, засгаас үзүүлж буй дэмжлэг, татаасын зэрэгцээ сүүлийн хоёр жилийн хугацаанд эрчим хүчний үнийг тодорхой хэмжээгээр нэмж ирсний үр дүн юм билээ. Тэгэхээр 2014 он хүртэл дулаан, цахилгааны үнийг үе шаттайгаар өсгөх боломж бүрдсэнээр эрчим хүчний компаниуд өр шир гэдгийг мартаад гялалзаж явах цаг удахгүй тохиох нь. Монгол Улс эрчим хүч импортлодог биш, экспортлодог орон болчихсон, Засгийн газар маань төсвийн хөрөнгөнөөс татаас гаргах талаар бодож толгойгоо гашилгадаг бус, цахилгаанаа борлуулж олсон мөнгөөрөө юунд хөрөнгө оруулалт хийх вэ гэж тооцоолдог болох үе ирэх биз ээ. ■



Эх сурвалж: ЭХЗГ-аас гаргасан “Эрчим хүчний статистик үзүүлэлтүүд 2010” эмхтгэл



Ч.Даваахүү: “Ухаа худаг” цахилгаан станцад усны алдагдал гарахгүй

Ухаа худагт ирэх наймдугаар сард Монгол инженерүүдийн бие даан хийсэн анхны цахилгаан станц ашиглалтад орох гэж байна. Говийн онцлогт тохирсон хуурай хөргөлтийн системийг нэвтрүүлснээр Монголын эрчим хүчний салбарт өнгө нэмж буй “Энержи ресурс” компанийн үйл ажиллагаа, төслийн удирдлага хариуцсан дэд ерөнхийлөгч Ч.Даваахүүтэй ярилцлаа.

–“Ухаа худаг” цахилгаан станцын хуурай хөргөлтийн системийн онцлог нь юу вэ. Монголд шинэ технологи нэвтрүүлсэн гэдэг утгаараа бэлтгэл ажил их шаардсан уу?

–Говийн нөхцөлд усны нөөц бага, цаашдаа тухайн бүс нутагт бий болох төслүүдэд усны хэрэгцээ зайлшгүй шаардлагатай зэргийг харгалзан, байгальд ээлтэй гэдэг утгаар нь бид хуурай хөргөлтийн системийг сонгосон юм. Энэ систем нь манай улсад анх удаа хийгдэж байгаа ч олон улсад бол хэрэглээнд нэвтрээд нэлээд хугацаа өнгөрсөн байна. Гол онцлог нь үйлдвэрлэлийн үндсэн технологийн хэрэглээний усны алдагдлыг “0” хэмжээнд буюу огт алдагдалгүй байлгахад оршиж байгаа. Зүйрлэж хэлбэл бидний хамгийн сайн мэдэх автомашины радиатортай ижил технологи юм. Цахилгаан станцад ашиглагдсан өндөр чанартай уурыг дахин ашиглахын тулд хөргөхдөө уламжлалт аргаар бол шууд агаартай харьцаанд оруулж, улмаар зарим хэсэг нь ууршиж алга болдог. Харин хуурай хөргөлтийн системд хөргөлтийн битүү системээр (радиатороор) ажиллах тул усны алдагдал гарахгүй.

Бэлтгэл ажлын хувьд эхлээд аль улсын ямар технологи нь манайд илүү тохиромжтой, найдвартай байх вэ гэдгээс эхлээд энэ төхөөрөмжийг суурилуулж тохируулах, дараа нь ажиллуулах хүмүүсийг бэлтгэх зэрэг олон ажил хийсэн. Ингээд



бид Германы GEA компанийн бүтээгдэхүүнийг сонгосон бөгөөд суурилуулалтын үед тухайн компаниас мэргэжилтнүүд газар дээр нь ирж зөвлөгөө өгч ажилласан учраас монгол компаниудад туршлага болж өглөө. Түүнчлэн цахилгаан станцын баг маань энэ төрлийн хөргөлтийн системтэй хэд хэдэн станц дээр очиж үйл ажиллагаатай нь танилцаж, сургалтад суусан. Удахгүй үр дүнг нь харах үлдэж байна. Мэдээж шинэ технологи тул асуудал, бэрхшээл тулгарах л байх, гэхдээ бид бэлтгэлээ сайн хангаж ажиллаж байгаа.

–“Ухаа худаг” цахилгаан станц уурхайн төдийгүй Цогтцэций сумын эрчим хүчний хэрэгцээг хангана гэж байгаа. Ер нь танай уурхайн эрчим хүчний хэрэгцээ ямар түвшинд байдаг вэ. Цаашдаа цахилгаан станцынхаа хүчин чадлыг нэмэгдүүлэх үү?

–Тийм ээ, бид цахилгаан станцыг ашиглалтад оруулсны дараа Ухаа худаг уурхайн хэрэгцээнээс гадна Цогтцэций сумыг эрчим хүчээр хангах төлөвлөгөөтэй ажиллаж байгаа. Үүнийхээ бэлтгэл ажлын хүрээнд өнгөрсөн жил уурхайн сүлжээг сумын сүлжээтэй холбосон юм. Өнөөдрийн байдлаар уурхай

орчмын хэрэглээ 1.2-1.5 МВт орчимд хэлбэлзэж байгаа ч нүүрс баяжуулах үйлдвэрийн туршилттай холбоотойгоор гурван МВт хүртэл хэрэглэж байна. Зөвхөн уг үйлдвэр ашиглалтад орсноор дангаараа 5-6 МВт эрчим хүчний хэрэглээтэй байх төлөвтэй. Гэхдээ дараагийн хоёр болон гуравдугаар өргөтгөлүүд орсон нөхцөлд цахилгаан станцын хүчин чадал бүрэн ашиглагдахаар тооцоолсон. Станцын хүчин чадлын хувьд 18 МВт гэж байгаа ч цаашид шинээр бий болох төслүүд болон цахилгааны хэрэглээнээс хамаарч өргөтгөл хийж болохуйц нөхцөлийг бүрдүүлсэн.

–“Энержи ресурс” компани энэ ажилд хэдий хэмжээний хөрөнгө зарцуулсан бэ? Энэхүү технологийн дагуу үйлдвэрлэх эрчим хүчний өртөг одоо Монголд ашиглаж байгаа дулааны цахилгаан станцуудтай харьцуулахад ямар байх тооцоотой байна вэ?

–“Ухаа худаг” Цахилгаан станц нь одоо орчин үед баригдаж байгаа станцуудыг бодвол харьцангуй бага чадлын станц тул нэгж хүчин чадалтай нь харьцуулбал нэлээд өндөр өртөгтэй босож байгаа. Хэдийгээр жижиг станц ч гэсэн цахилгаан станцад ▶

► байх ёстой бүх л объект баригдах шаардлагатай байдаг. Жишээ нь хими ус цэвэрлэгээний байгууламж, хөргөлтийн систем, засварын цех гээд үндсэн барилгаас гадна байх ёстой бүгдийг л барих шаардлагатай. Мөн хуурай хөргөлтийн систем болон утааны хийг цэвэршүүлэх системүүд нь зардал өсөх гол шалтгаан болсон. Станцын нийт зардал ойролцоогоор 45 сая ам.доллар болж байна. Үүнээс гадна цахилгааны дэд станц, уурхай орчмын цахилгаан шугам сүлжээнд мөн 10 гаруй сая ам.доллар зарцуулж байж бүтэн систем бий болж байгаа юм.

-Зөвхөн “Энержи ресурс” төдийгүй бусад хувийн компани ч суулийн үед эрчим хүч үйлдвэрлэх тал дээр нэлээд анхаарч байгаа. Энэхүү салбарын хөрөнгө оруулалтын орчныг Та хэрхэн үнэлж байгаа вэ. Хувийн

компаниуд санаачилгатай байж, шинэ технологи нэвтрүүлэхэд төрөөс ямар нэгэн байдлаар дэмжиж байна уу?

-Сүүлийн үед шинээр эрчим хүчний эх үүсвэр барих тал дээр хувийн хэвшлүүд санаачилгатай ажиллаж байгаа нь үнэхээр бодит хэрэгцээг хангах дэд бүтцийг сайн хөгжүүлж чадаагүй байгаатай холбоотойгоор зайлшгүй урган гарч ирж буй асуудал гэж ойлгож байна. Эрчим хүчний салбарын хөрөнгө оруулалт өөрөө маш өндөр, удаан хугацаанд өгөөжөө өгдөг, үнэ тарифын хувьд зах зээлийн системд шилжээгүй учраас шууд хөрөнгө оруулахад эрсдэлтэй харагддаг. Тиймээс хувийн компаниуд голдуу өөрсдийн хэрэгцээнд тохирсон бага оврын цахилгаан станц барьж таарах гээд байна. Уг нь хэд хэдэн том станц баригдвал хөрөнгө

оруулалт болон ашиглалтын зардал багатай, нийт дүнгээрээ эдийн засгийн хувьд хэмнэлттэй байх учиртай. Шинэ технологийн хувьд одоогоор төр засгийн байгууллагууд дэмжиж сайшааж байгаа ч цаашдаа ямар нэг байдлаар эдийн засгийн хөшүүргүүдийг илүүтэй ихээр бий болгож байж л дэвшилт технологиуд Монголд нутагшихад түлхэц үзүүлнэ гэж бодож байна.

Хамгийн гол нь эрчим хүчний салбарыг аль болох зах зээлийн системд түргэн оруулах тал дээр шат дараатай алхмууд хийвэл үр өгөөж нь түргэн гарна. Дотоодын болон гадаадын хөрөнгө оруулагчид энэ салбарт хөрөнгө оруулах сонирхол нэлээд нэмэгдэж байгаа ч одоо байгаа үнэ тариф болон хууль эрх зүйн орчин нь тэр бүр таатай биш байгаа нь салбарын хөгжилд нөлөөлж байгаа гэж ойлгодог. ■

“Mongolian Economy” сэтгүүлийн асуулт

Та компанийнхаа одоогийн байдлыг хэрхэн үнэлж дүгнэж байна вэ? Мөн компанийн ирээдүйг хэрхэн харж байна вэ?

Б.Цэвээн /ДЦС 4 ХК-ийн гүйцэтгэх захирал/:

-Манай станцын суурилагдсан хүчин чадал 540 бөгөөд бид өөрсдийн хөрөнгө оруулалтаар 40 МВт-ын чадлыг нэмж 580МВт болгосон байгаа. 1995 оноос хойш гаднын зээл тусламжаар техник технологийн шинэчлэл нэлээд хийсэн. 2001 оноос станц хувьцаат компани болсноор бие даан ажиллах системд шилжих замаар тогтвортой найдвартай ажиллагаагаа дээшлүүлсэн. Станцын техник эдийн засгийн үзүүлэлтүүд сайжирсан. Өнгөрсөн хоёр жилээс санхүү эдийн засгийн орчин эрүүлжсэн. Энэ нь эрчим хүчний үнийг их биш юм аа гэхэд бага хэмжээгээр нэмж, төрөөс татаас олгож байгаатай холбоотой. 2010, 2011 онд станцын өрийн сүлжээ байхгүй болж, Багануурын уурхайд өргүй болсон. Харин Шивээ-Овоогийн уурхайд тодорхой хэмжээний өр бий.

Бид станцынхаа ирээдүйг өөдрөгөөр харж байна. Шинэ эх үүсвэрийг ашиглалтад ортол эрчим хүчний хэрэглээний өсөлтийг манай станц дангаараа хааж ажиллана. Тиймээс техник технологийн найдвартай ажиллагаагаа хангах талаас ихэд анхаарч ажиллаж байна. 2013 он хүртэл эрчим хүчний хэрэглээний жилийн дундаж түвшин 10 хүртэл хувьтай, тогтвортой бус хэрэглээний өсөлттэй байвал манай станц тус хэрэглээг хааж ажиллах бүрэн боломжтой. Харин хэрэглээний жилийн дундаж өсөлт 10 хувиас давж, өсөлт ч жилдээ тогтвортой явбал 2012 оноос хүндрэл гарна. Манай станц 2014 оны түвшинд алдагдалгүй ажиллах боломжтой. Хамгийн гол нь эрчим хүчний үнийг жилдээ тодорхой хувиар нэмж, зах зээлийн өртөгт нь ойртуулах замаар мөн хэрэглэгчдийн нуруун дээр огцом ачаалал өгөхгүйн тулд төрөөс татаас өгч явбал станц алдагдалгүй ажиллах нөхцөл бүрдэх юм.

Х.Балсандорж /“Шивээ-Овоо” ХК-ийн гүйцэтгэх захирал/:

-Уурхайн санхүүгийн байдал хүндхэн байгаа. Энэ нь Засгийн газраас нүүрсний үнийг барьж ирсэнтэй холбоотой. Өөрийн өртгөөсөө хямд үнээр бүтээгдэхүүнээ нийлүүлэхээр уурхайн санхүү ямар сайн байх вэ дээ. Шийдэх асуудлуудын хувьд нэгдүгээрт, технологийн шинэчлэл хийх шаардлагатай байна. Компанийн хэмжээнд бодлого чиглэлээ гаргаад өгсөн байгаа. Бид нүүрс хатаах үйлдвэрийн конвейрийн системийг одоо ажилд оруулах гэж байна. Хөрсний тээврийн конвейрийн системийг мөн ашиглалтад оруулна. Эдгээр нь зардал багатай, бүтээмж өндөртэй технологиуд. Засгийн газрын дэмжлэг шаардлагатай байна. ДЦС-5-ын нүүрсний хэрэглээний 70 хувийг манай уурхай дангаараа хангахаар болж байна. Жилдээ 2.7 сая тонн нүүрс нийлүүлнэ гэсэн үг. Тиймээс ийм хэмжээний бүтээгдэхүүн нийлүүлэхийн тулд уурхайн хүчин чадлыг 2.6 дахин нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатай байгаа. Хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй байна. Энэ тохиолдолд уурхай жилдээ 4.5 сая тонн нүүрс олборлож Багануурын уурхайтай тэнцэхүйц том уурхай болох сайхан ирээдүй харагдаж байгаа юм. Энэ боломжийг бид ашиглах ёстой. Тэр хэрээр ч хариуцлага нэмэгдэхээ ч ухаарч одооноос бэлтгэл ажлыг хангаж ажиллаж байна.

Б.Дамдинсүрэн /ТЭЦ 3-ын гүйцэтгэх захирал/:

-Манай станц 42 жилийн настай. Техник технологийн хувьд хоцрогдолд орж, шинэчлэх зайлшгүй шаардлагатай байгаа. Харин эрчим хүчний шинэ эх үүсвэрийг манай станцын бааз суурийг ашиглан барих болсон нь цаг

» үеэ олсон асуудал. Техник технологи хуучирсан учраас зогсолт нэмэгдэж байна. Хуучин ЗХУ-д үйлдвэрлэсэн сэлбэгүүд ч олдохгүй хүндрэл учруулах болсон. Ийм цаг үед байгаль орчинд халгүй орчин үеийн технологи бүхий шинэхэн станцыг барьж байгуулах нь маш зөв шийдэл гэж хүлээн авч байгаа.

Б.Базар /Багануурын уурхай ХК-ийн тэргүүн дэд захирал/:

-Уурхай маань 2009 оныг хүртэл жилдээ 2.8-3.0 сая тонн нүүрс олборлодог байсан бол 2010 оноос энэ үзүүлэлт 3.5 сая тоннд хүрсэн. Нүүрсний хэрэгцээ нэмэгдэхийн хирээр бид дотоод нөөц бололцоогоо ашиглаад сайн ажиллах ёстой. Холбогдох төрийн байгууллагуудаас ч тодорхой хэмжээний дэмжлэг үзүүлж байна. Нүүрсний үнээс шалтгаалан техник технологийн хоцрогдолд нэлээд орсон. Тиймээс технологийн шинэчлэл хийх хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай байгаа тул уурхай хөрөнгийн зах зээлээс мөнгө босгох зорилгоор нэмэлт хувьцаа гаргах

бэлтгэл ажил хийж байна. Одоогоор уурхайн 75 хувийг төр, 25 хувийг хувьцаа эзэмшигчид эзэмшдэг. 2012 оноос нэмэлт хувьцаа гаргах төлөвлөгөөтэй байна. Ингэснээр 51 хувь төрд, 49 хувь нь хувьцаа эзэмшигчдийн мэдэлд очих юм. Мөн нүүрсээ боловсруулж гаргах ирээдүйн төлөвлөгөө ч бий.

Хуримтлагдсан өр авлагын хувьд буурч байгаа. Манай өөрийн бүтээгдэхүүн нэг тонн нь 21300 төгрөгийн өртөгтэй гараад 18200 төгрөгөөр нийлүүлэхээр жил бүрийн алдагдал улам л ихсээд байгаа юм. Харин сая тавдугаар сарын 1-нээс үнэ нэмснээр 20500 төгрөг болсон. Энэ нь бидэнд ашигтай биш юм аа гэхэд алдагдалгүй ажиллахад дөхөм болно. Тухайлбал, өнөө жил 8.3 тэрбум төгрөгийн алдагдал хүлээх байсан бол үнэ нэмснээр алдагдал дөрвөн тэрбум руу орж ирж байна. Тэгэхээр цаашдаа нүүрсний үнийг бодит өртөгт ойртуулбал уурхайн санхүүгийн байдал илт сайжирч тэр хэрээр нүүрсний өсөн нэмэгдэж буй хэрэглээг хангах зорилгоо тогтвортой сайн биелүүлээд явах нь ойлгомжтой. ■

PPP Түншлэл

Б.Заяабал: Эрчим хүчний салбарт дэвшилт технологийг нэвтрүүлэх боломжтой

Төрийн өмчийн хорооны Төр, хувийн хэвшлийн түншлэл, концессын газрын дарга Б.Заяабалтай ярилцлаа.

-Манай улсад төр, хувийн хэвшлийн түншлэл, тухайлбал эрчим хүчний салбарт ямархуу явж байгаа вэ?

-Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого, Концессын тухай хууль батлагдсанаас хойш шаардлагатай журмуудыг боловсруулж батлуулах, төр, хувийн хэвшлийн түншлэл, түүнийг Монголын хууль эрх зүйн орчинд хэрэгжүүлэх талаар дэлгэрэнгүй ойлголт өгөх гарын авлага гаргах, холбогдох яамд, агентлаг, орон нутгийн төрийн албан хаагчид, мөн хувийн хэвшлийнхэнд энэ талаар сургалт хийж чадавхыг нь бэхжүүлэх зэргээр ажиллаж ирсэн. Одоогийн байдлаар гурван төслийн концесс олгох уралдаант шалгаруулалтыг зарласан, сонгон шалгаруулах үйл

ажиллагаа явагдаж байгаа. Манай хамгийн анхны концессын гэрээг эрчим хүчний салбарт хийнэ. Тухайлбал, Могойн голын дулааны цахилгаан станцыг барих-ашиглах-шилжүүлэх нөхцөлөөр байгуулсныг хэлмээр байна. Цаана нь концессын зүйлийн жагсаалтад эрчим хүчний салбарын 15 төсөл байгаа. Монголын эдийн засаг хурдацтай өсөж байгаагийн хэрээр цаашид эрчим хүчний үйлдвэрлэл, дамжуулалт, түгээлтийн эрэлт эрс нэмэгдэж, холбогдох төслүүдийг цаг алдалгүй хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлагатай тулгарч байна.

-Эрчим хүчний салбарт төсвийн хөрөнгө оруулалтаар биш төр, хувийн хэвшлийн түншлэлээр төсөл хэрэгжүүлэх нь ямар ач холбогдолтой юм бол

-Монгол шиг хөгжлийнхөө гараан дээр байгаа улсад хязгаарлагдмал нөөц баялгаа хэзээ, юунд, яаж зарцуулах талаар зөв шийдвэр гаргах нь чухал ач холбогдолтой.



Эрчим хүчний салбар, дэд бүтцийн салбарын төслүүд маш их хэмжээний хөрөнгө оруулалт шаарддаг. Төр, хувийн хэвшлийн түншлэлийг ашигласнаар татварыг нэмэх, бусад төслийн хөрөнгө оруулалтыг бууруулах зэрэг арга хэмжээг авахгүйгээр төсвийн ачааллыг багасгаж, эдгээр чухал ач холбогдолтой төслүүдийг хэрэгжүүлж эхлэх, ард иргэдийн хувьд эрчим хүч, дэд бүтцийн байгууламжуудын үр ашгийг илүү эрт хүртэх, үр ашигтай, чанартай үйлчилгээ авах гэх мэтчилэн олон талын ач холбогдолтой юм. Гадаад орнуудын туршлагаас харахад

» эрчим хүчний үйлдвэрлэлээс гадна эрчим хүчний хэмнэлт, үр ашигтай зарцуулалт, “ногоон” хөрөнгө оруулалтад чиглэсэн түншлэлийг ихээхэн дэмжиж байна.

-Гадаадын улс орнуудын туршлагын талаар ярихгүй юу?

-Хамгийн их туршлагатайд Англи, Солонгос, Испани, Австрали, АНУ, Унгар, Япон, Итали, Португали, Канад гэх мэт орон тооцогддог. Турк улс гэхэд нийт 68 төсөл хэрэгжүүлснээс 30-ыг нь эрчим хүчний салбарт хэрэгжүүлсэн жишээ байна. Чили улсад ийм түншлэлийг эрчим хүчний салбарын хөгжилд амжилттайгаар ашигласан. Хөгжиж байгаа орнуудаас бол Индонезид 1990-2006 онд 13 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалтыг эрчим хүчний салбарт төр, хувийн хэвшлийн түншлэлээр дамжуулан оруулжээ. Эрчим хүчний салбарт ийм байдлаар хэрэгжүүлсэн ихэнх төсөл грийнфилд буюу шинээр барих төслүүд байдаг.

-Тэгвэл төр, хувийн хэвшлээр хэрэгжүүлсэн эрчим хүчний төслийн жишээ байна уу?

-Английн туршлагыг судлахад хог хаягдал боловсруулж эрчим хүч гаргах олон төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчмаар амжилттай хэрэгжүүлсэн байдаг. Одоо ч гэсэн энэ чиглэлээр тендерүүд ихээхэн зарладаг юм билээ. Хөгжиж байгаа орны нэг

жишээ бол Бангладешийн Мегнагат эрчим хүчний станцын төсөл байна. Барих-өмчлөх-ашиглах концессын төрлөөр 289.6 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийж, 2002 онд хугацаанаас нь өмнө ашиглалтад оруулан ажиллаж байгаа, эдийн засгийн ашигтай, байгаль орчинд халгүй, удирдлага зохион байгуулалт сайтай явагдсан маш сайн төслийн жишээ юм.

-Манай эрчим хүчний салбарт түншлэлийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд ямар арга хэмжээг авах шаардлагатай байна вэ?

-Төрийн өмчийн хорооноос Олон улсын санхүүгийн корпорацитай хамтран концессын зүйлийн жагсаалтад орсон төслүүдэд урьдчилсан үнэлгээ явуулахад өөрийн өртгөө нөхөж, ашиг олох боломж багатай төслүүд нэлээд байсан. Зохих хэмжээнд төсвийн санхүүгийн дэмжлэг, баталгаа өгвөл улс орны хувьд нэн тэргүүний ач холбогдолтой эдгээр төсөлд хувийн хэвшлийг татаж, хэрэгжүүлэх бүрэн боломжтой байгаа. Эрчим хүчний салбарын төслүүдийн хувьд амжилттай хэрэгжүүлэхийн тулд түүхий эд, материалын нийлүүлэлт, бүтээгдэхүүний худалдан авалтын гэрээг индексжүүлсэн үнээр урт хугацаанд тогтвортой байгуулах, орлогын доод хэмжээнд баталгаа өгөх гэх мэт бусад олон аргыг

хэрэглэж болох юм. Мөн түүнчлэн концессын гэрээг хэдий сайтар бэлтгэж байгуулсан ч хэрэгжүүлэх орчин нь бүрдээгүй бол тухайн төслийг хэрэгжүүлэх зорилгодоо хүрэхэд бэрхшээлтэй байдгийг харгалзан эрчим хүчний салбарын зохицуулалтыг сайтар бодолцож үзэх шаардлагатай байна.

-Хамгийн ойрын үед тус салбарт болон бусад салбарт хэрэгжүүлэх ямар ажлууд байна вэ?

-Эрчим хүчний салбарт Тавантолгойн цахилгаан станц, Дулааны 5-р цахилгаан станц болон нэлээд хэдэн дамжуулах шугам тавих ажлуудыг эхлүүлнэ. Мөн уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэх зам, шинээр барих нисэх буудлын хурдны зам тавих төслүүдийг хэрэгжүүлэх чиглэлээр ажиллана. Мэдээж концессын зүйлийн жагсаалтад орсон боловсрол, байгаль орчин, эрүүл мэндийн чиглэлийн төслүүдийг ч хэрэгжүүлж эхэлнэ. Эрчим хүчний салбар гэхээр зөвхөн дулааны цахилгаан станц, дамжуулах шугам гэж ойлгож болохгүй, олон улсын жишгээр сэргээгдэх эрчим хүч, хог хаягдал боловсруулж эрчим хүч гаргах гэх мэт дэвшилт технологийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр дамжуулж Монголд нэвтрүүлэх өргөн боломж байгаа гэдгийг онцлон хэлмээр байна. ■

ТӨРИЙН ӨМЧИЙН КОНЦЕССЫН ЗҮЙЛИЙН ЖАГСААЛТ ДАХЬ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТӨСЛҮҮД

| № | Концессын зүйлийн нэр | Концессын зүйлийн тодорхойлолт | Концессын төрөл | Гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээ | Төсвийн хөрөнгөөр санхүүгийн дэмжлэг үзүүлэх, баталгаа гаргах эсэх | Уралдаант шалгаруулалт явуулах, шууд гэрээ байгуулах эсэх |
|---|---|--|---|---|--|---|
| 1 | Таван толгойн цахилгаан станц | Говийн бүсийн цахилгаан эрчим хүчний хэрэгцээг хангахуйц цахилгаан эрчим хүчний үйлдвэрийг Таван толгойн нүүрсний станцыг түшиглэн барих | Барих-өмчлөх-ашиглах | Эрчим хүчний барилга байгууламж барих, цахилгаан үйлдвэрлэх, эзэмших | Шаардлагагүй | Уралдаант шалгаруулалт явуулах |
| 2 | Дулааны Ү цахилгаан станц | Улаанбаатар хотын цахилгаан болон дулааны хэрэгцээг хангах зорилго бүхий дулааны цахилгаан станц барих | Барих-өмчлөх-ашиглах | Эрчим хүчний барилга байгууламж барих, цахилгаан, дулаан үйлдвэрлэх, эзэмших | Шаардлагагүй | Уралдаант шалгаруулалт явуулах |
| 3 | УБ хотын “Их тойруу” цагираг шугам сүлжээ байгуулах | Улаанбаатар хотын хүн амын цахилгаан, эрчим хүчний хангамжийг нэмэгдүүлэх | Зураг төсөл боловсруулах-барих-санхүүжүүлэх-шилжүүлэх | Улаанбаатар хотын цахилгааны 110 кВт-ын “Их тойруу” цагираг шугам сүлжээний зураг төсөл боловсруулах, санхүүжүүлэх, шилжүүлэх | Судлан шийдвэрлэх | Уралдаант шалгаруулалт явуулах |

| | | | | | | |
|----|--|---|---|--|-------------------|--|
| 4 | Дулаан хангамжийг нэмэгдүүлэх | Улаанбаатар хотын хүн амын дулаан хангамжийг нэмэгдүүлэх | Зураг төсөл боловсруулах-барих-санхүүжүүлэх-шилжүүлэх | Улаанбаатар хотын дулааны шугам сүлжээг шинээр болон шинэтгэн өргөтгөх ажлуудын зураг төсөл боловсруулах, санхүүжүүлэх, барих, шилжүүлэх | Судлан шийдвэрлэх | Уралдаант шалгаруулалт явуулах |
| 5 | Дорнодын дулааны цахилгаан станц | 100 МВт хүчин чадалтай дулааны цахилгаан станц барих | Барих-смчлах-ашиглах | Эрчим хүчний барилга байгууламж барих, дулаан үйлдвэрлэх, ашиглах, шилжүүлэх. | Шаардлагагүй | Уралдаант шалгаруулалт явуулах |
| 6 | Могойнолын дулааны цахилгаан станц | 60 МВт хүчин чадалтай цахилгаан станц барих ажил | Барих- ашиглах-шилжүүлэх | Эрчим хүчний барилга байгууламж барих, цахилгаан үйлдвэрлэх, ашиглах, шилжүүлэх | Шаардлагагүй | Гэрээг шинэчлэн байгуулах |
| 7 | Шивээ-Овоо төсөл | БНХАУ-д цахилгаан эрчим хүчийг экспортлох зорилготой нүүрсний уурхай, дулааны цахилгаан станцын цогцолбор болон цахилгаан дамжуулах өндөр хүчдэлийн шугам сүлжээ барих | Барих-смчлөх-ашиглах | Эрчим хүчний барилга байгууламж барих, цахилгаан үйлдвэрлэх, ашиглах, шилжүүлэх | Шаардлагагүй | Засгийн газар хоорондын тохиролцооны дагуу гэрээ байгуулах |
| 8 | Улаанбаатар-Мандалговийн цахилгаан дамжуулах агаарын шугам | 260 км урттай 220 кВТ-ын хоёр хэлхээт 2хАС-400/51 дамжуулагч утастай, 2 тростой, цахилгаан дамжуулах агаарын шугам барих | Зураг төсөл боловсруулах-барих-санхүүжүүлэх-шилжүүлэх | Цахилгаан дамжуулах агаарын шугам барих | Судлан шийдвэрлэх | Уралдаант шалгаруулалт явуулах |
| 9 | Багануур-Чойрын цахилгаан дамжуулах агаарын шугам | 180 км урттай 220 кВТ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам барих | Зураг төсөл боловсруулах-барих-санхүүжүүлэх-ашиглах-шилжүүлэх | Цахилгаан дамжуулах агаарын шугам барих | Шаардлагагүй | Уралдаант шалгаруулалт явуулах |
| 10 | Чойр-Цагаан-суварга цахилгаан дамжуулах агаарын шугам | 280 км урттай 220 кВТ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам барих | Зураг төсөл боловсруулах-барих-санхүүжүүлэх-ашиглах-шилжүүлэх | Цахилгаан дамжуулах агаарын шугам барих | Шаардлагагүй | Уралдаант шалгаруулалт явуулах |
| 11 | “Дулааны III цахилгаан станц ХК” төсөл | Дулаан үйлдвэрлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, техник технологийг шинэчлэх | Шинэчлэн сайжруулах-ашиглах-эзэмших | Цахилгаан, дулаан үйлдвэрлэх, ашиглах, эзэмших | Шаардлагагүй | Уралдаант шалгаруулалт явуулах |
| 12 | “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ХК” төсөл | Цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, техник технологийг шинэчлэх | Шинэчлэн сайжруулах-ашиглах-эзэмших | Цахилгаан, дулаан үйлдвэрлэх, ашиглах, эзэмших | Шаардлагагүй | Уралдаант шалгаруулалт явуулах |
| 13 | “Орхон-говь” усан сан байгуулах | Говийн бүсийн усан хангамж, байгаль орчны доройтлыг нөхөн сэргээх зорилго бүхий усан сан, хоолой барих | Барих- ашиглах-шилжүүлэх | Ус хоолойгоор дамжуулан ус нийлүүлэх, эрчим хүчний барилга байгууламж барих, цахилгаан үйлдвэрлэх, ашиглах, шилжүүлэх | Шаардлагагүй | Уралдаант шалгаруулалт явуулах |
| 14 | “Туул-Сонгино” усны нөөцийн цогцолбор | Төв цэвэрлэх байгууламжийн усанд гүн цэвэршүүлэлт хийх, цэвэршүүлсэн усаа эрчим хүчний үйлдвэрүүд болон эрчим хүч гаргах хэрэгцээнд ашиглах | Барих-смчлөх-ашиглах | Бохир ус цэвэрлэх, ундны ус ханган нийлүүлэх, ус хоолойгоор дамжуулан нийлүүлэх, эрчим хүчний барилга байгууламж барих, цахилгаан үйлдвэрлэх, ашиглах, эзэмших. | Шаардлагагүй | Шууд гэрээ байгуулах |
| 15 | Хог хаягдал боловсруулан эрчим хүч үйлдвэрлэх | “Хог хаягдлыг өндөр хэмд боловсруулах технологи”-ийн үйлдвэр барьж хотын хог хаягдлыг дахин боловсруулан эрчим хүч үйлдвэрлэх | Барих-смчлөх-ашиглах | Хог хаягдал боловсруулах, эрчим хүч, эрчим хүчний барилга байгууламж барих, цахилгаан үйлдвэрлэх, ашиглах, шилжүүлэх | Шаардлагагүй | Уралдаант шалгаруулалт явуулах |
| 16 | Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламж болон урьдчилан цэвэрлэх байгууламжийг шинэчлэн сайжруулах | Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламж болон урьдчилан цэвэрлэх байгууламжийг шинэчлэх замаар хүн амыг баталгаат ундны усаар хангах, байгаль орчин, хөрс усны бохирдлыг багасгах | Зураг төсөл боловсруулах-барих-санхүүжүүлэх-шилжүүлэх | Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламж болон үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх байгууламжийг байгаль орчинд хор нөлөөгүй технологиор шинэчлэн сайжруулах, ашиглах, шилжүүлэх | Судлан шийдвэрлэх | Уралдаант шалгаруулалт явуулах |



Сэргээгдэх эрчим хүч

Импортыг орлох “удирдлага”

SOS! Оросоос авч буй эрчим хүчний импорт огцом өсөөд эхэлснийг Та анзаарч байна уу? Манай дулааны цахилгаан станцууд жилдээ дөрвөн тэрбум кВт.ц эрчим хүч үйлдвэрлэн, оргил ачааллын хэрэгцээгээ ОХУ-аас импортоор авч хаасаар өнөөдөртэй золгож буй. Өмнө нь бид хойд хөршөөс жилдээ 130 орчим сая кВт.ц цахилгаан худалдаж авдаг байсан учраас нэг их санаа зоволгүй ирсэн байж болно. Гэвч өнгөрсөн жил уг үзүүлэлт 21 хувиар суга өсөн 157.5 сая кВт.ц болж, энэ онд бүр 200 сая кВт.ц-т хүрч цойлох төлөвтэйг албаны хүмүүс тооцоолж сууна.

Хот хүрээгээ тэлж, эрчим хүчний эрэлт хэрэгцээ нэмэгдэх тусам Монгол орон маань Оросоос хараат болох гээд байна шүү дээ. Гэтэл хойд хөршийн эрчим хүчний салбар энэ оноос чөлөөт зах зээлд бүрэн шилжсэн учраас монголчуудад өндөр үнэ тулгахыг үгүйсгэх аргагүй болчихлоо. Ер

нь манайд эрчим хүч нийлүүлдэг “Интер РАО ЕЭС” нийгэмлэг үнээ байнга өсгөж ирсэн бөгөөд өнгөрсөн жилийн өдийд бүр 60 хувийн гэнэтийн өсөлтөөр сюрприз барьж, монголчуудыг сандаргаад авсныг сануулахад илүүдэхгүй биз ээ. Яах вэ, холбогдох албаныхан оросуудыг аргадаж, удаа дараа ярилцаж, хэлэлцсэний үр дүнд энэ асуудлыг Монголын талд дарамт учруулахгүйгээр шийдэж чадсан. Гэхдээ дахин ийм байдал үүсэхийг үгүйсгэхгүй. Ер нь бид яагаад Оросоос цахилгаан импортлоод, царай алдаад байдаг билээ?

Оройн 19.00-22.00 цагийн хооронд бүх хүн гэртээ ирээд, хоолоо хийгээд, зурагтаа үзээд ирэнгүүт хэрэглээ 150-200 МВт-аар гэнэт өсчихдөг ажээ. Оргил ачааллын энэ үеийг манай дулааны цахилгаан станцууд зуухаа ажиллуулаад хангачихаж болох ч 16 цагийн турш явж байж горимоо буюу хүчин чадлаа авдаг, мөн тэр хэмжээгээрээ ажиллаж байж

унтардаг тухай мэргэжилтнүүд тайлбарлаж байна. Энэ хугацаанд урсах түлшний болон ажиллах хүчний зардал зэргийг аваад үзэхээр оргил ачааллаа импортоор авч хаах нь хамаагүй хямд тусдаг ажээ. Гэвч энэ байдлаас гарах гарц бийг мэргэжилтнүүд олж хараад, ажил хэрэг болгохын тулд ярьж хэлсээр долоон жилийн нүүр үзэж байгааг л энэ нийтлэлдээ өгүүлэх гэсэн юм.

УЦС-ын турбинууд хүчин чадлаа хормын зуур өөрчилж, эрчим хүчний боловсруулалтын тохируулагч болж чаддаг давуу талтай ажээ. Маневрлах чадвар муутай дулааны цахилгаан станцууд шиг горимоо авахын тулд хэдэн арван цаг сажлах шаардлагагүй! УЦС нь нэг товчлуур дараад л цахилгаан үйлдвэрлээд, оргил ачаалал буурангуут хөдөлгүүрээ зогсоож, усаа нөөцлөөд дараагийн оргил ачааллын үед ажиллаад явах боломжтойг мэргэжилтнүүд тэмдэглэж байна. Өөрөөр хэлбэл,

» усны эрчим хүч нь манай орны хувьд импортын хараат байдлаас гарах хөшүүрэг болж чадах юм. Энэ сайхан боломжийг эрх баригчид мэдсээр байж хэрэгжүүлэлгүй өдий хүрсэн нь гайхалтай. Сэргээгдэх эрчим хүч, тэр дундаа УЦС гэдэг нь Монголд ч, дэлхийд ч шинэлэг зүйл биш шүү дээ!

Эрчим хүчний дэлхийн хэрэгцээг 2030 он гэхэд сэргээгдэх эрчим хүчээр бүрэн хангах бололцоотой хэмээн АНУ-ын Стэнфордын их сургуулиас хийсэн судалгаанд дүгнэжээ. Норвеги, Парагвай, Канад зэрэг орны туршлагаас үзэхэд хүн төрөлхтөн нүүрсээр дулаан, цахилгаанаа хангахаас бүрмөсөн татгалзана гэвэл болохгүй зүйл үгүй ч юм шиг. Ер нь байгаль эхийг уйлахад хүргэж буй дулаарал, цөлжилттэй тэмцэж, экологийн тэнцвэрт байдлыг хадгалахын тулд улс орнууд уламжлалт аргаар нүүрс түлэн гал гаргахаас аль болох зайлсхийж, цэвэр эрчим хүчний салбараа хөгжүүлэхэд анхаарч эхлээд буйг мэдэхгүй хүн үгүй биз.

Сэргээгдэх эрчим хүч дотроо мэдээж УЦС томоохон үүрэгтэй. Усны эрчим хүчийг XIX зууны сүүлчээс л улс орнууд ашиглаж эхэлсэн боловч асар богино хугацаанд энэ салбар өргөжин тэлж байгааг тэмдэглэх нь зүйтэй болов уу. УЦС-ын экологийн болоод эдийн засгийн үр өгөөжийн талаар ярих ч юм биш. Зүгээр ч нэг сэргээгдэх эрчим хүч гэхээсээ илүү мөн ядуурлыг бууруулж, тогтвортой хөгжлийг авчирч чаддаг учраас хөгжиж буй болон буурай орнууд хүртэл УЦС-ыг ихэд шохоорхох болжээ. Дэлхий дээр эдүгээ 1.6 тэрбум хүн УЦС-ын тусламжтайгаар халуун хоол, дулаан орон гэртэй байгааг Дэлхийн банк онцолсон байна. Ялангуяа Африкийн орнуудын хувьд УЦС нь иргэдээ цахилгаанаар хангах сайн шийдэл болж буй ажээ. Учир юу гэвэл уснаас гаргаж авсан цахилгааны өртөг дулааны цахилгаан станцуудтай харьцуулахад хамаагүй хямд байдаг гэнэ. Тухайлбал, манай хойд хөршид УЦС-ын үйлдвэрлэсэн цахилгааны өртөг дулааны цахилгаан станцын боловсруулж байгаагаас хоёр дахин бага байдаг аж. Монголд ч мөн ялгаагүй. Дөргөний УЦС-

ын үйлдвэрлэж буй нэг кВт.ц цахилгааны тарифыг 32.11 төгрөг байхаар баталсан байдаг шүү дээ. Гэтэл өнөөдөр төвийн бүсийн эрчим хүчний компаниуд нэг кВт.ц цахилгаанаа айл өрх, аж ахуйн нэгжүүдэд 71-100 төгрөгөөр зарж байгаатай харьцуулаад үзэхэд л усны эрчим хүч ямар хямд, хэмнэлттэй байгаа нь ойлгомжтой болох биз ээ.

Эдүгээ дэлхийн нийт эрчим хүчний хэрэгцээний 20 орчим хувийг УЦС-ууд хангаж байгаа гэдэг. Энэ хэмжээгээр нүүрс түлж гаргах байсан хүлэмжийн хийн ялгарлыг бууруулж, экологийн тэнцвэрт байдлыг хангахад өөрийн үүргээ гүйцэтгэж байгааг нурших юун. Манай орны хамгийн том гол болох их уст Сэлэнгэ мөрөн дээр каскад-цуваа УЦС барих замаар цэвэр эрчим хүч гарган авч, Улаанбаатар болон Дархан, Эрдэнэт хотын утаа угаарыг арилгах боломжтойг мэргэжилтнүүд ярьдаг юм билээ. Тэгэхээр усны эрчим хүчийг мөн агаар цэвэршүүлэх үүднээс ч харж болох нь ээ. Аргагүй шүү дээ, нэг ч грамм нүүрс түлэлгүйгээр цахилгаан үйлдвэрлэх юм хойно.

Дэлхий даяар усны эрчим хүчний салбар хөгжихийн хэрээр техник, технологи нь ч улам бүр сайжирч, санаанд оромгүй томоохон төслүүд урагшилсаар. Зөвхөн нэг жишээ дурдахад Бразил-Парагвай улсын дундын эзэмшлийн 14000 МВт-ын Итайпу УЦС жилд 94 тэрбум кВт.ц цэвэр эрчим хүч үйлдвэрлэж рекорд тогтоож буй. Ийм хэмжээний цахилгаанаар дэлхийн бүх улс орны хэрэгцээг хоёр хоногийн турш хангаж болох ажээ. Харин Канад улс нь байгаль цаг уурын нөхцөл хийгээд хүн амын нягтралаараа манай оронтой нэн төстэй учраас сонирхол татах болов уу. Тус улс УЦС-аар жилдээ 350 тэрбум кВт.ц цахилгаан үйлдвэрлэж, усны эрчим хүчний үйлдвэрлэлээрээ дэлхийд толгой цохидог юм билээ. За тэгээд 50 тэрбум кВт.ц цахилгаан АНУ-д экспортолж байгаагаас үзэхэд УЦС нь Канадын хувьд байгальд ээлтэй цэвэр эрчим хүчээр зогсохгүй орлогын эх үүсвэр, “валютын үйлдвэр” болж чадаж байна шүү дээ. Энэ мэтийн сайхан туршлагаас судлах замаар монголчууд сэргээгдэх эрчим хүчний “ноу хау”-г эх орондоо

нутагшуулж, дэлхийн хөгжилтэй хөл нийлүүлэн алхах аятай боломж нээлттэй байна. 1997 онд Канадын Парламентын дарга Монголд айлчлахдаа усны эрчим хүчний өндөр технологитой гоотанилцуулж, хамтран ажиллах санал тавьсан удаатай бус уу? Ер нь усны эрчим хүчний үйлдвэрлэлээр манай урд хөрш дэлхийд тэргүүлэхдээ АНУ, Бразил, Канад болон ОХУ-ыг араасаа дагуулж буй ажээ.

Баруун бүсэд Дөргөний УЦС ашиглалтад орсон нь манай орны нөхцөлд усны эрчим хүчийг жилийн дөрвөн улирлын турш тогтвортой ажиллуулан ашиглах бүрэн боломжтойг нотолсон гэлтэй. Гэвч ний нуугүй хэлэхэд 12 МВт-ын Дөргөний УЦС, Тайширын 11 МВт-ын хүчин чадалтай станц нь даанч чамлахаар хэрэг юм. Учир нь манай улсын усны эрчим хүчний нөөц бүхэл бүтэн 56 тэрбум кВт.ц-аар үнэлэгдсэн байдаг ажээ. Энэ нь эдүгээ Монголд бүтэн жилийн турш үйлдвэрлэж буй нийт эрчим хүчнээс даруй 14 дахин өндөр үзүүлэлт гээд бод доо! Тиймээс бид төвийн болон зүүн бүсийн усны эрчим хүчний баялаг нөөцөө эдийн засгийн эргэлтэд оруулах хэрэгтэйг мэргэжилтнүүд сануулсаар. Азийн хөгжлийн банкны тусламжаар хийсэн Эрчим хүчний мастер төлөвлөгөө болон Эрчим хүчний нэгдсэн систем хөтөлбөрт ч гэсэн томоохон УЦС-уудын төслийг хэрэгжүүлэх талаар зөвлөмж тусгасан байдаг шүү дээ!

Харамсалтай нь монголчуудын дунд газар авсан буруу, ташаа ойлголт дэлхийн чиг хандлага Монголд нэвтрэхэд чөдөр тушаа болж байгаа юм. Байгаль орчин, цаг агаарын дулааралтай холбоотойгоор хур тунадасны хэмжээ буурч, Тайширын УЦС-ын ус нөөцлөх хугацаа нэг жилээр ухарснаас болж сэргээгдэх эрчим хүчний тухай сөрөг ойлголт манай нийгэмд бугшжээ. “Тайширын УЦС-ын ус дүүрэхгүй байна, тиймээс энэ нь бүтэхгүй эд юм байна” гэж энгийн иргэд төдийгүй эрх баригчид хүртэл заримдаа ярьж явдгаас хараад л ийм дүгнэлтэд хүрч болох юм. Ийнхүү дэлхийн чиг хандлагын эсрэг алхах хэрэг байна уу?

Цаг уурын өөрчлөлт, цөлжилт, дулаарал газар авахын хэрээр »

» хүн төрөлхтөн байгальд хал багатайхан шиг “гал гаргах” арга, саам сөвөгчилсөөр. Сүүлийн 10 жилд хамгийн хурдтай өргөжин тэлсэн усны эрчим хүч нүүрс түлэх уламжлалт аргыг орлох тал дээр хамгийн их найдлага төрүүлж буй. Харин монголчуудын хувьд УЦС нь цэвэр эрчим хүчний эх үүсвэр болоод зогсохгүй импортыг орлох хямд цахилгааны “ундрага”, оргил ачааллын үед аврах “удирдлага” болж чадах ажээ.

220 МВт-ын Эгийн голын УЦС-ыг барихад 350-400 сая ам.долларын хөрөнгө оруулалт хэрэгтэй гэж байсан. 220 МВт гэдэг чамлахаар үзүүлэлт биш ээ! Төвийн эрчим хүчний системийг нуруун дээрээ

үүрч буй ТЭЦ 4 маань 580, ТЭЦ 3 нь ердөө 136 МВт-ын хүчин чадалтай байгааг санацгаая. Мөн зөвхөн энэ хоёр станц хүчин чадлаараа ажиллахын тулд бараг дөрвөн сая тонн нүүрс түлнэ гэдгийг бодоод үзье. Нөгөө талаас дулааны цахилгаан станцыг 30 жил болоод л шинэчлэх хэрэгтэй болдог бол 100-гаас дээш жил ажиллах боломжтой байдаг УЦС нь үнэхээр улс орны хөгжлийг тогтвортой болгож чаддагийг амьдрал баталжээ.

Товчхондоо, томоохон УЦС-ыг барьснаар бид өсөн нэмэгдэж буй хэрэгцээгээ хангаад импорт гэдгийг таг мартаж болох нь. Мөн нэг ч грамм нүүрс түлэлгүйгээр

иргэдээ хямд бөгөөд байгаль орчинд ээлтэй ногоон эрчим хүчээр хангана гээд төсөөлөөд үз л дээ. Сайхан биш гэж үү?

Эгийн голын ТЭЗҮ-ийг Азийн хөгжлийн банкны тусламжаар хийсэн нь тоосонд дарагдаад хэвтэж байна. Мөн Сэлэнгэ мөрөнд 200 МВт, Орхон голд 100 МВт-ын боломжбайгааг мэргэжлийн хүмүүс тооцоолжээ. Эхний ээлжинд энэ гурвын аль нэгийг хөдөлгөх нь зайлшгүй шаардлагын нэг болсныг мэргэжилтнүүд ярьсаар байна. Цаасан дээр амилж, цаг өнгөрөх тусам тоосонд дарагдаж буй энэ мэт сайхан төслийг ажил хэрэг болгох л үлджээ. ■



Мороодол

Гурван хавцлын гайхамшиг

Хятадын эрх баригчид, эрчим хүчний салбарынхан энэ оны тавдугаар сард их ажлын ард гарлаа. Шар мөрнийг түшиглэн сүндэрлэсэн Гурван хавцлын цахилгаан станцад 14 жилийн нөр их хөдөлмөр шингэсэн бол өнөөдөр усан дор байраа эзэлсэн аварга том зургаан турбин хэвийн ажиллаж байгаа, эсэхийг нягтлан шалгах л үлджээ.

Шар мөрний Гурван хавцлын бүсэд аварга том далан барих

санаа нь шинэлэг зүйл байгаагүй юм. 90 гаруй жилийн өмнө Хятадын улс төрийн лидер Сүн Зонг Шан (Sun Zhongshang) энэхүү төслийг хэрэгжүүлэх санал гаргаж байжээ. Үүнээс хойш гадаад, дотоодын мэргэжилтнүүд энэ тал дээр олон тооны судалгаа хийж байв. Харамсалтай нь дэлхийн түүхэнд өмнө нь ийм том хэмжээний усан цахилгаан станц бүтээн босгож байсан түүх үгүй учир Гурван хавцлын далан гэдэг бүтэхгүй

мөрөөдөл мэт сэтгэгдэл төрдөг байжээ.

Харин 1992 онд БНХАУ-ын эрх баригчид барилгын ажлыг эхлүүлэх шийдвэр гаргасны дараа Засгийн газар нь ажилдаа яаравчлан орсон байна. Олон зуун жилийн турш Шар мөрөн эргээ даган амьдардаг хүмүүсийг үе үе үерлэн айдас түгшүүрт автуулдаг байв. Үүний хажуугаар хятадууд өсөн нэмэгдэж буй эрчим хүчний хэрэгцээгээ энэхүү усан цахилгаан станцаар

» хангах зорилго өвөртөлсөн юм. Ийнхүү нэг сумаар хоёр туулай буудах асар том төслийн барилгын ажил 1994 оны арванхоёрдугаар сарын 14-нд албан ёсоор эхэлсэн байдаг.

Шар мөрний ойр орчмын хүмүүс үерийн улмаас амь нас, эд хөрөнгөө алдаж ирсэн тухай дээр дурдсан. Сүүлийн 2000 жилийн хугацаанд аймшигт гамшиг 200 гаруй удаа болж, XX зуунд л гэхэд хагас сая хүний амийг авч оджээ. Зөвхөн 1931 онд болсон үерт 145 мянган хүн живж, хөдөө аж ахуйн 333 мянган га (hectares) газар сүйдэж байсан гээд бод доо!

22.1 тэрбум шоо метрийн усны нөөц бүрдүүлэх далан барьснаар энэ асуудлыг шийдэж болох байсан нь Хятадын эрх баригчдыг хөдөлгөх хүч болсон юм. Үүний хажуугаар 22400 МВт-ын хүчин чадал бүхий Гурван хавцлын усан цахилгаан станц жилдээ урд хөршийн нийт эрчим хүчний нийлүүлэлтийн есний нэгийг бий болгох тооцоо гарч байжээ.

Далан барихын тулд 1.2 гаруй сая хүнийг нүүлгэн шилжүүлснээс үзэхэд 28 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт шаардаж байсан энэ төсөл амар хялбар хэрэгжээгүй юм. Үүний хажуугаар Шар мөрөнд идээшдэг далайн гахай болон хилэм загасны амьдралд барилгын ажил яаж сөргөөр нөлөөлөхийг тооцоолж, аюулаас хамгаалах гээд олон асуудал тулгарч байсныг шийдэж чаджээ. Энэ бүхнийг даван туулсны эцэст цэвэр эрчим хүч үүсгэх замаар жилдээ 50 сая тонн түүхий нүүрс шатааж гаргах хорт утааг алга хийж, тэр хэрээр байгаль орчинд таатай нөлөө үзүүлж буй.

Хятадын ард түмэн өөрсдийн хүч хөдөлмөр болон олон улсын байгууллагуудын дэмжлэгтэйгээр Гурванхавцлын төслийг хэрэгжүүлж чадна гэдэгтээ бүрэн итгэж байсан аж. 2003 онд тэд их ажлынхаа анхны үр дүнг харж, эхний усан цахилгаан үүсгүүрээ ажиллуулж, эрчим хүч үйлдвэрлэж эхэлсэн байна. Өнөөдрийг хүртэл төслийн

барилгын ажил үргэлжилсээр, тус бүр 700 МВт-ын хүчин чадал бүхий 26 турбин ашиглалтад орсон байгаа. Жилдээ 100 тэрбум кВт.ц эрчим хүч үйлдвэрлэх хүчин чадал бүхий энэ нүсэр эд 2010 онд л гэхэд 84.37 тэрбум кВт.ц цахилгаан боловсруулжээ. Үүнийгээ 1000 км-ийн зайд хүргэж байгаа нь мөн алмайрам үзүүлэлт билээ.

Харин өнөөдөр 14 жилийн турш ажилласны үр дүнд сүүлчийн даваа буюу газар дорх зургаан турбиныг бэлэн болгож, зорьсон хэмжээндээ буюу 22400 МВт-ын суурилагдсан хүчин чадалтай болж байгаа юм. Энэ нь усан цахилгаан станцаараа зартай Бразил, Канад, Венесуэл, Парагвай зэрэг орныг ардаа орхиж, дэлхийд №1 болсон хэрэг. Гэхдээ Хятадын эрх баригчдын гол зорилго энэ байгаагүй ээ. Шар мөрний Жиан жин бүсэд аж төрдөг 15 сая хүн болон газар тариалангийн 1.5 сая га талбайг үерээс хамгаалж чадахаар болсон нь л энэ орны хувьд хамгийн баярт мэдээ билээ. ■

KHATAN TUUL

Pure Water



Packaging quantity of Pure water:

0.35 L /bottled/
0.6 L /bottled/
1 L /bottled/
19 L /balloon/

Маркетинг: 99071655
Захиалга авах утас: 70173386
Факс: 976-11-70174494

БИД МОНГОЛЫН ИРЭЭДҮЙГ БҮТЭЭЛЦЭЖ БАЙНА

“Оюу Толгой төслийн их бүтээн байгуулалтын энэ үед аюулгүй ажиллагааг жинхэнэ утгаар нь бий болгох хариуцлагатай ажилд хувь нэмрээ оруулж байгаагаараа бахархдаг. Бид аливаа эрсдлийг урьдчилан харснаар осол гэмтлээс сэргийлэх боломжтой гэж үздэг.”



Б.ГАНТУЛГА

Аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй хариуцсан Ахлах мэргэжилтэн



Оюу Толгойн Хөрөнгө оруулалтын гэрээ: Бодит баримтууд



Оюу Толгойн Хөрөнгө оруулалтын гэрээний тухай олон нийтэд илүү бодит ойлголт өгөх, уг төслөөс Монгол Улсад үзүүлэх үр ашгийг дахин таниулан хүргэх зорилгоор энэхүү баримтыг толилуульж байна.

Бид Оюу Толгойн Хөрөнгө оруулалтын гэрээний талаар тодорхой тайлбарласнаар Монгол Улсын Засгийн Газартай хийсэн хэлэлцээр шударга, ил тод явагдсаныг дахин нотлохыг хүсч байна.

Оюу Толгой төслийн зүгээс Хөрөнгө оруулалтын гэрээний гол заалтууд, ил тод байдлыг хангаж буйг илтгэх баримтуудыг толилуульж байна. Хөрөнгө оруулалтын гэрээний гол заалтуудыг дурдвал:

- Оюу Толгой нь дэлхийд томоохонд тооцогдох зэс-алтны хүдрийн биет бөгөөд

одоогоор тогтоогдсон нөөцийг үндэслэн 60 гаруй жил ашиглах боломжтой гэж тооцож байна. 2011 оны эцэс гэхэд Рио Тинто болон Айвенхоу Майнз компаниуд Оюу Толгой төсөлд нийт 4.5 тэрбум ам.долларын хөрөнгө оруулсан байх бөгөөд Хөрөнгө оруулалтын гэрээ батлагдах хүртэлх хугацаанд хайгуул, үнэлгээний ажилд нэг тэрбум гаруй ам.долларын хөрөнгө оруулсан юм.

- Оюу Толгойн Хөрөнгө оруулалтын гэрээг Монгол Улсын Ашигт малтмалын тухай хуулийн хүрээнд хэлэлцэн Монгол Улсын Засгийн газар, Рио Тинто болон Айвенхоу Майнз компаниуд гэрээнд гарын үсэг зурсан.

- Хөрөнгө оруулалтын гэрээний дагуу Монгол Улсын Засгийн газар Оюу Толгой төслийн 34%-ийг үнэ төлбөргүй эзэмших бөгөөд энэхүү хувь хэмжээ ямар ч нөхцөлд өөрчлөгдөхгүй. Мөн Засгийн газар өөрийн эзэмшлийн хувь хэмжээг 50% хүргэж нэмэгдүүлэх сонголт хийх боломжтой.

- Монгол Улсын Засгийн газар Оюу Толгой төслийн үр ашгийн ихэнх хэсгийг татвар хураамж, байгалийн баялаг ашигласны татвар (роялти) болон ноогдол ашгийн хэлбэрээр хүртэнэ.

- Монгол Улсын Засгийн газар төслийн хөрөнгө оруулалтанд өөрийн төсвийн эх үүсвэрээс ямар нэгэн байдлаар хөрөнгө оруулах шаардлагагүй. Айвенхоу Майнз болон Рио Тинто компаниуд Монгол Улсын Засгийн газрын нэрийн өмнөөс шаардагдах бүхий л санхүүжилтийг хийнэ.

- Оюу Толгой Монголчуудад мянга мянган ажлын байр, бизнесийн боломжуудыг бий болгоно. Оюу Толгой нь хувийн хэвшлийн хамгийн том ажил олгогчдын нэг бөгөөд одоогоор 9000 гаруй ажиллагсадтайн зэрэгцээ сургалт, ажлын байрны боломжуудыг бий болгосоор байна.

- Монголчуудыг ажилд авах, сургаж дадлагажуулах нь бидний тэргүүлэх зорилт юм. Хөрөнгө оруулалтын гэрээний дагуу уурхайн ашиглалтын жилүүдэд 10 ажилтны 9 нь Монголчууд байна.

- Монголын олон зуун аж ахуйн нэгж, хувь хүмүүс Оюу Толгойд бүтээгдэхүүн, үйлчилгээ нийлүүлж байна.

- Уурхайг дагасан дэд бүтэц тэр дундаа зам, эрчим хүч, ус, агаарын шугамууд нь Өмнийн говийн бүсийн эдийн засгийн хөгжилд чухал түлхэц болно.

Оюу Толгой ХХК-ийн Ерөнхийлөгч бөгөөд Гүйцэтгэх Ерөнхий Захирал Камерон МакРей "Айвенхоу Майнз Оюу Толгойн ордыг нээснээс хойш өнөөг хүртэлх төслийн ажил нь гагцхүү Хувь нийлүүлэгчдийн санхүүгийн дэмжлэгээр амжилттай явагдаж ирлээ. Рио Тинто, Айвенхоу Майнз компаниуд төслийг өнөөдрийн түвшинд хүргэхэд асар их хэмжээний хөрөнгө оруулалтыг хийгээд байна. Цаашид ч уурхайг барьж үйлдвэрлэлийг эхлүүлэх, дэлхийн түвшний стандартад нийцсэн үйл ажиллагаа явуулахад зориулж олон тэрбум ам.долларын хөрөнгө оруулалтыг хийсээр байх болно.

"Монгол Улсын Засгийн Газар болон ард иргэд Оюу Толгой төслөөс нийгэм, эдийн засгийн олон ач тусыг хүртэнэ. Олон улсын санхүүгийн байгууллагууд, судлаачдын зүгээс Оюу Толгойн Хөрөнгө оруулалтын гэрээнд хийсэн дүн шинжилгээнүүд нь уг гэрээг олон улсын тэргүүн туршлагыг шингээсэн болохыг баталж байна.

"Оюу Толгойгоос Монголчуудын хүртэх үр өгөөжийг Хөрөнгө оруулалтын гэрээгээр баталгаажуулсан бөгөөд нөгөө талаас уг гэрээ нь ирэх олон арван жилүүдэд Монголын эдийн засгийн бат суурь нь Оюу Толгой төсөл байна гэдгийг бататгаж байгаа юм.

"Хөрөнгө оруулалтын гэрээг Засгийн Газар дэмжиж буй нь хөрөнгө оруулагчдад итгэл өгч, төслийн шаардлагатай хөрөнгө оруулалтыг тодорхой болгож буй хэрэг юм. Түүнчлэн энэ нь олон улсын хөрөнгө оруулагчдад Монгол Улс бизнес эрхлэхэд нээлттэй гэдэг чухал дохиог өгч байна.

"Шударгаар хэлэлцэн тохирсон эрх зүйн баримт гэрээгээ туйлбартай сахин мөрдөх нь цаашид хэрэгжих томоохон төслүүдийн санхүүжилтийг босгоход Монгол Улсыг хүчирхэг байр суурьтай байхад нь тус дөхөм болно. Үүний үр дүнд томоохон төслүүдийнхээ үр шимээр Засгийн Газар үндэсний хэмжээний бүтээн байгуулалтыг өрнүүлж Монголын ард иргэдийн амьдралын чанарыг сайжруулахад нь дэмжлэг болж чадна гэж итгэж байна" хэмээн тэмдэглэн хэллээ.

Төлбөртэй нийтлэв



Түлш, шатахуун

SOS биш ээ! Зүгээр л сануулга...

Д.Мөнхчимэг

Хойд хөршийн гэнэтийн шийдвэрманай таксиныжолооцоос эхлээд Төрийн тэргүүнийг хүртэл сандаргаж дөнгөв. ОХУ бензиний экспортоо зогсоох шийдвэр гаргасныг дуулангуутаа Үндэсний аюулгүй байдлын зөвлөл даруй хуралдаж, сайд, дарга нар “орос ах нар” луугаа утас цохин, хэвлэлийнхэн Газрын тосны газар, Эрдэс баялаг, эрчим хүчний яам хийгээд импортлогчдын хаалгыг хэдэн өдрөөр манаж суух шив дээ. Тэгээд “Оросын хориг Монголд үйлчлэхгүй гэнэ ээ” гэсэн алт шиг сайхан мэдээг дуулангуутаа дор дороо тайвширцагасан нь бүр ч хөөрхийлөлтэй. Тавантолгойн “ялагч”-ийгөнөөмаргаашгүйзарлах гэж буй, тус ордын нүүрсийг зөөх төмөр замын асуудал шийдэгдэж байгаа энэ чухал цаг үед ОХУ бидэнд бензин өгөхгүй байж чадна гэж үү?

Монголд юу болов?

ОХУ тавдугаар сарын 1-нээс нефтийн бүтээгдэхүүний экспортоо зогсоох тухай

мэдээлэл цацагдсан даруйд л манай Үндэсний аюулгүй байдлын зөвлөл хуралдаж, нефтийн бүтээгдэхүүний импортын талаар авч хэлэлцсэн юм байх. Газрын тосны бүтээгдэхүүний хэрэгцээгээ 100 хувь гадаадаас хангадаг, түүнийхээ 90 гаруй хувийг ганцхан хойд хөршөөсөө авдаг Монгол Улсын хувьд оросуудын шийдвэр зүрхний шигдээс авчрах дөхсөн нь ойлгомжтой.

Өнгөрсөн дөрөвдүгээр сарын сүүлчийн өдрүүдэд монголчууд шатахуун тойрсон асуудлаар “амьсгалав”. Ядаж байхад барилга, зам засвар, уул уурхайн ажил эрчимжиж, хамгийн гол нь хаврын тариалалт эхэлж түлш, шатахууны хэрэглээ тэнгэрт хаддаг үеэр оросууд бензинээ “харамладаг” нь ч юу вэ дээ.

Газрын тосны газрын орлогч дарга Ц.Амараа “Одоогоор манай улсад шатахууны хангалттай нөөц бий” хэмээн бардам хэлж суух зуур Монгол Улсын эрх баригчид ОХУ-ын Засгийн газраас тодруулга авч амжсан тухай хэвлэлүүд шуугив.

Тэгээд “ОХУ-ын Засгийн газрын экспортоо зогсоох тухай шийдвэр Монгол Улсад хамаарахгүй гэж албан ёсоор мэдэгдсэн. Тиймээс манай улс өмнөхийн адил тус улсаас шатахууны хэрэгцээгээ хангах боломжтой” хэмээн Эрдэс баялаг, эрчим хүчний яамны Түлшний бодлогын газрын орлогч дарга Н.Болдхүү хэлсэн. Ингээд Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, салбарын яам болоод тэднийг шалгааж байсан сэтгүүлчдийн ч сэтгэл амарчээ. Гэтэл импортлогчид сюрприз барив! Тайван нойрсоод босоод ирсэн чинь бүх төрлийн түлш, шатахууны үнэ 80 төгрөгөөр нэмэгдчихдэг байгаа! Тэгээд яав? Мэдээж “буруутны” эрэлд гарав. “Ах нар” бид нарыг тусгайлан харж үзээд байхад энэ муу импортлогчид больмоор юм гэх мэдээлэл энд тэндгүй цацагдаж гарах нь тэр. Эрх баригчид ч хойд хөршөө “найрч”, тусгай эрх авсан юм болохоороо додигор сууна. Нийгмийн бухимдал импортлогчдыг чиглэж, “хадны

► мангаа” хэмээн цоллоно. Шударга өрсөлдөөн, хэрэглэгчдийн төлөөх газар ч яаж зүгээр суух вэ, мэдээж импортлогчдыг шалгаж эхэлсэн. “Үгсэн хуйвайлдаж, үнээ нэмсэн муу сайн импортлогчдыг шийтгээч ээ” хэмээн сэтгүүлчид үг, үзгээ уралдуулна.

Оросод юу болов?

Нефтийн нөөц хийгээд олборлолтоороо дэлхийд толгой цохидог ОХУ-ын ард түмэн “төмөр хүлгээ” тэжээх хоолгүй болж орхилоо. Алтайн хязгаараас эхэлсэн бензиний хомсдол нүд ирмэхийн зуур энэ орны олон арван мужид халдварлаж, хямрал дагуулахад хүрсэн нь сонин. Ядаж байхад өдрөөс өдөрт түлш, шатахууны үнэ өсөөд байхаар газрын тосоор даанч баян орос үндэстэн бухимдах нь аргагүй ээ.

Энэ асуудлын учиг бүр он солигдох мөчөөс л эхлэлтэй аж. 2011 оны эхний өдрөөс ОХУ-ын нутаг дэвсгэрт зөвхөн “Евро 3” стандартын бензин зарах шаардлагыг Засгийн газар нь тавьсан юм байх. Уг нь нутаг нэгтнүүдээ өндөр чанартай түлш, шатахуун хэрэглээсэй гэсэндээ гаргасан дээрх шийдвэр удалгүй бензиний хямрал дагууллаа. Учир юу гэвэл “Евро 3” стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ гэдэг ОХУ-ын цөөнгүй нефть боловсруулах үйлдвэрийн хувьд амаргүй даваа байжээ. Хаалгаа бариад техник, технологийн шийдэл эрсэн үйлдвэрүүдээс болоод зах зээлд бензиний хомсдол нүүрлэсэн гэнэ. Тэгээд мэдээж үнэ нь талийв. Өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж буй бензиний үнийг зохицуулахын тулд Засгийн газар нь өнгөрсөн хоёрдугаар сараас ханшийг зохиомлоор хазаарлаж эхэлжээ. Ингээд ихэнх шатахуун түгээх станц “дарамтлуулсан” үнээр бүтээгдэхүүнээ борлуулахад хүрэв. Аль нэг монополийн ивээлд багтдаггүй хараат бус шатахуун түгээх станцууд сул зогсохоос аргагүй боллоо. Яагаад гэвэл бензинээ экспортлох нь дотоодын зах зээлд хямд үнээр зарснаас хавьгүй дээр буюу тонн тутамд 2000-3000 рублийн ашигтай байсан тул монополь компаниуд


бүтээгдэхүүнээ гадагш зөөхийг илүүд үзжээ. Тус улсын Эрчим хүчний яамны мэдэгдсэнээр нефтийн бүтээгдэхүүний экспорт 67 хувиар өссөнөөс л бензиний хямрал нүүрлэсэн байна. Тэгээд энэ байдлаас гарахын тулд толгойд орсон ганц арга нь экспортоо хориглох явдал байлаа...

Нефтийн компаниуд тавдугаар сараас бүтээгдэхүүнээ гадагш гаргахгүй гэсэн ам өчгөө эрх баригчдадаа өгсөн тухай Оросын Эрчим хүчний сайдын орлогч Сергей Кудряшов мэдэгдсэнийг “РИА Новости” мэдээлсэн юм. Гэсэн ч энэхүү “дипломат” хэлэлцээг төрийн төмөр нударгаар “тамгалах”-ын тулд тавдугаар сарын 1-нээс нефтийн бүтээгдэхүүний экспортын татвараа 44 хувиар огцом өсгөж, тонн тутамд 408.3 ам.доллар болгох тухай тус улсын Ерөнхий сайд Владимир Путин өнгөрсөн дөрөвдүгээр сарын 28-нд мэдэгдсэн билээ. Энэ зохицуулалт хэр удаан үргэлжлэх нь тодорхой бус байгаа ч 2-5 сарын хугацаанд лав үйлчлэх төлөвтэйг учир мэдэх хүмүүс ярьсныг “Ведомости” сонинд онцолсон байна.

АИ 92 маркийн бензиний зах зээлийн ханш өнгөрсөн дөрөвдүгээр сард л гэхэд 18.8 хувиар огцом өссөн тухай “Интерфакс” мэдээлсэн. Дөрөвдүгээр сарын 10-нд 23600 рубль байсан нэг тонн АИ 92 маркийн бензиний бөөний үнэ тавдугаар сарын 10-нд 28900 рубль болтлоо цойлсныг <https://www.eoil.ru/> цахим хуудаснаас харж болох юм. ОХУ-ын монополийн эсрэг байгууллага буюу ФАС нефтийн компаниудаа шалгасаар, юу ч олж долоогоогүй хэвээр л... АИ 92 маркийн бензин хойд хөршийн зарим мужид 28 рубльд (ойролцоогоор 1260 төгрөг) хүрсэн бөгөөд тэнгэр чиглэн өсөх төлөвтэй үнэ цаашид ч хадгалагдах хандлагатай гэсэн мэдээлэл Оросын хэвлэлүүдийн тэргүүн нүүрт ярайсаар л... Бас л буруутныг эрнэ. Оросуудын хувьд бол “хадны мангаа” нь нефтийн монополиуд буюу “Роснефть”, ЛУКОЙЛ, ТНК-ВР, “Газпром нефть” зэрэг компани юм.

Жинхэнэ парадокс!

Монголбанкнаас гаргасан гадаад худалдааны тоймоос үзэхэд өнгөрсөн жил манай улс 678 сая ам.долларын нефтийн бүтээгдэхүүн оруулж ирсэн нь нийт импортын 20.7 хувийг эзэлж байна. Ингээд бодохоор түлш, шатахууны үнийн хэлбэлзэл манай эдийн засагт асар ихээр нөлөөлөх чадалтай. Гэтэл мөн хугацаанд бид хоёр сая 78 мянган баррель түүхий нефть экспортолсон нь 154.9 сая ам.доллар болжээ. Эх орондоо дусал ч бензин үйлдвэрлэдэггүй Монгол орны экспортын гол нэрийн барааны тоонд газрын тос нэлээд дээгүүр давхиж явааг юу гэж ойлгох вэ? Сүүлийн жилүүдэд манай орны түүхий нефтийн олборлолт, экспорт тогтмол нэмэгдэж ирснийг графикаас харахад ойлгомжтой биз ээ.



ОХУ-ын Засгийн газар нефтийн экспортын татвараа сар бүр шинэчлэн тогтоохдоо Urals маркийн түүхий нефтийн дэлхийн зах зээлийн ханшийг харгалзан үздэг. Он гарсаар “хар алт”-ны үнэ тогтвортой өсөж буй тул дээрх татварын хэмжээ ч сар бүр нэмэгдэж, тэр хэрээр манай эрх баригчид толгойгоо гашилгаж ирсэн нь үнэн. Засгийн газар маань дотоодын зах зээлд үнийн тогтвортой байдлыг хадгалж үлдэхийн тулд Оросуудын тогтоосон татварын хэмжээнээс шалтгаалан импортын автобензин, дизель түлшний онцгой албан татвараа дээш, доош хөдөлгөсөөр өдий хүрсэн. Гэтэл “ах нар” гэнэтийн бэлэг барьж, татварын хэмжээгээ 44 хувиар огцом өсгөсөн юм болохоор манай эрх баригчид онцгой албан татвараа огцом бууруулсан нь ойлгомжтой. Тэглээ гээд үнэ цаашид өсөхгүй, нефтийн нийлүүлэлт баталгаатай

► байна гэдгийг хэн хариуцах юм бэ? Оросууд өөрсдөө үнээ тогтоож дийлэхгүй байгаа өнөө цагт монголчууд түлш, шатахуунаа хямд авах баталгааг хэн өгөх юм бэ, манай Засгийн газар уу?

Өнгөрснийг нэхэн саная. 2008 оны хавар нефтийн бүтээгдэхүүний үнэ огцом өсөж эхэлмэгц импортлогчдыг татвараас чөлөөлж, татаас ч өгсөн удаатай. Тэглээ гээд үнэ өсдгөөрөө өссөн. Дэлхийн зах зээлд, тэр дотроо Оросод ханш нэмэгдээд эхлэхээр эх орондоо дусал ч бензин үйлдвэрлэдэггүй, 100 хувь гаднаас хараат манай орон бензиний үнийн тогтвортой байдлаа хангаж чадах уу?

Энд гарц байна...

Дотооддоо шатахуун нэрэх, нүүрснээс шингэн түлш гаргах зэрэг технологийг нэвтрүүлэх тал дээр анхаарах цаг хэдийнэ ирснийг Оросын бензиний хямрал, түүнээс үүдсэн Монголын бужигнаан гэрчлэх биз ээ. Санхүү, эдийн засгийн хямралаас өмнө буюу нефтийн бүтээгдэхүүний үнэ асар нэмэгдэх үед дээрх үйлдвэрүүдийг яаралтай барих хэрэгтэй хэмээн амтай болгон ярьж байсныг санаж байна. Гэвч сонин дээрээ соохолзоно гэгчээр үнэ буураад эхэлмэгц мартагдсан буюу. Сайншандын аж үйлдвэрийн цогцолборын хүрээнд газрын тос боловсруулах үйлдвэр, кокс химийн үйлдвэр байгуулна л гээд байгаа. Цаасан дээр “амилсан” дээрх сайхан нэрс амьдрал дээр хэзээ биелэх юм бол доо?

Монголын аж үйлдвэрийн корпораци Нүүрснээс шингэн түлш үйлдвэрлэх үйлдвэрийн төслийг хэрэгжүүлэхээр ХБНГУ-ын “Thyssen Krupp”-ын салбар “Uhde” компанитай хамтран ажиллаж, техник, эдийн засгийн үндэслэлээ хүртэл бэлэн болгоод гурав дахь жилтэйгээ золгож байна. Төв аймгийн Баян сумын Төгрөг нуурын ордод түшиглэн барихаар төлөвлөсөн эл үйлдвэр Coal-to-Liquid буюу CTL технологийн дагуу жилдээ нэг сая тонн бензин, дизель түлш гаргах хүчин чадалтай байх тухай танилцуулж байв. Өөрөөр хэлбэл, бид дотоодын хэрэгцээгээ хангаж чадах юм. Монголын аж

үйлдвэрийн корпорацийнхны хэлснээр уг үйлдвэр жилдээ 1.1 тэрбум ам.долларын бүтээгдэхүүн бий болгож, Монгол Улсын ДНБ-ийг 20-25 хувиар өсгөхөөр байв. Үүний хажуугаар газрын тосны үйлдвэр нэг биш, нэлээд хэд баригдах сурагтай байсан, яав? Өнгөрсөн оны сүүлчээр УИХ-ын дарга Д.Дэмбэрэл Японы “Тоёо Инженеринг” болон “Марубени” корпорацийн төлөөлөгчдийг хүлээн авч, Дархан-Уул аймагт нефтийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх төсөлтэй танилцаж байх зуур Ерөнхий сайд С.Батболд 2014 он гэхэд Сайншандад газрын тос боловсруулах үйлдвэр барина хэмээн ам гарч явсан санагдах юм. 2004 оноос хойш салбарын яаманд газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах талаар тавьсан 13 төсөл, санал байдаг гэх юм билээ.

Дархан-Уул аймагт япончуудтай хамтран газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг “Монголсэкию” компани аль эртнээс хөөцөлдөж, 2007 онд тусгай зөвшөөрлөө авсан байдаг. Тэгээд 2012 онд үйлдвэр ашиглалтад орно гэж байсан нь мэдээж худлаа болсон. Харин өнгөрсөн оны сүүлчээр тус компани Японы “Тоёо Инженеринг” болон “Марубени” корпорацитай гэрээ байгуулж, түүнийг нь төр, засгийн эрхмүүд хүртэл сайшаан баяр хүргээд байсныг бодоход бага ч гэсэн найдлага төрнө. Өдөртөө 44 мянган баррель газрын тос боловсруулах хүчин чадалтай үйлдвэр барих ажлыг энэ онд эхэлж, 2014 онд ашиглалтад оруулах учиртай. Уг үйлдвэрийг 600 сая ам.долларын хөрөнгө оруулалтаар байгуулах тухай манай хэвлэлийнхэн мэдээлж байсан.

Дэлхийн зах зээл дэх нефтийн үнэ нэг хувиар өсөхөд Монгол Улсын ДНБ-ий хэмжээ 0.1 хувиар буурна гэсэн тойм тооцоо байдгийг мэргэжилтнүүд ярьдаг. Гэтэл монголчуудын түлш, шатахууны хэрэглээ улам нэмэгдсээр. 2003 онд бид 441 мянган тонн нефтийн бүтээгдэхүүн импортолж байсан бол өнгөрсөн жилийн байдлаар энэ үзүүлэлт 864 мянган тоннд дөхөж очжээ. Эдүгээ уул уурхайн

томоохон төслүүд хэрэгжиж эхэлж буйтай холбоотойгоор газрын тосны бүтээгдэхүүний эрэлт, хэрэгцээ улам л нэмэгдэх төлөвтэй. Хамгийн “даруухнаар” бодоход л 2012 онд 1.1, 2015 он гэхэд 1.5 сая тонн нефтийн бүтээгдэхүүн шаардлагатай гэсэн тооцоог мэргэжилтнүүд гаргасан нь бий. Энэ хэрэгцээгээ бид яаж хангах вэ, хойд хөршөө л царайчлах уу?

Түлш, шатахуун нь стратегийн чухал ач холбогдол бүхий эдийн засгийн суурь үнийг бүрдүүлэгч бүтээгдэхүүний нэг юм. “Монголчууд болж өгвөл дотоодын хэрэгцээнийхээ 50 хувийг, болохгүй бол ядахдаа 30 хувийг өөрсдөө хангах хэрэгтэй” хэмээн Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны Хөгжил, хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Ганбаатар онцолж байв. Энэ ч утгаараа “Made in Mongolia” гэх шошготой шатахуун монголчуудын хувьд мөрөөдөл болоод удаж байна. Гэтэл Хүний хөгжил сангаас гаргаж буй 805.2 тэрбум төгрөгөөр нефть боловсруулах үйлдвэр байгуулчихаад, хэнийг ч царай алдалгүй додигор суух боломж бидэнд уг нь байжээ. Нөгөө талаас “Нүүрсний Саудын Араб” хэмээн Роберт Фрийдландаар өргөмжлүүлсэн Монгол орон нүүрсээ ашиглаад түлш, шатахуун, хий гаргаж авах технологи хэдийнэ бий болсныг эрх баригчид сайн мэднэ дээ.

Газрын тос болоод нүүрсээ түүхийгээр нь асар хямд үнээр гаргачихаад, өөрсдөө өндөр ханштай шатахуун авч хэрэглэсээр байх гэж үү? Тэгээд оросууд “шогтох” вий гээд дагжин чичирч суух уу? Энэ байдал үргэлжлэвээс үүцээ задалж, үсрэнгүй хөгжилд хүрнэ гэсэн монголчуудын найдвар хоосон мөрөөдөл болоод замхрах биз ээ. Оросын Засгийн газрын шийдвэр Монголд нөлөөлөөгүй, SOS зарлаад байхаар зүйл болоогүй нь үнэн. Гэхдээ энэ нь бидний хувьд нэгэн сануулга өгч байгаа бус уу? Сэрүүлэг дуугарлаа. Түлш, шатахууны хараат байдлаас гарахаар тэмүүлж, тэмцэх цаг болжээ. ■

Төвбанкуудыг заналхийлсэн аймшигт инфляци

Монголбанк бараг бүтэн жилийн турш гар хүрэлгүй өдий хүрсэн бодлогын хүүгээ 0.5 хувиар нэмж, 11.5 хувьд хүргэх шийдвэр гаргалаа. Зээлийн хүүг бууруулахын тулд чадах бүхнээ хийнэ хэмээн ам гарч байсан Төвбанкны эрхмүүд ийнхүү хэлсэн үгэндээ эзэн болоогүйн шалтгаан инфляци гэнэ.

Уг нь өнгөрсөн гуравдугаар сард инфляци буурч, жилийн 7.4 хувьтай гарснаар олон хүний гайхлыг төрүүлсэн. Гэвч энэ нь зөвхөн махны үнийн бууралтаас шалтгаалсан тухай Монголбанкныхан учирлаад, оны эцэст инфляци 15-20 хувьд хүрэх магадлалтайг санууллаа. Ингэснээр бид санхүү, эдийн засгийн хямралтай ахиад нүүр тулах аюултайг Төвбанкныхан мөн анхааруулсан юм.

Эдийн засагт хэт халалтын шинж тэмдгүүд илэрч, мөчлөг дагасан төсвийн бодлогоос зайлсхийж чадахгүй байгаа энэ үед инфляцийг “чөдөрлөх” ганц гарц нь мөнгөний хатуу бодлого ажээ. 2011 оны гуравдугаар сарын байдлаар мөнгөний нийлүүлэлт өмнөх оны мөн үеэс 67 хувиар буюу 1.98 их наяд төгрөгөөр өссөн нь цаашид ч үргэлжлэх төлөвтэй. Үүнээс улбаалан санхүүгийн системийн зээлийн өрийн үлдэгдэл мэдэгдэхүйц нэмэгдсэн байна. “Зээлийн хурдтай өсөлт болон төсвийн өндөр зардал нь инфляци нэмэгдэхэд нөлөөлсөөр байх болно” хэмээн Монголбанкны тэргүүн дэд ерөнхийлөгч Б.Жавхлан тайлбарласан.

Гэхдээ бодлогын хүүг 0.5 хувиар нэмлээ гээд инфляцийг нэг мөр “номхтож” байна гэвэл ташаа ойлголт болох биз ээ. Дотоодод мөнгөний нийлүүлэлт нэмэгдсэнээс



гадна гадаадаас шалтгаалах “импортын инфляци” манай орны хувьд ноцтой дарамт учруулж байгааг тэмдэглэх нь зүйтэй болов уу. Хүнсний бүтээгдэхүүнийхээ 70 хувийг импортоор хангаж, түлш шатахууныхаа хэрэгцээг тэр чигт нь Оросоос базаадаг монголчуудын хувьд бусад оронд үнэ хэрхэн хэлбэлзэх нь хамгийн их хамаатай. Гэтэл инфляци гэдэг зөвхөн Монголын биш, дэлхийн тулгамдсан асуудал болоод байна шүү дээ.

Энэ оны эхний хоёр сард дэлхийн хүнсний үнэ өнгөрсөн оны мөн үеэс 31 хувиар өссөн байгааг Азийн хөгжлийн банк анхааруулсан тухай <http://www.radioaustralia.net.au> цахим хуудсанд онцолжээ. Бөмбөрцгийн ядуучуудын гуравны хоёр нь амьдардаг Азийн хөгжиж буй орнууд хүнсний үнийн өсөлтөөс хамгийн ихээр хохирох тухай дээрх мэдээлэлд онцолсон байна.

Ер нь үнийн өсөлт дэлхийн улс орнуудыг баян, ядуу хэмээн ялгалгүйгээр хиар цохиж эхэлсэн билээ. Эдийн засгийн өсөлтөөрөө дэлхийг гайхшруулж буй Энэтхэг,

Хятадаас эхлээд газрын тосоор баян Булангийн орнуудыг ч инфляци тойрсонгүй. Чинээлэг, баярхуугаараа зартай Саудын Арабад өргөн хэрэглээний хүнсний үнэ энэ онд өсөн хувиар өсөх төлөвтэй. Инфляцийн дарамтыг жинхэнэ утгаар нь мэдрэлгүй олон жилийг үдсэн АНУ, Их Британи, Европын супермаркетууд хүртэл хүнсний бүтээгдэхүүнийхээ үнийн шошгыг байн байн сольж, эзэгтэй нарыг гонсойлгоход хүрээд буй. Дэлхийн зах зээл дэх газрын тос, улаанбуудай, кофены үнэ тэнгэр чиглэсэн хэвээр... НҮБ-ын тооцоолсноор өнөөдөр нэг тэрбум гаруй хүн өлсгөлөнгийн байдалтай амьдарч буй. Гэтэл цаг уурын өөрчлөлтөөс болж ургац хураалт муудаж, хүнсний нийлүүлэлт улам л хумигдсаар.

Бусад нь ямар арга хэмжээ авч байна вэ?

Инфляцийн дарамттай холбоотой зөвхөн Монголын Төвбанк мөнгөний бодлогоо чангаруулж байна гэвэл өрөөсгөл »

Эдийн засаг

► болно. Оросын Төвбанк он гарсаар хоёр дахь удаагаа бодлогын хүүгээ нэмж, тавдугаар сарын 3-наас 8.25 хувьд хүргэж байгаа юм. Хойд хөршид өнгөрсөн дөрөвдүгээр сарын 25-ны байдлаар инфляци 4.2 хувьд хүрсэн тухай мэдээлэл цацагдахад энэхүү үзүүлэлтийг жилийн 7.5 хувьд барихаар зорьж буй хойд хөрш сандрах нь гарцаагүй ажээ.

Хятадын Төвбанк өнгөрсөн дөрөвдүгээр сарын 21-нд банкуудын заавал байлгах нөөцийн хэмжээг 0.5 хувиар нэмж байгаагаа мэдэгдсэн. Он гарсаар дөрөв дэх удаагаа ийм арга хэмжээ авч байгааг “Bloomberg” онцолсон байна. Гуравдугаар сард урд хөршийн жилийн инфляци 5.4 хувьд хүрсэн нь сүүлийн 32 сарын дээд үзүүлэлт болсон юм. БНХАУ-ын эрх баригчид энэ онд инфляцийн үзүүлэлтийг дөрвөн хувьд барих зорилготой байгаа учир мөнгөний бодлогоо чангалахаас өөр замгүй ээ. Түүнчлэн бодлогын хүүгээ дөрөвдүгээр сарын 6-наас 0.25 хувиар өсгөсөн байна. Хятадын Төвбанк 2010 оны аравдугаар сараас хойш дөрөв дэх удаагаа бодлогын хүүгээ нэмсэн тухай

“Reuters” мэдээлсэн юм. Үүнээс дүгнэхэд урд, хойд хөрш маань мөнгөний бодлогоо чангаруулах аянд эргэлт, буцалтгүй орсон нь илт байна. Харин бусад орон яаж байгаа бол?

Европын Төвбанк санхүү, эдийн засгийн хямралаас хойш бодлогын хүүгээ нэмэх тал дээр хойргохандаж ирсэн билээ. Гэвч өсөн нэмэгдэж буй инфляцийг анзаарахгүй байж болсонгүй. Гуравдугаар сард евро бүсийн инфляци жилийн 2.6 хувьд хүрсэн нь сүүлийн 29 сарын дээд үзүүлэлт болжээ. Үүнээс үүдэн Европын Төвбанк сүүлийн хоёр жилийн турш өсгөхөөс цааргалаж ирсэн бодлогын хүүгээ өнгөрсөн дөрөвдүгээр сарын 7-нд нэмэхээс аргагүй байдалд орсон юм.

Гэхдээ АНУ, Их Британи, Япон зэрэг хөгжингүй орон ч мөн инфляцийн заналхийлэл дор байгаа боловч сул тавьсан мөнгөний бодлогодоо өөрчлөлт оруулах гэж яарахгүй байна. Англичууд өнгөрсөн оны сүүлчийн улиралд 0.5 хувиар хумигдсан ДНБ-ээ дорвитойхон өсгөчих хүсэлтэй байгаа бол япончууд гамшигт нэрвэгдсэн эх орноо бушуухан сэргээн босгох

зорилготой ажиллана. Энэ нь Их Британи, Японы Төвбанкны хувьд инфляцитай тулалдахаас чухал асуудал билээ. Харин Америкийн Холбооны нөөцийн системийн удирдлага “Бодлогын хүүг нэмнэ, гэхдээ цаг нь болоогүй..” гэсээр нэлээд урт хугацаа ардаа орхиж байгаа билээ.

“Дэлхийн зах зээл дэх хүнсний үнэ өссөөр байх уу? Инфляцийн өсөлтийг сатааруулахын тулд мөнгөний бодлогоо чангаруулах уу?” гэсэн эргэлзээ дэлхийн олон орны Төвбанкны хувьд “шүдний өвчин” болоод буй. Монголбанкныхан ч мөн эдгээр асуултаар толгойгоо гашилгаж буй биз ээ. Харин бизнес эрхлэгчдийн хувьд Төвбанк хүүг нэг удаа нэмээд л зогсох уу, эсвэл мөнгөний бодлогыг үе шаттайгаар чангаруулах уу гэдэг нь илүү чухал асуудал байх. Харин хорвоогийн хүн бүрт хамаатай нэг асуулт бий. Өнөөдрийн цайны талх, хоолны махны үнэ өчигдрийнхөөс өссөн байх уу, үгүй юу? Ийнхүү бүгд л дор дороо хүлээлттэй, толгой гашилгах асуулттай... ■

Худалдаа

Худалдагч нарт ёс зүй, худалдаанд хууль хэрэгтэй

И.Отгонжаргал

Улсын хөгжил хурдсахын хэрээр эдийн засагт гүйцэтгэх худалдааны салбарын үүрэг нэмэгдэж байна. Өнгөрсөн 20 жилд манай худалдааны салбар танигдахын аргагүй өөрчлөгджээ. Энэхүү өөрчлөлтөд сайн үр дүн ч бий бас анхаарахаас аргагүй болсон саар зүйл ч цөөнгүй аж. Тиймээс энэ оны төгсгөлөөр тохиож буй худалдааны салбарын 90 жилийн ойг угтаж ХХААХҮЯ худалдааны салбарын Хууль эрх зүйн зохицуулалт, бодлогын хүрээнд, Бодлогын хэрэгжилт, зохицуулалтын хүрээнд гэсэн хоёр чиглэлээр хийх ажлын төлөвлөгөөний урт жагсаалт гаргажээ. Түүний нэг нь ирэх зургадугаар сарын 10-нд болох “Монголын худалдаа: Бодлого-

шинэтгэл” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурал юм. Худалдааны салбарын асуудлыг хамаардаггүй салбар гэж бараг үгүй. Тэгээд ч тус салбарын хөгжил 90 жилийн түүхтэй ч өнөөдрийг хүртэл Худалдааны тухай бие даасан хууль ч байхгүй явж ирсэн нь хурдацтай хөгжил ярьж буй өнөө үед учир дутагдалтай юм. Гадаад худалдааны бодлогыг Гадаад харилцааны яам зангиддаг байх гэж боддог ч салбар болгон тус тусдаа гаргаж, хэрэгжүүлж байх жишээтэй. Худалдааны тухай хууль Монгол Улсын 50 гаруй хуулинд маш бага багаар бүр заримд нь нэг хоёр өгүүлбэрээр туссан байдаг гээд бод доо. Үүнд нэгдсэн хууль эрх зүйн орчин үгүйлэгдэж байгаа учраас

ХХААХҮЯ, ГХЯ хамтран Худалдааны тухай тусгайлсан хуулийн төсөл боловсруулж, Засгийн газарт өргөн барьсан байна. “Маш олон хуулинд туссан худалдаатай холбоотой бүх зүйл заалтыг Худалдааны тухай хуулинд авч оруулна гэж бол байхгүй. Ерөнхий бөгөөд бусад хуультай уялдсан байх юм” гэж



Эх сурвалж: ХХААХҮЯ

» ХХААХҮЯ-ны Хүнсний үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Ч.Энх-Амгалан хэллээ.

“Худалдаа гэдэг бол эдийн засгийн гол хөдөлгөгч хүч юм” гэж Гадаад харилцааны яамны Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны газрын дэд захирал С.Жавхланбаатарын хэлсэн нь бий. Тэгвэл хөдөлгүүр хэр хүчтэй байхаас эдийн засгийн хөгжлийн хурд хамаарах учиртай. Өнөөдрийн байдлаар манай гадаад, дотоод худалдааны байдал ямар дүр зурагтай байгааг зарим тоо баримтаар өгүүлнэ. Эхлээд гадаад худалдааны хувьд яривал 1990-ээд он хүртэл манай худалдаа цөөхөн улсаар хязгаарлагдаж байж. Харин өдгөө Монгол Улс дэлхийн 130 гаруй оронтой худалдааны хамтын ажиллагаатай. Түүнчлэн Монголын худалдааны салбар маш эрчимтэй хөгжиж байгааг харуулах том тоо баримт ч байна. Тухайлбал, 2010 онд гэхэд л манай гадаад худалдааны нийт эргэлт 6.2 тэрбум ам.долларт хүрчээ. Нэг үгээр хэлбэл, ДНБ-тэйгээ дүйцэхүйц хэмжээний худалдаа хийсэн гэсэн үг. Гэтэл 1990-ээд оны эхэнд энэ үзүүлэлт ердөө 200 гаруйхан ам.доллараар хэмжигдэж байсан аж. Ойрын жилүүдэд манайд уул уурхайтай холбоотой их бүтээн байгуулалт өрнөж байгаа тул худалдаа бүр ч их нэмэгдэх нь дамжиггүй.

2013 онд гадаад худалдааны эргэлт 12 тэрбум ам. долларт хүрч, одоогийнхоос хоёр дахин нэмэгдэх ч таамаглал бий. Тэр үед экспорт эрчимжиж, гадаад худалдааны тэнцэл ашигтай болох хандлагатайг холбогдох албаныхан онцлон тэмдэглэж буй юм.

Импортын хувьд аваад үзвэл хоёр хөрш маань тус бүр 30 орчим хувийг эзэлж байгаа аж. Үүнийг мэргэжилтнүүд баланс барьж байгаа гэж үзэж байна. Хоёр том зах зээлийн дунд хавчуулагдсан далайд гарцгүй улс учраас энэ нь хэвийн үзэгдэл гэнэ. Харин экспортын хувьд ихээхэн учир дутагдалтай тал ажиглагдах. Манай улсын экспортын 80 гаруй хувь нь БНХАУ-руу гарч байна. Мэдээж манай уул уурхайн бүтээгдэхүүний гол худалдан авагч урд хөрш. Экспортын 70 гаруй хувийг эрдэс баялгийн бүтээгдэхүүн эзэлж байгаа болохоор арга ч үгүй. Тэр дундаа зөвхөн нүүрсний

экспорт гэхэд л 30 хувьд хүрч байх жишээтэй. Тиймээс төр, засгийн зүгээс уул уурхайн бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулж, төрөлжүүлэхийн тулд эрдэс баялгаа дотооддоо боловсруулж, нэмүү өртөг шингээх бодлогыг чухалчилж буй. Энэ нэг хэрэг. Бусад салбарын экспортоо хэрхэн дэмжих вэ? Ганцхан урд хөршдөө хамаг бүтээгдэхүүнээ гаргаад суух уу? Экспортын шинэ зах зээл нээх тал дээр хэрхэн анхаарах вэ гэдэг бодлогоо тодорхойлж, шийдвэр гаргагчдын ойрын хугацаанд анхаарч, толгойгоо гашилгах асуудал болоод байна.

Гадаад худалдаанд дээр дурдсан ахиц дэвшил гарсан ч экспортын барааны нэр төрөл өнгөрсөн 20 жилд бага багаар буурсаар өнөөдөр тун бага хэмжээнд очжээ. Ялангуяа хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспорт бараг байхгүйтэй адил болсон нь харамсалтай. Жишээлбэл, 1980-аад оны дундуур хойд хөрш манай гадаад худалдааны эргэлтэд 83 хувийг эзэлж байжээ. Дангаараа шүү. Тус улсын манай экспортод эзлэх хувийн жин л гэхэд тухайн үед 80-аад хувьтай байсан байх жишээтэй. Гэтэл 2010 оны байдлаар ОХУ-ын манай гадаад худалдааны эргэлтэд эзлэх жин 20 хувьд ч хүрэхгүй болсон байна гээд бод доо. Экспорт, импортын үзүүлэлтээр нь аваад үзвэл хойд хөршийн экспорт 28, импорт 32.7 хувьтай байна. Энэ бол Монголын гадаад худалдаа алдагдалтай гарч байгаагийн дотор уламжлалт харилцаатай хойд хөршдөө бүр ч их алдагдалтай байгаа гэсэн үг. Монголын импортын хэмжээ буурч болно, экспорт эдийн засгийн хурд нэмэгдэхийн хэрээр өсөж байх учиртайсан. Энд 1980-аад онд хойд хөршид юу юу гаргаж байсан болоод экспорт өндөр байсныг сонирхоод үзье.

Хонины ноос 10.8 мянган тонн, тэмээний ноос гурван мянган тонн, адууны шир, ямаа, хонины арьс 65-315.1 мянган ширхэг, шевро, савхин эдлэл 54.7-175 мянган ширхэг, за тэгээд нэхий эдлэл, хивс, ноосон даавуу, ноолууран сүлжмэл, ноосон хөнжил, тарваганы арьс, улаан буудай, архи, мах, мал гээд хөдөө аж ахуйн гаралтай бүхий л бүтээгдэхүүнийг нийлүүлдэг байжээ. Цемент л гэхэд 6.8 мянган



Эх сурвалж: ХХААХҮЯ

тонн байх жишээтэй. Таван жилийн дараагаас буюу 1985 оноос дээрх бүтээгдэхүүнүүд дээр зэсийн баяжмал, молибдений баяжмал зэрэг уул уурхайн баялгийн экспорт нэмэгджээ. Нүүрс 1988 онд ОХУ-д 1,040.8 мянган тонныг нийлүүлж байв. Эдгээр бүтээгдэхүүний экспортын хэмжээ нь өссөн уруудсан ч 1990 оныг хүртэл тодорхой хэмжээгээр тасалдалгүй гаргасаар байж. Гэтэл 2010 оны байдлаар манай улсын хойд хөршдөө экспортолж буй барааны жагсаалт гарын арван хуруунд багтахар цөөхөн болжээ. Тухайлбал, жоншны баяжмал 510 мянган тонн, нүүрс 5.3 мянган тонн гарчээ. Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспорт тун бага. Хонь тэмээний ноос 0.1-0.5 мянган тонн, ноолууран сүлжмэл, ноосон хөнжил, мах гээд дуусчихаж байна. Хамгийн их хэмжээтэй гардаг байсан махны экспорт өнгөрсөн оны байдлаар 13.8 мянган тонн болж буурчээ.

Хөдөө аж ахуйн гаралтай эдгээр уламжлалт экспортын бүтээгдэхүүний экспортын

► нэмэгдүүлэх бүрэн боломж бий, манай улсад.

Нэгэнт худалдааны салбарын асуудлыг хөндөж буй учраас дотоодын зах зээлийн хөгжлийн тухай ярихгүй өнгөрч боломгүй. Өнгөрсөн онд худалдааны салбарын ДНБ-ий өсөлт 23.4 хувь, эзлэх хувийн жин 7.2 хувь байна. 2009 оны байдлаар улсын хэмжээнд идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа нийт аж ахуйн нэгжийн 39.8 хувь худалдааны салбарт байдаг гэсэн тооцоо бий.

Ер нь бол худалдаа хүн амыг хамгийн өргөн хүрээтэй хамардаг салбар юм. Тэр ч үүднээсээ хууль эрх зүйн зохицуулалт, бодлогын хэрэгжилтийг илүүтэй үгүйлж буй хэрэг. Худалдааны 90 жилийн ойг угтаж ХХААХҮЯ-наас Хууль эрх зүйн зохицуулалт, бодлогын хүрээнд хийх ажлын жагсаалтад “Худалдааны газар, түүний үйлчилгээ, ерөнхий шаардлага, стандарт”-ыг шинэчлэн боловсруулах, “Худалдагчийн ёс зүйн дүрэм” боловсруулах төлөвлөгөө гаргасан нь сайшаалтай.

“Жуулчдад хөтөч хийдэг дүү маань миний найзууд ч удахгүй ирэх нь дээ. Гэхдээ жуулчдад үйлчлэхэд хамгийн нүүр улаймаар асуудал

нь дэлгүүр хоршоогоор дагуулж явах. Манай худалдагч нарын үйлчилгээний соёлгүй, муухай зантай, бараа бүтээгдэхүүнээ хүнд танилцуулж мэдэхгүй. Англиар А үсэг ч байхгүй байдал нь үнэхээр ичмээр байдаг гэж ярьсан” хэмээн нэгэн танил маань сонирхууллаа. Инээмсэглэсэн эелдэг үйлчилгээ манай худалдааны салбарт үнэхээр үгүйлэгдэж байгаа зүйл. Тэгвэл Худалдагчийн ёс зүйн дүрмийг баталснаар худалдааны салбарын өнөөгийн таагүй үйлчилгээг халах болно гэж ХХААХҮЯ-ны газрын дарга Ч.Энх-Амгалан ярьсан.

Гадаад худалдааны тэнцлийг эерэг байлгахад анхаарах нэг зүйл нь дотоодын үйлдвэрлэлээ байгаа нөөц бололцоондоо түшиглэн хөгжүүлэх. Мэдээж мал аж ахуй, газар тариалангийн салбар хамгийн түрүүнд үүнд хамаатай. Тухайлбал, манай ноолуур дэлхийн босгыг алхахад ойрхон байна. “Атрын III аян”-тай холбоотойгоор газар тариалангийн үйлдвэрлэлд том ахиц гарсныг хэн хүнгүй мэднэ. Өнөөдөр бид төмс, улаан буудайн хэрэгцээгээ дотооддоо зуун хувь хангадаг болсон. Төмс, хүнсний ногоо, улаан буудайн экспорт сүүлийн жилүүдэд хэрхэн буурсныг графикаас

хараарай. Түүнчлэн импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлд сүүлийн жилүүдэд нөөшилсөн ногоо хүч түрэн орж ирж байгааг энд тэмдэглэхэд таатай байна. Ч.Энх-Амгалан даргын хэлснээр энэ чиглэлийн 4-5 өндөр хүчин чадалтай үйлдвэр байгуулагдаж үйл ажиллагаа явуулж буй аж. Мөн ойг угтаж Бодлогын хэрэгжилт, зохицуулалтын хүрээнд хийх ажлын төлөвлөгөөнд тусгасан ажлуудаас дуулгахад хүнсний аюулгүй байдлыг хангуулах чиглэлээр “Эрүүл зах-2011” аян орон даяар зарлажээ. Энэ нь эрүүл өрсөлдөөнийг бий болгох, салбарын өсөлтийг дэмжих, худалдааны орчин нөхцөлийг сайжруулах зорилготой гэнэ. Тавдугаар сарын 1-нээс эхэлсэн аяныг дүгнэх үеэр шилдэг худалдааны байгууллага тав, шилдэг худалдааны төв болон зах гурав, аяныг хамгийн үр дүнтэй зохион байгуулсан аймаг, дүүрэг нэгийг тус тус шалгаруулах юм. Үүнээс гадна удтал тасарсан худалдаа эрхлэгчдийн зөвлөлгөөнийг хийхээс гадна ДХБ-тай хамтарсан уулзалт зохион байгуулах аж.

Эцэст нь хэлэхэд, худалдааны салбарт тэр дундаа дотоодын худалдаанд шинэчлэлийн салхи үлээх нь. ■



Засуул төрийн эрэлд



Ч.Отгочулуугийн БУЛАН



Монгол түмэн дэлхийд юугаараа танигддаг вэ? гэсэн асуултын хариу их энгийн байх боломжтой. Чингисийн их байлдан дагуулал, онгон зэрлэг байгаль, хагас нүүдлийн соёл, уул уурхайн асар их баялаг гэх мэт. Гэвч сүүлийн үед энэ жижиг үндэстнээс дэлхийн урлаг, спортын тавцанд олон залуу авьяастан хүч түрэн гарч ирэх болсон билээ. Энгийн жишээ авахад нэг хүнд ногдох олимпийн наадмаар тухайн цагтаа БНМАУ өөрийн ах ЗХУ-аас дутахааргүй сайн байв. Сүүлийн жилүүдэд ч тэр 1000 хүнд ногдох олимпийн алтан медалийн тоогоороо дэлхийд эхний гуравдугаарт бичигдэж буй юм.

Бостон Баллетын гоцлол бүжигчин Монгол залуу Нью-Йоркийн сонгодог урлагийн тайзнаа өөрийн өнгө төрхийг нэмж буй бол Москва хотноо зохиогдсон дэлхийд алдартай олон улсын дуурийн дуулаачдын эрсэлт тэмцээнд 200 шилдгүүд өрсөлдсөнөөс монгол бүсгүй түрүүг нь авч байлаа. Өсвөрийн математикчдын олимпиадад ч, эсвэл шатарчдын уралдаанд ч тэр өсвөр насныхан маань айрагдсан дуулдаж л байдаг. Эндээс үзэхэд монгол авьяас дэлхийн тавцанд гологдохооргүй байна. Онцлог нь эдгээр нь бүгд л хувь хүний авьяас, мөн хүчин зүтгэлээс хамаарч буй юм. Мэдээж авьяастнуудын маань ард буй багш, дасгалжуулагч нарын хөдөлмөрийг энд дурдах нь зүйтэй. Гэвч багаар тоглодог спорт, багийн ажиллагаанаас бүрддэг бизнесийн салбарт монголчууд төдийлэн сайнгүй. Өөрөөр хэлбэл, авьяаслаг монголчууд маань багаараа, компаниараа эсвэл нийгэм, нийтээрээ хамтарч ажиллах болохоор л үзүүлэх амжилт нь бүдгэрээд байх шиг. Монгол ухаанаар “хахаж цацаж”, “ханхалж” байдаг улс төрчдийн маань бодлогын чадавч ч тийм сайн биш гэж хувийн хэвшлийнхэн үздэгийг Дэлхийн банк, Дэлхийн өрсөлдөх чадварын төв, Дэлхийн эдийн засгийн чуулга (Давосын форум) зэрэг байгууллагын судалгаанаас бэлхэн харж болно.

Дэлхийн эдийн засгийн тавцанд монголчууд түүхий эдийн супер нийлүүлэгч буюу тоглогч болон гарч ирлээ. Энэ нь гэхдээ Монголын эдийн

засагчид, улс төрчид, бизнесийнхэн сайндаа гэсэн үг бол мэдээж биш. Харин эцэг өвгөдөөс үлдэж ирсэн газар шороо, байгалийн хэвлийн үүцийг нээсэн хэрэг. Манайхтай адил жижиг үндэстнүүд биднээс дутахгүй сайхан амьдарч, санхүү, шинжлэх ухааны салбараа хөгжүүлж өөрсдийгөө тэжээж байна. Тодорхой хэлбэл, төр нь эдгээр салбарт бизнес эрхэлж буй компаниудаа зориудаар сайтар дэмждэг юм. Тэдэнд зориулж боловсролтой ажилтнуудыг нь бэлтгэж өгнө, тэдэнд зориулж зам барьж өгнө, ажлын байр бий болгох юм бол урамшуулж татварын хөнгөлөлт үзүүлнэ, гадаадын ижил төстэй компаниудтай “олон улсын рингэнд зодолдох” -д нь ил далдаар дэмжинэ. Америкийн капитализмын бэлгэ тэмдэг болсон “Женерал Моторс”-ыг ид мандаж байх үед “ЖМ-д сайн бол тэр нь АНУ-д ч сайн” гэсэн утга бүхий уриа хүртэл гарч байжээ.

Гэтэл Монголд байдал өөр. Гаднынхантай өрсөлдөх нь бүү хэл, дотроо ажлын байр бий болгох гэж ядаж буй хувийнхныг төр нь дэмжих гээд байгаа ч юм шиг, дарамтлах гээд байгаа ч юм шиг. Төрийн үндсэн үүрэг болсон нам инфляци, эрх зүйн тогтвортой орчин, боловсролын чанар, дэд бүтэц зэрэг нь социалист, капиталист чиг баримжаатай нь ялгарахгүй болжээ. Нөөц баялаг нь улам бүр багасаж буй дэлхий ертөнц дээр мэдлэг, хүн, нөөцийн төлөө ширүүн өрсөлдөөнөөр тодорхойлогдох цоо шинэ энэ цаг үед Монголын эдийн засаг “зэсийн засаглал”-ын ноёрхлоос “зэс-нүүрсний засаглал”-ын ноёрхол руу аажмаар шилжиж байна.

Уул уурхайн компаниуд ашигтай ажиллахын хэрээр чадалтай боловсон хүчнийг бүхий л салбараас “ховх сорох” болов. Өндөр цалин, байр, унааны тааламжтай нөхцөл амлах замаар банк, аялал жуулчлал гэх зэрэг үйлчилгээний салбарын ажилтнуудыг өөртөө урвуулах боллоо. Уул уурхайн салбарын экспортын орлогоос үүдэн төгрөгийн ханш чангарч байна. Энэ нь эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж экспортод гаргадаг, эсвэл гаднын жуулчдаас гадаад валютаар орлогоо олдог компаниудын хувьд туйлын

таагүй байдал үүсгэх аюултай. Учир нь, орох орлогоо өндөр ханшаар тооцсон үед гадаад валютын ялангуяа ам.долларын ханш унах нь тэдний ашигт сөргөөр нөлөөлөх юм.

Уул уурхайн бус салбарынхны хувьд ийнхүү зардал өсөж, ашиг буурах үзэгдлийг Голланд өвчин гэдэг. Зүйрлэвэл айлын хотонд хэдэн том биетэй тэмээ орж ирээд тэнд байсан бог малыг хөөж гаргаснаас өөрцгүй.

Энэ нөхцөлд төрийн үүрэг ямар байх вэ? Эдийн засаг дахь төрийн оролцоо ямар байх ёстой вэ?

Бид уул уурхайн бус салбаруудаа хэрхэн олон улсын зах зээлд бэлтгэх талаар анхаарах ёстой. Эдгээр салбарт ажиллахаар очиж буй төгсөгчдийн мэдлэг, чанар олон улсын шаардлагыг хангахуйц байж энэ өөрчлөлт хийгдэнэ. Харин энэ талаар төрийн оролцоо тун болхи хэвээр байгаа юм. Улсын нэртэй хэдэн их, дээд сургуулийн удирдах зөвлөлд тэр чигээрээ улс төрчид суухыг өнөөдөр бид төрийн сайн оролцоо гэж хараад дасчихаж. Гэтэл хааяа хэдэн хүүхэд шахахаас өөр ид шидгүй, хуралдаа ирж шийдвэрээ гаргаж өгдөггүй тэдгээр улс төрчдөөс болж их, дээд сургуулиудад хийгдэх ёстой реформ хийгдэж чадахгүй байна. Хөшүүн удирдлагын тогтолцооноосоо болж их, дээд сургуулиудын бүтээгдэхүүнүүд зах зээлийн эрэлтийг хангахуйц уян хатан байж чадахгүй байна.

Гадаад ертөнц хувьсан өөрчлөгдөж байна. Монгол Улс ч гэсэн хувийн хэвшлийнхний шургуу хөдөлмөрөөр нүүр царайгаа алгуур өөрчилж, байгалийн хэвлийд биш, хүний овсгоо самбаандаа найдаж хөгждөг орон болох замдаа алгуур гулссаар буй юм. Гэвч бидэнд сэтгэлгээний өөрчлөлт хэрэгтэй. Өнөөдөр дэлхийн зах зээлд төр өөрөө биш, харин хувийн хэвшлийнхэн өрсөлдөнө. Хувийн хэвшлийнхэн маань дэлхийн дэвжээнд зодоглохор дэвж буй хүчит бөхчүүд билээ. Харин төр маань ердөө л бөхийн засуул юм. Хясуул биш, засуул төр болсон цагт монголчууд бид “зэсийн засаглал”-аас “зах зээлийн засаглал” руу шилжсэн гэж хэлэх эрхтэй болох билээ. ■

Монголын хөгжлийг тэтгэх банк үүдээ нээлээ



2011.05.13. Эл өдөр Монгол Улсын “Хөгжлийн банк”-ны үүдийг нээж, өрхийг татлаа. Засгийн газрын II байр буюу хуучин Сангийн яамны байрны нэгдүгээр давхрын баруун жигүүрт төвхнөж буй “Хөгжлийн банк”-наас будагны үнэр ханхална. Монгол Улсын “Хөгжлийн банк”-ны удирдлагын багийг сонгон шалгаруулах олон улсын нээлттэй тендерт БНСУ-ын Хөгжлийн банк /KDB/ шалгарсан. Тус банктай байгуулах гүйцэтгэх удирдлагын гэрээ хэлэлцээрийг ойрын хугацаанд багтаан дуусгахаар “Хөгжлийн банк”-ны ТУЗ ажиллаж байгаа аж. Түүнчлэн гүйцэтгэх удирдлагын 50-иас доошгүй хувь нь Монгол Улсын иргэн байх тухай “Хөгжлийн банк”-ны хуулийн заалтыг баримталж ажиллаж байгаа гэсэн.

Нээлтийн ёслолын үеэр Ерөнхий сайд С.Батболд “Энэ онд улсын төсвөөр 680 гаруй тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөсөн. Үүний зэрэгцээ 800 тэрбум төгрөгийн бонд гаргана гэдэг бол Монгол Улсын эдийн засагт өсөлтийн ямар их боломж байгаагийн баталгаа. Цаашид хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх боломж бий. Уул уурхайн салбарын орлогыг Монгол Улсын хөгжилд чиглүүлэх үндсэн механизм бол “Хөгжлийн банк” байх ёстой” хэмээн онцлон тэмдэглэлээ.

“Хөгжлийн банк”-ны 800 тэрбум төгрөгийн бондыг хэн авах вэ гэдэг нь сонирхолтой асуулт хэвээр буйн сацуу тус банк хамгийн түрүүнд ямар төсөл санхүүжүүлэх вэ гэдэг хэвлэлийнхний сонирхлыг татсаар. “Банкнаас санхүүжилт хийх төслийн хувьд эхний ээлжинд “Шинэ бүтээн байгуулалтын дунд хугацааны зорилтот хөтөлбөр”, “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”, “Сайншанд аж үйлдвэрийн цогцолбор”, Монгол Улсыг хэрсэн авто замын болон эрчим хүчний сүлжээг тэтгэнэ. “Хөгжлийн банк”-ны ТУЗ-ын дарга бөгөөд Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны дарга Ч.Хашчулуун “Эрчимтэй хөгжлийн гараан дээр ирсэн Монгол Улсад уул уурхайн салбараас орж ирэх орлогоороо эдийн засгийн өсөлтийг тэтгэх тусгайлсан байгууллага хэрэгтэй болсон. Энэ бол Хөгжлийн банк. Ингэснээр манай улсын дэд бүтэц, өрсөлдөх чадварыг сайжруулах, үндэсний боловсруулах аж үйлдвэрийг хөгжүүлэх, нэмүү өртөг бүтээх салбарыг бодлогоор тэтгэх хүчтэй хөшүүрэг бий боллоо” гэж “Хөгжлийн банк”-ны ач холбогдлыг нь тодорхойллоо.

Хөгжлийн банк нь улсын эдийн засгийн хөгжлийг түргэтгэх томоохон төслүүдэд оновчтой хөрөнгө оруулалт хийх зорилгоо хэрэгжүүлэх үүднээс 800 тэрбум төгрөгийн өрийн

бичиг гаргах тухай Засгийн газрын тогтоол гарсан билээ. Үүний 250 тэрбум төгрөгийг таван жилийн хугацаатай, мөн хэмжээнийхийг 10 жилийн хугацаатай, 300 тэрбум төгрөгийнхийг 15 жилийн хугацаатай гаргах юм. Нээлтийн үеэр сэтгүүлчид Ч.Хашчулуун даргаас дээрх бондын борлуулалт болон хүүний талаар лавлахад “Бондын зээлийн хүүг хэд байлгах вэ, хэнд худалдаж болох вэ гэдгийг нарийн судалж байна. Энэ чиглэлээр ойрын хугацаанд хөрөнгө оруулагчдын форум зохиох бодолтой байна” гэв.

Монгол Улсад “Хөгжлийн банк” байгуулж байсан түүх, туршлага байхгүй учраас тус банкны менежментийн багаар БНСУ-ын KDB тодорсон ч япончуудтай зөвлөгөө авах байдлаар хамтарч ажиллаж байгаа билээ.

Дээрх ёслолын арга хэмжээний туузыг хайчилж, нээлтэд оролцсон Засгийн газар, УИХ, Монголбанк зэрэг төр, засгийн байгууллагын төлөөлөгч болох эрчүүдийг нэгэн эмэгтэй чимэглэсэн нь “Хөгжлийн банк”-ны дэд захирал Л.Болормаа байлаа. Богино үстэй, дунд зэргийн нуруутай тэрбээр МУИС-ийг Банк, санхүүгийн чиглэлээр дүүргэсэн бөгөөд АНУ, Японд мэргэжлээрээ эрдмийн зэрэг хамгаалжээ. Тэрбээр ХБНГУ-ын “Дойче” банкинд ажиллаж багагүй туршлага хуримтлуулж 15 жилийн дараа эх орондоо ажиллахаар иржээ. Л.Болормаа “Эх орондоо ирэх болсон гол учир бол Хөгжлийн банкны тухай миний төсөл болов уу. Би үргэлж чадвараараа ажил олж, хийж ирсэн. Өөрөөр хэлбэл, би эх орондоо өөрийн гэсэн төсөлтэй ирсэн. Түүнийгээ хэрэгжүүлэх боломж гарч байгаад баяртай байна” хэмээн хэн нэгэн сайд, даргын татаасаар “Хөгжлийн банкны дэд захирлаар томилогдсон байж магадгүй гэсэн сэтгүүлчдийн харыг тайлсан юм.

“Хөгжлийн банк”-ны туг, логоны хувьд тэнгэрийн хөх өнгө дээр өлзий хээ тавьсан нь Монгол орны дөрвөн зүг, найман зовхист бүтээн байгуулалтыг өрнүүлж, хөрөнгө мөнгөө арвижуулж, өлзий буянтай ажиллана гэдгийг бэлгэдсэн аж. ■



Рейтинг

Луугийн өсөлт

Олон улсын валютын сангийн таамаглал сенсаац дэгдээв. 2016 он гэхэд Хятадын эдийн засаг Америкийг ардаа орхиж, дэлхийд тэргүүлнэ хэмээн уг байгууллагын мэргэжилтнүүд дүгнэжээ. АНУ-ын эдийн засаг 1890-ээд оноос тухайн үеийн лидер Их Британийг шахан дэлхийд тэргүүлж эхэлсэн бөгөөд хэн нэгэнд байраа тавьж өгөлгүй өдий хүрч байна. Гэхдээ дэлхийн тэргүүлэх эдийн засгийн эзэн халаагаа хятадуудад өгнө хэмээн шинжээчид нэлээд хэдэн жилийн турш ярьж байгаа юм. Гол нь үүний тулд дахиад 15 жил шаардлагатай гэж таамаглаж байв. Гэтэл яагаад энэ хугацаа 10 жилээр нашилчихав аа?

Олон улсын рейтингийн агентлаг болох "Standard & Poor's" энэ ертөнцийн хамгийн найдвартай зээлдэгч хэмээн тооцогддог Америкийн зэрэглэлийг бууруулж, "тогтвортой"-гоос "сөрөг" болгосон билээ. Тус улсын өр гэрлийн хурдаар нэмэгдэж, 14.2 их наяд ам.долларт хүрсэн нь ДНБ-тэйгээ дүйцэх болов.

Дэлхий даяараа эдийн засгийн өсөлтөө хадгалах, хангах гэж мэрийж байх зуур хятадууд тэс өөр бодлого баримталж буй. "БНХАУ-ын эрх баригчид орон сууцны үнийг тогтоон

барихад гол бодлогоо чиглүүлж байна. Түүнчлэн хүнсний үнэ цаашид ч өсөх төлөвтэй байгаагаас инфляцийг бууруулахад анхаарах болсон" хэмээн Дэлхийн банкны Хятадыг хариуцсан тэргүүлэх эдийн засагч Ардо Ханссон онцолсон юм. Урд хөршид инфляци 5.4 хувьд хүрсэн нь SOS зарлахуйц түвшин гэнэ. Үнийн өсөлтийг "чөдөрлөх"-ийн тулд Хятадын Төвбанк хэд хэдэн удаа бодлогын хүүгээ нэмж, мөнгөний бодлогоо чангаруулж буй. Гэхдээ л Хятадын өсөлт дэлхийг алмайруулсан хэвээр. Тус улсын ДНБ энэ онд 9.3 хувиар өсөх төлөвтэйг Дэлхийн банк мэдэгдсэн юм.

Гэхдээ Хятадын нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ ердөө 4000 доллар байгаа нь маш бага үзүүлэлт билээ. Өөрөөр хэлбэл, хятадуудад хийх зүйл их байна. Хүн амын тоогоороо энэ орон Японоос 10 дахин давж буйгаас үзэхэд эдийн засгаа илүү тэлэх боломжтой нь харагддаг.

XXI зууны эхний 10 жилийг эдийн засгийн хэмжээгээрээ долдугаар байрт жагсаж эхэлсэн БНХАУ бүх өрсөлдөгчөө гүйцэж түрүүлсээр АНУ-ын дараа орж, аман хүзүүдсэн билээ. 2000 онд Италийг, 2005 онд Францыг, 2006 онд Их Британийг,

2007 онд ХБНГУ-ыг ардаа орхиж, 2010 оны сүүлчээр Японы өмнө жагсах болсон. Японы эдийн засаг сүүлийн 30 жилийн хугацаанд тасралтгүй эзэлсэн байр сууриа Хятадад яагаад алдчихав аа?

1980-аад оны эхээр Дэн Сяопины шинэчлэлийг дөнгөж эхлүүлж байсан энэ орон өнөө үетэй харьцуулахад даанч танигдахааргүй байжээ. Ядуу буурай урд хөрш маань тодорхой хэмжээгээр үйлдвэржсэн байсан ч барууны орнуудтай харьцуулах нь инээдтэй хэрэг байв. 1990 онд Хятадын ДНБ өсөж, 390 тэрбум ам.долларт хүрч байх үед Японых гурван их наяд доллараас ч давчихсан тууж явсныг дурсахад илүүдэхгүй биз. Гэтэл гадаадаас үйлдвэрлэлийн технологи шууд импортлох замаар үйлдвэржилтийн эхний шатаа дуусгасан хятадууд эрч хүчээр дүүрэн ажиллаж гарах нь тэр. Ингээд Азийн хамгийн том бар болох манай урд хөрш гангийн үйлдвэрлэл, электрон барааны угсралт, бөс барааны хувьд дэлхийд толгой цохиж эхэллээ. 1998 онд Хятадын ДНБ Азийн эдийн засгийн хямралыг үл харгалзан нэг их наяд ам.доллараас давсан юм. Ер нь манай урд хөрш хямралыг ажралгүй даваад зогсохгүй ашиг олж чаддагаа ▶

► нэг бус удаа баталсан билээ.

2008 онд эхэлсэн дэлхийн санхүү, эдийн засгийн хямрал Хятадыг улам хүчирхэгжүүлсэн тухай эдийн засагчид тайлбарладаг. Дэлхийн бүх улс орон хүнд байдалд орсон байхад зөвхөн хятадууд л од шүүрч чадсан юм. Монголчууд зэсийн үнэ тонн нь 4000 доллараас доош ороход л эдийн засгийн уналт, төсвийн алдагдал, валютын ханшийн хэлбэлзэлд хиэр цохиулж, өрөвдөлтэй байдалд орсон. Тэгээд Лондоны металлын бирж дэх зэсийн үнэ өсөхийг нүдээ чилтэл харж, хүлээж суусан. Харин хятадууд эсрэгээрээ, хямралаас болж түүхий эдийн үнэ унасан үеийг ашиглаад их бүтээн байгуулалтын ажилдаа шамдан орж байв.

АНУ, Япон, Европын орнууд “сульдаа”-тай байх үед хэчнээн ч томоохон банк, компанид өөрийн нөлөөгөө бататгаж амжив даа. Сүүлийн гурван жилийн хугацаанд Хятадын төрийн өмчит компаниудын дэлхийн өнцөг булан бүрт худалдаж авсан алт, зэс, нефтийн ордуудын тоо ч тоймоо алдсан. Одоо ашигт малтмалын үнэ өсөөд эхэлсэн учраас хямралын үед хятадуудын задгай мөнгөө шажигнуулан худалдаж авсан ордуудын үнэлгээ хэд дахин өссөн билээ.

2010 оны байдлаар АНУ-ын ДНБ 14.6 их наяд ам.доллар байгаа нь Хятадынхаас 2.5 дахин өндөр үзүүлэлт юм. Гэхдээ 1980 онд бол америкчууд Хятадаас 14 дахин том эдийн засагтай байсныг сануулах

нь зүйтэй болов уу. Үүнээс үзэхэд гэрлийн хурдаар цойлж буй БНХАУ таван жилийн дараа америкчуудыг ардаа орхиж чадахгүй гэх аргагүй. Ер нь олон мэргэжилтэн хятадууд АНУ-ыг ардаа орхиж, эдийн засгийн хэмжээгээрээ дэлхийд тэргүүлнэ хэмээн итгэдэг. Гол нь хэзээ вэ гэдэгт л байгаа юм. “Deutsche Bank” банкны шинжээчдийн үзэж буйгаар энэ нь 2020-иод оны эхээр болох бол “Standard Chartered” энэ арван жилийн сүүлчээр тохионо гэж үзэж буй. “Goldman Sachs”, “Price-waterhouse Coopers” гээд бүгд л өөр өөрсдийн тоог хэлдэг. ОУВС болохоор 2016 онд энэ түүхэн үйл явдал болно гэлээ. Хэн нь илүү дөхүүлснийг хүлээх л үлдэх шив дээ. ■

Дуулиан

Доминик Стросс-Каныг хэн орлох вэ?

Францын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвших хамгийн хүчтэй өрсөлдөгчдийн тоонд орж байсан, Олон улсын валютын сангийн тэргүүн, 62 настай Доминик Стросс-Кан Нью-Йорк хотын зочид буудлын үйлчлэгч эмэгтэйг хүчиндэхийг завдсан хэрэгт холбогдсоныхоо дараа өөрийн хүсэлтээр огцорсон билээ. Тэрбээр энэ тухайгаа ОУВС-гийн Гүйцэтгэх удирдлагад албан ёсны захидлаар мэдэгдэхдээ: “Хүндэтгэн, зүтгэл гаргаж ажиллаж байсан хамт олноо би хамгаалмаар байна. Тэднийхээ нэр хүндэд сэв суулгасан нь харамсалтай. Би бүхий л хүч чадал, цаг зав, эрч хүчээ өөрийн гэмгүй гэдгээ нотлоход зарцуулахыг хүсэж байна” гэжээ. Түүнчлэн өөрийг нь буруутгаж байгаа зүйл ор үндэсгүй гүтгэлэг гэдгийг цохон тэмдэглэхээ мартсангүй.

Франц улсын Ерөнхийлөгч Николя Саркозигийн хамгийн том өрсөлдөгч хэмээн өнөөг хүртэл тооцогдож байсан Социалист намын Стросс-Кан буруутай гэдэг нь нотлогдох юм бол 25 жил шоронд суух ял эдэлж болзошгүй ажээ. Ямартай ч ОУВС-гийн шинэ захирал томилогдох хүртэл Стросс-Каны орлогч Жон Липски түүний албан үүргийг гүйцэтгэж буй.

Америкийн шүүгч Мелисса Жексон Стросс-Каныг нэг сая ам.долларын барьцаатайгаар батлан даалтад

гаргахаас татгалзсан. “Julius Baer & Co” банкны Хөрөнгө оруулалтын ахлах ажилтан Венкатраман Ананд Нагесваран “Стросс-Кан нь чухал хүн учир хэдийгээр огцорсон ч ОУВС-д том сүүдэр туссаар байх болно” гэж мэдэгдсэн байна. “Стросс-Кан Европын улс төр, эдийн засгийн байдлыг маш сайн ойлгодог хүн. Европын санхүүгийн байдал хүнд байгаа өнөө үед түүнийг орлож чадах хүн олдоход хэцүү л болов уу. ОУВС-д түүн шиг хүн байгаа гэж би бодохгүй байна” хэмээн Канадын Төвбанкны удирдагч асан Дэвид Дож ярьжээ. Харин ОУВС тэргүүнээ энэ оны зургадугаар сарын 30-ны дотор сонгоно гэдгээ албан ёсоор мэдээлээд байгаа юм.

Ямартай ч Стросс-Каныг хэн орлох вэ гэсэн шуугиан хэдийнэ эхэлсэн. Хөгжиж буй орнууд өөрийн хүнээ гаргаж ирэх хүсэлтэй байгаа бол европчууд уламжлалаа хадгалж үлдэх зорилго өвөртөлж буй. Дэлхийн банк, ОУВС-г АНУ, Европын орнуудаас гарсан хүн л удирдаж ирдэг бичигдээгүй хууль үйлчилдэг гэхэд хилсдэхгүй биз ээ.

Сингапур улсын Сангийн сайд Тарман Шанмугаратнам, Өмнөд Африкийн Сангийн сайд асан Тревор Мануэл болон Турк улс ОУВС-гаас тусламж авч байх үед тус улсын Сангийн сайд байсан Кемал Дэрвис



нар хөгжиж буй орнуудаас нэр дэвших магадлалтайг “Financial Times” мэдээлсэн байна.

Харин ХБНГУ-ын канцлер Ангела Меркель ОУВС-ийн тэргүүнийг Европоос сонгосон нь дээр гэж үзэж байгаа аж. Францын Сангийн сайд Кристин Лагардыг бол Шведийн Сангийн сайд Андерс Борг тэргүүтэй нөлөө бүхий хүмүүс дэмжиж буйгаа илэрхийлсээр байна. Үүний хажуугаар ХБНГУ-ын Төвбанкны захирал асан Аксель Вебер, Их Британийн Ерөнхий сайд асан Гордон Браун нарын нэр ч цухалзаж буй.

ОУВС-гийн 187 гишүүн орны аль нь ч тавдугаар сарын 23-наас зургадугаар сарын 10-ны хооронд өөрийн нэр дэвшигчээ санал болгох бололцоотой бөгөөд хураангуй жагсаалтад гурван хүн шигшигдэж үлдэхийг уг байгууллага албан ёсоор мэдээлжээ. ■

Улстөрч

“Сингапур гайхамшгийн эцэг” шинэ үедээ зай тавьж өгөв үү?

З агасан сүүлт арслан буюу Сингапурын бэлгэ тэмдэг болох “Merlion”-ыг мэдэхгүй хүн дэлхийд үгүй болжээ. Аялал жуулчлалын таатай орчин, анагаах ухааны үсрэнгүй хөгжил, дэлхийд дээгүүрт орох боловсролын чанар зэргээрээ тус улс харийнхныг “даллаж”, халаасыг нь “сэгсэрнэ”. Сингапур хэмээх хот-улс руу монголчууд ч мянга, мянгаараа цувах болсон. Гэвч нэгэн үед юу ч үгүй байсан жижигхэн тосгон яаж, ямар замаар ийм хөгжилд хүрсэн нь сонирхол татна.

Саяхан залуу улстөрчдөд боломж олгохын тулд Засгийн газраа орхиж буйгаа мэдэгдсэн 87 настай Ли Гуан Юг “Сингапур гаймхшгийн эцэг” хэмээн өргөмжилдөг. Түүний бичсэн “From third world to first” гэдэг номыг дэлхийн нөлөө бүхий улстөрчид ширээний номоо болгосон бөгөөд монгол хэлнээ “Буурай орноос бусдын манлайд хүрсэн замнал” хэмээн орчуулагдсан байдаг юм билээ. Японы Ерөнхий сайд асан Киичи Миязава “Энэ бол улсыг хэрхэн төвхнүүлэх тухай анхны сурах бичиг” хэмээн дээрх номыг тун ч оновчтой тодорхойлсон байдаг.

Улс бүтээхийн урлагт суралцсан хүн хэмээн алдаршсан Ли Гуан Ю мөндарангуулагч, үрхүүхдүүддээ албан тушаал бэлэглэгч хэмээн цоллуулах нь ч бий. Ямартай ч 1959 онд энэ хүнийг Сингапурын анхны Ерөнхий сайд болох үед тус улсын нэг хүнд ногдох ДНБ 400 ам.доллар байсан бол өнөөдөр энэ үзүүлэлт 50 мянган ам.доллараас ч давчихаад байгаа юм. 52 жилийн турш шууд буюу шууд бусаар Сингапурын засгийн эрхийг атгаж ирсэн энэ эрхэмтэй хот-улсын хөгжил, цэцэглэлт нягт холбоотой ажээ.

“Ертөнц биднийг тэжээх албагүй...”

1819 онд 120 загасчин амьдарч байсан жижигхэн тосгоныг “British East India” компанийн Стэнфорд Раффлз анзаарч, Энэтхэгээс Хятад хүрэх далайн замын төв болгосон нь Сингапурын түүхийн хуудсыг нээсэн гэдэг. 1923 онд хятад гаралтай гэр бүлд төрсөн Ли Гуан Ю дорь идэр насандаа эх орон нь Их Британийн колончлолын үед цэцэглэж байхыг ч харсан, Дэлхийн II дайны үеэр япончуудад эзлэгдэхийг ч үзсэн. Кэмбрижийн их сургуулийг хуульч мэргэжлээр дүүргэсэн энэ залуу 1959 онд 35 настайдаа Сингапур муж улсын Засгийн газрын тэргүүн болно гэж зүүдлээ ч үгүй гэдэг. Түүний удирдлага дор арлын орон 1963 онд Малайтай нэгдэж үзсэн ч хоёрхон жилийн дараа туурга тусгаарласан билээ.

1965 онд 42 настай Ли Гуан Ю ийнхүү тусгаар тогтносон Сингапур улсын засгийн эрхийг барьж үлдсэн юм. Гэхдээ тухайн үед энэ орны ирээдүйд хэн ч итгэж



байгаагүйг тэмдэглэх нь зүйтэй болов уу. “Sydney Morning Herald” сонины 1965 оны наймдугаар сарын 10-ны дугаарт “Тусгаар тогтносон Сингапур улс амьдарч чадна гэж гурван жилийн өмнө хэн ч хэлэхээргүй байсан. Өнөөдөр ч илүү амьдрах чадвартай болсон гэх баталгаа алга” гэж бичиж байв. Харин Ли Гуан Ю шал өөр бодолтой байсан юм. Сингапур улс зүгээр ч нэг амь гараад зогсохгүй, Азийн санхүүгийн төв болно гэж том дуугарч байсныг яана.

Гэхдээ бодит байдал аймшгийн байв. Газрын тасархай дээр байрласан, байгалийн баялаг гэх юу ч үгүй энэ орон ундны ус, элс шороогоо хүртэл импортолдог байсан юм. 1950-иад онд энд хятад, малай, энэтхэг гэсэн олон үндэстнийг багтаасан сая гаруй хүн л оршин суудаж байжээ. Үндэстэн хийгээд шашин хоорондын зөрчил, коммунизм, капитализм хоорондын сөргөлдөөн зэргийг Сингапур улс тойрч биш, дайрч гарсан бөгөөд авлига, хээл хахуульд идэгдсэн энэ орныг удирдана гэдэг бэрх даваа байсан нь гарцаагүй. Ядаж байхад хоёр хөрш буюу Малайз, Индонези нь буруу хараад зогсохгүй, худалдааны бодлогоор хот-улсыг дарамтлах янзтай. Монголчуудын дуртай “Хадны завсар хавчуулагдсан халиуны зулзага” гэдэг хэллэг Сингапурт л яг нийцэх юм шиг.

Цэргийн бааз байрлуулсны төлөө Их Британиас Сингапурын авдаг төлбөр үндэсний нийт бүтээгдэхүүнийх нь 20 хувийг бүрдүүлж, 70 мянган хүнийг ажлын байраар хангаж байлаа. Лондоны хэвлэлүүд “Их Британийн цэргийн баазууд хаагдах юм ▶

» бол Сингапурын эдийн засаг сүйрнэ” хэмээн бичиж байсан нь ч учиртай. Товчхондоо, үүнээс дор нөхцөл гэж байхааргүй байв. Тэр үед ард түмнээ хэн нэгний тусламжид найдах биш, өөртөө л найддаг болгох хэрэгтэйг ухамсарласан Ли Гуан Ю “Ертөнц биднийг тэжээх албагүй. Бид гуйланчлалаар хооллох ёсгүй” гэж хэлж байжээ.

Англичуудын цэргүүдээ татах ажлыг Сингапур улсад аль болох хохирол багатайгаар шийдвэрлэх нь Ли Гуан Югийн хувьд анхны том даваа нь байж. Үүнийгээ ч нааштай зохицуулчихаад хөрөнгө оруулагчдыг хайх их аянд морджээ. 1960-аад онд Хонконг, Тайваний аж ахуй эрхлэгчид Сингапурт үүд хаалгаа нээж, ажлын байр бий болгож эхэлсэн ч Ли Гуан Югийн хувьд энэ нь хангалтгүй хэрэг байлаа. Тэрбээр эх орондоо дэвшилт технологи нэвтрүүлж, иргэдээ өндөр чадвартай, боловсролтой болгохыг хүсэж байсан юм. Үүнийг Америкийн үндэстэн дамнасан корпорациуд л хийж чадна гэдгийг Ли Гуан Ю мэдэж байв.

Итгэл даах урлаг

Дотоодын зах зээл гэх юмгүй, байгалийн баялаггүйн зэрэгцээ усны нөөцөөр хүртэл хомс энэ оронд үндэстэн дамнасан корпорациудыг яаж ажиллуулна гэж? Татварын хөнгөлөлт, тогтвортой байдал гэх хоёрхон томъёолол урдаа бариад зүтгэвэл юу ч олж долоохгүй нь тодорхой байсан тул Сингапурын Засгийн газар өөр зам сонгожээ. Ингээд 1961 онд Эдийн засгийн хөгжлийн төвийг байгуулсан нь хөрөнгө оруулагчдад олон яам, агентлагтай биш, ганц хамт олонтой харилцаж цаг заваа хэмнэх бололцоо бүрдүүлсэн аж. Газрын түрээсийн асуудлаас эхлээд дэд бүтэц, эрчим хүч, усны хангамж, хөдөлмөрийн аюулгүй байдал гээд бүхнийг энд л шийддэг байв. Гэвч энэ байгууллагынхан шууд амжилтад хүрчихээгүй. Хөлөө цуцтал компаниудын хаалга татаж, Америкийн бизнес эрхлэгчидтэй уулзан, Сингапур улсад хөрөнгө оруулаач хэмээн царай алдахад зарим нь ийм орон байдгийг ч мэдэхгүй толгой сэгсэрдэг байсныг Ли Гуан Ю дурссан нь бий. Тэр үед Эдийн засгийн хөгжлийн төвийн

мэргэжилтнүүд 40-50 компаниар ороход ганц нь л ямар нэгэн хариу өгдөг байжээ.

Харин 1968 онд “Texas Instruments” компанийн төлөөлөгчид Сингапурыг сонирхож ирснээс байдал өөр болов. Үүний дараахан “Hewlett-Packard”-ын удирдлага энэ орныг шохоорхож буйг Эдийн засгийн хөгжлийн төвийн мэргэжилтнүүд нь мэдчихээд, асуусан болгонд нь шөнө дунд ч хамаагүй хормын дотор хариу өгч, Сингапурт ирж үзэхийг зөвшөөрөх хүртэл нь амар заяа үзүүлээгүй гэнэ. Эцэст нь НР хот-улсад үйлдвэрээ нээсэн. “Хөрөнгө оруулагчдыг татахын тулд бид арьсаа хуулж өгөхөөс ч буцахааргүй байлаа” хэмээн Ли Гуан Ю бичсэн байдаг. Өнөөдөр энэ оронд Америк, Европ, Японы 3000 гаруй үндэстэн дамнасан корпораци, дэлхийд толгой цохих 200 орчим банк ажиллаж байгаа юм. Гэхдээ Эдийн засгийн хөгжлийн төв нь л энэ бүхнийг “уургалсан” уу гэвэл үгүй.

1971 онд Сингапурын эрх баригчид мод тарих өдрийг анх зохион байгуулсан нь уламжлал болон тогтжээ. “Гаднынхан манайд ирэхдээ мод, цэцэгсээр дүүрэн тансаг, цэвэрхэн гудамж, гольфийн талбай зэргийг харах хэрэгтэй байлаа. Энэ нь хотын оршин суугчдын ёсзүйд ч сайнаар нөлөөлж, аялал жуулчлалын хөгжлөөс эхлээд хөрөнгө оруулагчдыг татахад хүртэл хэрэгтэй байсан юм” гэж Ли Гуан Ю тэмдэглээд, “Сингапурчууд хэдийгээр гуравдагч ертөнцөд амьдарч байсан ч хөгжингүй орнуудаас хөрөнгө оруулагчдыг татахын тулд тэдний хэм хэмжээнд очих хэрэгтэй байсан юм. Наад зах нь англиар чөлөөтэй ярьж, хөгжингүй орнуудын стандартад нийцсэн үйлчилгээ үзүүлж, соёлжих ёстой байлаа” хэмээн дурссан байдаг. Үүнээс ч “From third world to first” (Гуравдагч ертөнцөөс анхдагч руу) номын нэр улбаатай буюу.

“Хэрвээ хэн нэгэн надаас Сингапурын хөгжлийн хөшүүрэг юу вэ гэж асуувал би итгэл (confidence) гэж хариулна” гэж Ли Гуан Ю “Forbes” сэтгүүлд ярилцлага өгөхдөө онцолжээ. 1973 онд АНУ Израилийг дэмжиж байгааг Арабын орнууд эсэргүүцээд, нефтийн хорио тавьснаас болж дэлхий даяар газрын тосны хомсдол нүүрлэж,



үнэ нь дөрөв дахин өссөн байдаг. Тухайн үед “Shell”, “Mobil”, “Esso”, BP зэрэг олон улсын томоохон компани Сингапурт ажиллаж байсан бөгөөд хот-улсын эрх баригчид өөрсдийн эрх ашгаа бодоод, эхний ээлжинд сингапурчуудын хэрэгцээг ханга гэсэн бол хэдэн өдрийн бензин, шатахуунаас өөр юу ч хожихгүй байсан биз. Харин Ли Гуан Ю олон нийтийн өмнө нефтийн компаниудад хандаж үг хэлэхдээ “Та бүхэн юуны түрүүнд харилцагчдаа гэрээлсэн бүтээгдэхүүнээ хүргэ, сингапурчууд өөрсдийн квотыг хасахад бэлэн байна. Аливаа хүндрэлийг бид хамтдаа үүрч чадна” гэж мэдэгдсэн юм. Үр дүнд нь юу болсон гэвч?

1970-аад онд Сингапур улсад нефть боловсруулах үйлдвэрлэл дөнгөж хөгжиж байсан бол 1990-ээд оны эхээр энд өдөрт 1.2 сая баррель газрын тос боловсруулж байсан нь Хьюстон, Роттердамын дараа буюу дэлхийд гуравдугаарт »



► жагсах үзүүлэлт байв. Ийнхүү газрын хэвлийдээ дусал ч “хар алт”-гүй хот-улс нефтийн худалдаагаар Нью-Йорк, Лондоны дараа мөн л дэлхийд гуравдугаарт жагсах болжээ.

Яаж ийм амжилтад хүрч чадав аа? “Яагаад гэвэл бид хүлээсэн үүргээсээ хэзээ ч няцахгүй гэдгийг бүгд мэднэ. Бид гэрээ хийхээсээ өмнө бүх нөхцөлийг сайтар судалдаг. Тэгээд нэг бол үзэглэнэ, үгүй бол үзэглэхгүй. Гэхдээ үзэглэсэн л бол ямар ч тохиолдолд үүргээ биелүүлнэ. Ямарваа хэлэлцээний ард Та алдаж болно. Харин урт хугацаанд хийх ёстой бүхнээ хийж чадвал ялагч л болж үлддэг юм” хэмээн Ли Гуан Ю хэлснийг “Forbes” онцолжээ.

Сингапурт шинэ эрин эхлэх үү?

1959 оноос засгийн эрх барьсан Ли Гуан Югийн албан тушаалыг

1990 онд Го Чок Тонг залгамжилсан байдаг. Гэвч тэрбээр “Сингапур гайхамшгийн эцгийг” засгаас зүгээр л гаргачихаагүй, Ахлах сайд гэх албан тушаалд үлдээснээр барахгүй том хүү Ли Шиен Лүүнийг нь өөрийн орлогчоор томилжээ. Үүнээс болж Го Чок Тонг гэх “хүүхэлдэй” Ли Гуан Югийн хүүгийн ирээдүйн үүрийг бүлээцүүлж байна хэмээн доог тохуу хийх шүүмжлэгчид олширсон юм. Түүнчлэн Ли Гуан Югийн бага хүү Шиен Ян “Сингапур Телеком” компанийн ерөнхий захирлаар томилогдох үед ч хэл ам тасарсангүй. “Үр хүүхдүүддээ албан тушаал бэлэглэгч”, “Садам Хуссейнээс өөрцгүй дарангуйлагч” хэмээн барууны нөлөө бүхий хэвлэлүүд Ли Гуан Юг буруутгаж байсан юм.

Үнэхээр ч Ли Гуан Югийн том хүү 2004 онд Ерөнхий сайдын суудлыг авсан бөгөөд өнөөдөр ч энэ албан тушаалаа хадгалж байгаа билээ.

Ингэхдээ өөрийн аав болон Го Чок Тонгийг Зөвлөх сайд, Ахлах сайдын албан тушаалд мөн л үлдээсэн байдаг. Харин тавдугаар сарын 16-нд энэ хоёр эрхэм хоёул Засгийн газар дахь суудлаасаа татгалзаж, шинэ үеийн улстөрчдөд зай тавьж өгч буйгаа мэдэгдсэн нь цаанаа учиртай. Юу гэвэл 1959 оноос л засгийн эрхэнд дангаараа ноёрхсон, Ли Гуан Югийн үүсгэн байгуулсан Ардын ажиллагааны нам (People's Action Party) өнгөрсөн тавдугаар сарын 7-нд болсон сонгуулиар парламентын 87 суудлын зургааг нь сөрөг хүчиндээ алдсан юм. Энэ нь тус намын түүхэн дэх хамгийн муу үр дүн болжээ.

“Ли Гуан Ю өөрийн санаачилгаар албан тушаалаа өгсөн ч гэлээ парламентад байсаар л байна. Тэрбээр арын суудлаас илтгэл, хэлэлцүүлгээ өрнүүлж, олон нийтийн өмнө гарч, мэдээж илүү олон ном бичнэ” хэмээн “The Economist” тэмдэглээд, хот-улсын үүсгэн байгуулагчийн өөрийнх нь хэлсэн үгийг иш татжээ. “Би өвчтэй хэвтэж байлаа ч, та нар намайг булшлах гэж байлаа ч, ямар нэгэн зүйл буруу явж байгааг мэдрэх л юм бол босоод ирнэ шүү” хэмээн Ли Гуан Ю 1988 онд хэлсэн удаатай.

Өнөөдөр Сингапур улс нэг хүнд ногдох орлогоороо дэлхийд дөрөвдүгээрт эрэмбэлэгдэж, өндөр технологийн үйлдвэрлэл, санхүүгийн үйлчилгээгээрээ Зүүн Өмнөд Азидаа тэргүүлж буй. Гэвч 40 хүрээгүй сингапур залуусын олонх нь хот-улс тусгаар тогтноод, Азийн бар болох замд юу тохиолдсоныг ойлгохгүй, бүрхэг өдрүүдийг мэдэхгүй. Тиймээс өнөөдөр шинэ үе шинэ эринд ороход бэлэн байгаа нь ойлгомжтойг “The Economist” онцолжээ. Ямар ч байсан энэхүү хот-улсын түүх Ли Гуан Ю гэдэг удирдагчтай нягт холбоотой бөгөөд дэлхийн нөлөө бүхий улстөрчид ч үүнийг хүлээн зөвшөөрдөг буюу.

Их Британийн Ерөнхий сайд асан Маргарет Тэтчер “Ли Гуан Ю суртал ухуулгын утааг сарниулж, тулгамдаж буй асуудлуудыг хэрхэн шийдвэрлэх арга замыг олж хараад, тодорхой хэлдэг байсан. Тэрбээр ганц ч удаа алдаж байгаагүй” хэмээн тэмдэглээд, “Нэгэн үед Сингапур Их Британиас суралцаж байлаа. Эдүгээ бид Сингапураас үлгэр жишээ авч байна” гэжээ. ■

Б.Болд: Институционал хөрөнгө оруулагчдыг хөгжүүлмээр байна

Хөрөнгийн зах зээлийн хөгжлийн тухай ид ярьж байгаа энэ үед “Mongolian Economy” сэтгүүл хөрөнгө, санхүүгийн зах зээлийн талаарх олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор Монголын хөрөнгийн биржийн ТУЗ-ийн дарга Б.Болдтой цуврал ярилцлага хийж байгаа билээ. Энэ удаа бид институциональ хөрөнгө оруулагчийн тухай ярилцлаа.

-Институционал буюу байгууллагын хөрөнгө оруулагчийн талаар тодорхой ойлголт өгнө үү. Ийм хөрөнгө оруулагчид манайд хөгжөөгүйн гол шалтгаан нь юу вэ?

-Хувьчүнсвэлмэргэжлийнбайгууллагуудлхувьцаанд хөрөнгө оруулдаг. Ялангуяа компаниуд мэргэжлийн байгууллагуудад хувьцаагаа зарах илүү сонирхолтой байдаг. Тэдний хувьд мэргэжлийн ур чадвар, чадавх компанийн тухай ойлголт илүү, мэргэжлийн анализ бүрэн хийж чаддаг. Институционал буюу байгууллагын хөрөнгө оруулагч гэдэг нь ерөнхийдөө хувь хүн өөрөө хувьцааны зах зээлийн талаарх мэдлэг мэдээллийг бүрэн гүйцэд бүрэлдүүлж чаддаггүй учир тэдний өмнөөс мэргэжлийн байгууллага ажиллаж мөнгийг нь удирдахыг хэлнэ. Компанийн үнэлгээ, хувьцааны үнэ өдөр бүр, минут, секундээр өөрчлөгддөг. Энэ нь олон шалтгаантай. Тухайлбал, эдийн засгийн өсөлт, уналт, хууль эрх зүйн орчин, байгалийн хүчин зүйлс, технологийн дэвшлүүд гэх мэт макро, микро олон хүчин зүйлс нөлөөлнө. Тиймээс хувь хүн өөрөө байнгын ажилтай байдаг тул тэр болгоныг хянажсуугаадбайжчаддаггүй.Тэгвэлмэргэжлийнхөрөнгө оруулагчид нэгдүгээрт, хянах чадвартай, хоёрдугаарт, урт хугацаанд хөрөнгөө оруулдаг. Нэг хувьцааг худалдан аваад 1-2 жилийн дараа ямар ашиг авчрах вэ гэдэг талаар судалдаг.Энгийнээр бол мэргэжлийн хөрөнгө оруулагч гэж бусдын мөнгийг удирддаг мэргэжлийн менежер хүнийг хэлнэ. Сангийн менежер гэсэн үг.

Ийм менежерүүд яагаад манайд хөгжөөгүй гэхээр хувийн тэтгэврийн систем бүрдээгүй, даатгалын компаниуд нь саяхнаас зөвшөөрөл авсан, мэргэжлийн менежмент хийдэг чадавх бүрдэж амжаагүй, ард иргэдэд хөрөнгө оруулах хуримтлалын мөнгө харьцангуй бага байгаатай холбон тайлбарлаж болно.Тэгэхээр энэ байдал өөрчлөгдөх ёстой. Учир нь бид Тавантолгойн хувьцааг иргэн бүртээ тарааж өгсний дараах жил манай хөрөнгийн бирж дээр арилжаа нээгдэнгүүт гаднын олон хөрөнгө оруулагч орж ирлээ гэж бодъё. Гэтэл тэд биржийн бүх хувьцааг авахад хувьцааны урсгал гадагш чиглэх г



аюултай тул дотоодын хөрөнгө оруулагчдын чадавхыг яаралтай бүрэлдүүлэх шаардлагатай хэмээн би байнга яриад буй хэрэг шүү дээ. Тиймээс хувийн тэтгэврийн сангийн системийг бүрдүүлж, хөрөнгө оруулалтын сангуудыг богино хугацаанд хөгжүүлмээр байна.

-Байгууллагын буюу мэргэжлийн хөрөнгө оруулагчийг хөгжүүлэх хөшүүрэг, хууль эрх зүйн орчныг хэрхэн бүрдүүлэх вэ. Мэргэжлийн хөрөнгө оруулагчдын сангийн төрлүүд, тэдгээрийн хоорондын ялгааны талаар тайлбарлана уу?

-Үнэт цаасны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж байх шиг байна. Хувийн тэтгэврийн сан, Компанийн тухай, хөрөнгө оруулалтын сангийн хуулиудад ч мөн өөрчлөлт оруулах ёстой. Мэргэжлийн хөрөнгө оруулагчдын сангийн төрлүүд дотор хувийн тэтгэврийн сан, даатгал, хөрөнгө оруулалт, их сургуулиудын хандивын сан болон хедже сангууд багтдаг.

Хувийн тэтгэврийн сан

Америкт хамгийн том нь CAIPERS /California Public Employees' Retirement System/ нэртэй Калифорни мужийн багш нарын буюу төрийн ажилтнуудын тэтгэврийн сан байдаг. Канад, Австралид ч тэтгэврийн том том сангууд бий. Ихэнх хувьцаанд хөрөнгө оруулагчийн том тоглогчид нь хувийн тэтгэврийн сангууд юм. Эерэг тал нь тэд хөрөнгө оруулахдаа урт хугацааг голчилдог. Тэдний бүрэлдүүлсэн мөнгө нь ирээдүйн санд мөнгөө өгсөн хүмүүсийн тэтгэврийн асуудлыг шийддэг. Өнөө маргаашийн тэтгэврийн асуудлыг бус шүү. Тухайлбал, Та өнөөдөр 37 настай бол 23 жилийн дараа тэтгэвэр авна

гэж бодоод хувийн тэтгэврийн санд хөрөнгө оруулах нь байна шүү дээ. Тэтгэврийн сан дотроо олон төрөл бөгөөд энэ сангийн хамгийн гол давуу тал нь хугацаа урт. Дээр нь маш том хөрөнгө оруулагчид байдаг тул компаниуд энэ том сангуудтай үнэн зөв, шударга харилцаатай байхыг эрмэлздэг. Учир нь нэг удаа мөнгө босгуулж авчихаад худлаа яриад гомдоож, итгэлийг нь алдвал сангаас дахин мөнгө босгоход хүндрэлтэй болдог. Тэгэхээр хувийн тэтгэврийн сангийн системийг хөгжүүлснээр компанийн гүйцэтгэх удирдлагыг үнэнч шударга ажиллуулах, ТУЗ-ийг хянах том ач холбогдолтой. Харин сөрөг тал нь тэд нэлээд консерватив гэж хэлж болно. Бусдын тэтгэврийн мөнгийг хариуцаж байгаа хүмүүс хамаагүй өндөр эрсдэлтэй хөрөнгө оруулалт хийхээс зайлсхийдэг байх ёстой.

Даатгалын сан:

Даатгалын сангууд шууд хувьцааны хөрөнгө оруулалт хийхдээ нэлээд консерватив ханддаг. Ийм сангуудын дийлэнх нь Moody's, Fitch, Standard&Poor's зэрэг судалгаа хийж, компаниудын зээлжих зэрэглэлийг тогтоодог байгууллагуудын AAA, AA, A үнэлгээтэй бондуудад хөрөнгө оруулалт хийдэг.

Даатгалын сангуудын хамгийн гол онцлог нь тогтворжсон компаниудад хөрөнгө оруулах сонирхолтой байдаг. Тухайлбал, "Кока кола", "Женерал электрикс" гэх мэт маргааш алга болчихгүй томчуудыг сонирхоно. Жижиг компанид бол нэлээд болгоомжтой хандана. **Хөрөнгө оруулалтын хамтын сан:**

Хөрөнгө оруулалтын хамтын сан нь хувийн тэтгэврийн сангаас ялгаатай нь 20-30 жилийн хөрөнгө оруулалт гэхээс илүүтэй хөрөнгийн зах зээл дээрх жилээс жилд өөрийнхөө хөрөнгө оруулалтын стратегийг зах зээлийн байдал, бизнесийн орчинд тааруулан өөрчилж байдаг. Гэхдээ харьцангуй урт хугацааны хөрөнгө оруулагчид гэж ойлгох хэрэгтэй. Хөрөнгө оруулалтын санд мөнгөө өгнө гэдэг бол мөнгөө өсгөх нэг хэлбэр л дээ. Хэрвээ банкны хүү өндөр бол би банкинд мөнгөө хадгалуулна. Харин хөрөнгө оруулалтын сан банкны хүүгээс өндөр "тоглолт" хийгээд байвал би ийм сангуудад л хандана. Хувийн тэтгэврийн сан бол миний урт хугацааны тэтгэврийн асуудлыг шийддэг бол даатгалын

сан хувийн амьдралын маань даатгалыг хариуцаж байна. Хамтын хөрөнгө оруулалтын сан миний хуримтлуулсан хөрөнгийн менежер юм. Хамтын хөрөнгө оруулалтын сан дотроо олон янз. Үүний цаана хэдэн мянган сангийн менежерүүд байдаг. Эдгээр менежерийн ажлын үр дүнг зах зээлийн индексүүдтэй харьцуулж дүгнэдэг. Индексүүд дотроо олон төрөл, хувьцааны, бондын, "дэлхийн" гэх мэт. Жишээ нь Dow Jones Industrial Average гэдэг индекс Америкийн хамгийн том 30 хувьцаат компаниудын хувьцаанаас бүрддэг бөгөөд тэдгээрийн үнийн өсөлт бууралтыг илэрхийлдэг. MSCI-World индекс нь дэлхийн өндөр хөгжилтэй 20 гаруй орны 1500 хувьцаат компанийн хувьцаануудын өсөлт бууралтыг хэмждэг.

Тэгэхээр ийм сангийн менежерүүдийн хариуцлага маш өндөр. Тухайлбал, технологийн сангийн менежер хүн тухайн үед технологийн индекс 20 хувиар өсвөл тэр менежер 30 хувийн өсөлт хийж байж өөрийгөө амжилттай ажиллаж байна гэж үзнэ. Түүнээс 18 хувийн өсөлт хийчихээд томд тооцож болохгүй. Тэгвэл би энэ менежерээр биш, өөрөө технологийн хувьцаа авсан бол 20 хувийн өсөлт хийх байжээ гэж бодно. Индекстэй өрсөлддөг салбар юм. Менежер хүн арванхоёрдугаар сарын 31-ний байдлаар өөрийнхөө тайланг гаргаж, хөрөнгө оруулагчдад тайлагнах ёстой. Ер нь хүмүүс мөнгөн хуримтлалаа өсгөхийн тулд хамгийн сайн менежерийг хайна. Туршлага, чадавх хэр юм, яаж ажилладаг гэх

мэтчилэн тухайн менежерийг хэн бэ гэдэгт түлхүү анхаарна. Нөгөө талаар менежер индексийг "цохихын" тулд хувьцааны сонголтыг зөв хийх ёстой. Ямар менежментээр, шударга, үнэн зөв өрсөлдөж энэ хувьцааг илүү үнэд хүргэх вэ гэдэгт гол анхаарлаа хандуулна. Энэ хэрээр тухайн компанийн менежментэд идэвхтэй ханддаг. Хувьцаа эзэмшигчдийн хуралд нь очоод өнгөрсөн жилийн тайлан танилцуулахад гүйцэтгэх захирал Та ийм ажлууд дээр дутуу ажилласан, одоо эдгээрт анхаарах хэрэгтэй гэх замаар тухайн компанийн менежментэд идэвхтэй оролцох боломж бүрдэж байгаа юм. Би их хэмжээний триллион долларын салбаруудыг ярьж байна. Ер нь хөрөнгийн хэмжээгээр яривал, хамгийн том тоглогчид бол магадгүй хамтын хөрөнгө оруулалтын, дараа нь тэтгэврийн, тэгээд хедже сангууд орно.

Хедже сан:

Энэ нь сүүлийн 10 жилд гарч ирсэн нэр томъёо. Өмнө нь хөрөнгийн зах зээлд тэтгэврийн, хамтын хөрөнгө оруулалтын сангууд голлох байр суурьтай байлаа. Хедже сан нь хөрөнгө оруулалтын сангуудаас ялгаа нэг их байхгүй, гэхдээ менежментийн төлбөр нь өндөр 20 хувь, нийт олсон ашгийнхаа 20 хувийг авдаг. Хөрөнгө оруулалтын сангийн менежерүүд зөвхөн менежмент хийснийхээ төлөө 1-1.5 хувийн төлбөр л авч байгаа. Нийт ашгаас авахгүй. Тэгэхээр хедже менежерүүд нийт ашгийн 20 хувийг авдаг тул аль болох өсөлт хурдантай компаниудыг сонирхдог.



► Тиймээс Америкийн Уолстрийгийн хамгийн чадварлаг менежерүүд Хедже сан руу явсан байдаг. Ийм сангийн сөрөг тал нь хөрөнгө оруулалтын хугацаа маш богино. Хувьцаа руу гялс ороод л гялс гарна. Өдөр тутмын хэлбэлзэлд идэвхтэй анхаарна. Хедже нь анхлан ямар ч эдийн засгийн хямралын үед хүний мөнгийг алдахгүй хамгаалахаар гарч ирсэн. Хедже гэдэг нь өөрийгөө хамгаалах гэсэн утгатай. Дэлхийн Хедже сангийн анхны томчуудын нэг нь бидний сайн мэдэх Жорж Сорос байна. Энэ санд хөрөнгө оруулдаг хүмүүс ихэвчлэн баян чинээлэг хүмүүс байдаг. Тэрбумтан, саятангууд хамгийн доод хязгаарыг тухайлбал, 1-5 сая ам.доллар гэж тогтоогоод хедже санд өгч, мөнгөө үржүүлүүлдэг. Хедже сангийн менежерүүд жилийн ашгийг бусад сангаас өндөр авчирдаг тул баячууд ийм менежерүүдэд хандах илүү сонирхолтой гэж ойлгож болно. Лондон, Нью-Йорк хотуудад хедже-ээр мэргэшсэн хамгийн олон байгууллага, менежерүүд байдаг. Хамгийн том хедже бол "Blackrock", "Soros", "Bridgewater" "Associates" байна.

-Хөрөнгө оруулалтын банкууд яаж оролцох вэ?

-Ихэнх хөрөнгийн бирж дээр хөрөнгө оруулалтын банкууд том суудалтай байдаг. Тэд үйлчлүүлэгчдийн өмнө худалдах, худалдан авах гэрээг зуучилдаг зуучийн байгууллага. Саяны хямралаас Америкт хөрөнгө оруулалтын банкуудыг өөрийнхөө мөнгөөр спекуляци /үндэслэлгүй цоорхал тарааж дундаас нь мөнгө олох/ хувьцааг худалдан авч зарах үйл ажиллагааг хориглосон. Харин үйлчлүүлэгчдээс тийм санал гарвал хөрөнгө оруулалтын банкууд хувийн тэтгэврийн сан, хөрөнгө оруулалтын сангийн захиалгыг гүйцэтгэдэг зууч брокер дилер нь болно. Ийм банкууд хоёр төрлийн харилцагч, үйлчлүүлэгчтэй байдаг. Өөрөөр хэлбэл, худалдан авагч буюу хөрөнгө оруулагчийн дунд сууж буй дундын зуучлагч байгууллага юм. Тухайлбал, "Эрдэнэс Тавантолгой" компани хөрөнгийн зах зээлд хувьцаагаа гаргаж гэж хөрөнгө оруулалтын банкинд хандахад тэд хөрөнгө оруулагчийг холбож өгч байгаа юм. Ийм банкны ажилтнууд уул уурхайн арилжааг өдөр бүр харж, ажиглаж суудаг. Хэн ямар хувьцаа авч

байгааг байнга ажиглаастай. Энэ бүх талын мэдээлэл дээрээ тулгуурлан "Эрдэнэс Тавантолгой"-н хувьцааг ийм хувийн Тэтгэврийн сан, Хедже сангууд авах юм байна. Яагаад гэвэл миний хамгийн сүүлд оролцсон Индонезийн уул уурхайн IPO-д энэ сангууд ингэж оролцсон юм аа хэмээн тайлбарладаг. Тэгээд тэд дэлхийг тойрсон хөрөнгө оруулагчдын чуулга уулзалтын жагсаалтыг гаргахдаа тэр урт жагсаалтаа хараад, "Эрдэнэс Тавантолгойн" өрсөлдөгчид өнөөдөр ийм ийм компани байна, эдгээр нь хувьцааг худалдан авах хамгийн том боломжтой хүмүүс гээд тэдгээрийн дунд уулзалт зохион байгуулж хувьцаагаазарнагэжтөлөвлөдөг. Ийм л мэдээллийг Хөрөнгө оруулалтын банкныхан хийж ажилладаг. Өөрөөр хэлбэл, хөрөнгө оруулалтын банк нь хөрөнгө оруулагч, хөрөнгө хайгч хоёрыг холбодог гүүр юм. Энэ утгаараа үйлчлүүлэгчдийнхээ өмнө хариуцлагатай хандах ёстой. Нэгэнд нь худал ярьж, нөгөөг хууран мэхлэх зүйл гаргаж болохгүй. Гаднын "Goldman Sachs", "Deutsche" гэх мэт маш том хөрөнгө оруулалтын банкууд байдаг. Манай Хөрөнгө оруулалтын банкууд жижиг ч ийм л зорилго чиглэлтэй ажиллаж байгаа. Дотоодын компаниудаас хөрөнгө босгоод өгөөч гэж хандахаар хөрөнгө оруулагчийг хайж эхэлнэ. Гэхдээ манай хөрөнгийн бирж сайн хөгжөөгүй учир хөрөнгө оруулалтын банкууд идэвхтэй хувьцааны арилжаа явуулдаггүй. Бирж хөгжөөд ирвэл аль аль талд нь үйлчлээд явчихна.

Гадаадын хөрөнгө оруулалтын банкны хийдэг ажил нь ийм. Өнөөдөр манай бирж дээр хөрөнгө хайгчид цөөхөн, хөрөнгө оруулагчид байхгүй. Тэгэхээр бидний хамгийн том асуудал хөрөнгийн зах зээлийн миний дээр ярьсан дэд бүтэц хөгжөөгүй учраас хөрөнгө оруулдаг хүн нь зөвхөн хувь хүн юм. Цэвэрлэгч хүн хувьцаа авах талаар ярьж эхэлбэл үүнийг хөөсийн дээд зэрэглэл гэж үздэг. Энэ тохиолдолд бүх хувьцаагаа зарах ёстой. Өөрөөр хэлбэл, хүн бүр хувьцааны талаар ямар нэг байдлаар ярьдаг, мэддэг шинжтэй болчихвол спекуляцид орсны шинж. Энэ тохиолдолд Америкт хувьцаагаа шууд зардаг. Хэтэрхий хувь хүнд түшиглэсэн зах зээл байхын сөрөг тал нь энэ. Хөрөнгийн зах зээлийн мэдлэггүй хүн 100 төгрөгийн үнэтэй гайгүй хувьцаа юм байна

гэж л харахаас бус цаана нь хэдэн ширхэг хувьцаа байгааг, үнэлгээг мэдэхгүйгээр хувьцааг худалдан авна гэдэг утгагүй юм. Хэдэн жилийн өмнө Хятадад ийм хөөснөөс болж, зах зээлийн хувьцааны ханш 30-40 хувиар унасан. Яасан гэхээр хятадууд тэтгэврийн мөнгөөрөө гэнэт хувьцаа авч эхэлсэн. Хөгшчүүл нь 10 юаниас доош хувьцааг авна, таван юаниас доош хувьцаа хямд байна гээд л. Энэ бол маш буруу ойлголт. Энэ хувьцааны цаана ямар компани байдаг, гүйцэтгэх захирал нь хэн юм, салбар нь хэр эрсдэлтэй талаар судалгаа явуулж сайн мэдээлэл авах ёстой. Тэгвэл үүнийг хийдэг газар нь дээрх мэргэжлийн сангууд.

-Манайд ийм судалгаа шинжилгээ хийдэг мэргэжлийн байгууллага байхгүй байна шүү дээ

-Харин тийм. Эдийн засгийн их, дээд сургуулиуд, банкууд, брокер санхүүгийн байгууллагууд ийм мэргэжилтнүүдийг гаргаж ирэх ёстой. Үнэндээ бол бидний аав, ээжүүд хувьцаа арилжаад эхэлбэл утгагүй. Компанийн тайлан тэнцэл, санхүүгийн үзүүлэлтүүдийг уншиж чадахгүй хүмүүс хувьцаанд хөрөнгө оруулалт хийхэд хэцүү. Наад захын нябо, санхүүгийн ойлголт хэрэгтэй.

Мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг яаралтай чадавхжуулах талаар хоёр жилийн турш ярьсан. Хууль эрх зүйн орчныг яаралтай бүрэлдүүлэх ёстой гээд л. Ер нь бол бид хөрөнгийн биржийн энэ том бүтцийг хөгжүүлээгүй суутал гаднын хөрөнгө оруулагчид орж ирээд манай бирж дээрх бүх хувьцааг аваад байж байтал Монгол Улс гэнэт ямар нэг шалтгаанаар моодноос гарлаа гэж бодъё. Энэ тохиолдолд бирж үхмэл байдалдаа эргээд л орно. Иймэрхүү тодорхой учир шалтгааны улмаас дотоодын хөрөнгө оруулагчдыг хөгжүүлэх ёстой талаар яриад байгаа юм. Бид өөрсдөө шинэ зүйл зохиох хэрэггүй. Казакстаны бэлэн туршлага байна. Казакстан улс 1990-ээд онд залуучуудын тэтгэврийн санг улсаас тусгаарлаад хөгшчүүдийнхийг төрдөө аваад үлдсэн байна. Насны эрэмбээр. Тэгээд залуучуудынхаа тэтгэврийн санг тусгаарлангуут хувийн тэтгэврийн, хөрөнгө оруулалтын, Хедже сангууд гарч ирж хөгжсөнөөр өдгөө 90 тэрбум ам.долларын дотоодын хөрөнгө оруулагчийн чадавх бүрдсэн байна шүү дээ. Хувьцааны индекс өсөөд

ирэхээр сангууд мөнгө хийнэ, дунд нь ардиргэд мөнгөтэй болж баяжина. Эхэндээ жаахан мөнгө ч жилээс жилд залуучуудын тэтгэврийн мөнгө нь нэмэгдээд л яваад байна. Магадгүй энэ зарчмаар явбал Монголын залуучууд 10 жилийн дараа зөвхөн дотооддоо төдийгүй дэлхийн хэмжээнд хувьцааны арилжаанд оролцдог хөрөнгө оруулалтын салбарын чадавхтай болохыг үгүйсгэхгүй шүү дээ.

-Гаднын хөрөнгө оруулагчдын давуу болоод сул тал юу байх вэ?

-Гадаадын байгууллагын хөрөнгө оруулагчид ороод ирвэл бидэнд ноу-хау-гаа дамжуулж болно. Санхүүгийн зах зээлийн сургалтын процесс эхлүүлж болно. Гаднын хөрөнгө оруулагч орж ирэхийн тулд ямар брокер дилерийн компани байна, чадавх нь хэр талаар судалгаа явуулна. Хүмүүсийг сургаж эхэлнэ. Гэхдээ хэтэрхий гаднынханд найдсан байж болохгүй ч тэднээс зугатах арга алга гэдэг нь үнэн юм. Эхлээд гаднынхан л орж ирж байж манай бирж хөгжинө. Түүнээс бид зөвхөн дотооддоо хийнэ, гаднын байгууллагын хөрөнгө оруулагчдыг оруулахгүй гэвэл өөрсдийгөө

өөрчилж, дэлхийн хөрөнгийн зах зээлтэй өрсөлдөж чадахгүй. Тиймээс гаднын байгууллагын хөрөнгө оруулагчид орж ирж л байвал мөнгийг нь үр өгөөжтэй ашиглах талд л анхаарах ёстой. Мөн банкуудын хүүг бууруулах нэг үүсвэр энэ юм. Гаднын хөрөнгө оруулалтын сангууд ороод ирвэл манай компани бонд гаргаад тэр бондоо банкнаас хямдхан авч, урт хугацааны 5-10 жилийн хөрөнгө оруулалт хийж болно. Өнөөдөр манай банкууд өндөр хүүтэй богино хугацаатай хөрөнгө оруулалтууд хийж байна. Энэ тохиолдолд улсынхаа хэмжээнд мөнгөн хуримтлал үүсгэж чадахгүй байгаа юм. Нэг ёсондоо богино хугацааны наймаа хийгээд байна гэсэн үг. Тэгэхээр улс орны хөгжлийн чанартай төсөл, томоохон дэд бүтцийг хөгжүүлэх хэмжээний мөнгөн хуримтлал үүсгэж чадахгүй байна.

-Монголын хөрөнгийн биржийг хөгжүүлэх ажлын талаар ямар шинэлэг мэдээлэл өгөх вэ?

-Ажлынхаа дунд явж байна. Лондоны бирж 90 хоногийн хугацаанд удирдлагын баг явуулах, бизнес төлөвлөгөөгөө боловсруулах юм. Тэгээд түүнийгээ МХБ-ийн

ТУЗ, Төрийн өмчийн хороонд танилцуулах ёстой. Хугацаа арай болоогүй байна. Ирэх сард ТУЗ, ТӨХ-нд танилцуулж батлуулах байх. Лондоны биржийн менежмент бол ороод ирсэн. Гэхдээ орж ирэнгүүт бүх юмыг өөрчилчихгүй. Өөр нэг мэдээлэл нь МХБ-ийн дэргэд Хөрөнгийн зах зээлийн хөгжлийн төв байгуулагдсан. Гол зорилго нь хууль эрх зүйн орчныг яаралтай бүрдүүлэхэд санаачилгатай ажиллах, олон нийтийн хөрөнгийн зах зээлийн мэдлэг боловсролыг соён гэгээрүүлэх, хувьцааны мэдлэгийг дээшлүүлэх ажлыг цэвэр хувийн салбарын, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх сонирхолтой байгууллагуудын дэмжлэгээр явуулах төв юм. Хөрөнгийн бирж төсвийн байгууллага тул хөрөнгө санхүү талаасаа хүндрэлтэй. Тийм учраас банкууд, гаднын хөрөнгө оруулагчид, олон улсын байгууллагууд, дотоодын санхүүгийн байгууллага, компаниуд, хувь хүмүүсийн Монголын хөрөнгийн биржийг хөгжүүлэхэд үзүүлэх санаачилга, дэмжлэгийг авах үүднээс ажиллах юм. ■

Хувьцаа

Малчин Доржийн хувьцаа ба брокерийн үйлчилгээ

Х.Хулан

Миний бие 536 ширхэг хувьцаа эзэмшигч болсон эсэхээ шалгахар Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв /УЦТТХТ/-ийн цахим хуудсанд зочиллоо. Регистрийн дугаараа ашиглан үзтэл, дараах бичиг гарч ирэв. И р г э н Та Монгол Улсын Засгийн газраас олгосон "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн 536 ширхэг хувьцаа эзэмшиж байна. Та Төвлөрсөн хадгаламжинд данс нээлгээгүй байна. Хэрэв Та дансаа нээлгэхийг хүсвэл энэ цахим хуудсыг ашиглан брокер дилерийн компаниудын мэдээллийг авч үйлчлүүлнэ үү" гэжээ. Энэ гэснийх



» нь дагуу цааш аялахад 47 брокер дилерийн компанийн хаяг, холбоо барих утсыг жагсаажээ. Ямар компанийг нь сонгох нь иргэн таны эрх гэнэ. Ямар чиг л байсан аль нэгэн брокерийн компанийг сонгож, дансаа нээлгэх учиртай. Хүн бүхэн интернэтээр аялдаг болсон өнөө цагт дээрх мэдээллийг авах амархан санагдаж байж болох юм. Гэтэл малчин Дорж хүртэл 536 ширхэг хувьцаагаа шалгаж, улмаар данс нээлгэж ирээдүйд их мөнгө авчрах хувьцааны арилжаанд оролцоход бэлтгэх ёстой. Манайд интернэт хэрэглэгчдийн тоо 450 мянгад хүрсэн гэсэн албан бус судалгаа байдаг. Гэтэл интернэтийн үйлчилгээ, гэрэл цахилгааны хүртээмж хөдөө, орон нутагт хэр түвшинд байгаа билээ. Монголын бүх сум интернэтэд холбогдсон гэж ярьдаг ч өнөөдөр төвийн эрчим хүчинд холбогдоогүй дизель станцаар амиа аргацаадаг сум гарын арван хуруунаас давсан тоотой. Хөдөө, орон нутаг битгий хэл, Улаанбаатар хотод гэрэл цахилгаангүй суугаа өрх цөөнгүй байгаа гэж бодохоор энэ нь тийм ч амар хялбар шийдэгдэх ажил биш бололтой. Тэгвэл хэрхэх ёстой вэ?

Малчин Дорж ч өнөөдөр болдог бол хувьцаа эзэмшигч болсон үгүйгээ шалгаж үзээд, дансаа нээлгэх юмсан хэмээн санааширч хонио хариулж яваа байх. Гэтэл интернэтээр дансаа шалгаж үзээд, "Иргэн Та Монгол Улсын Засгийн газраас олгосон "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн 536 ширхэг хувьцаа эзэмшиж байна" гэсэн сайхан өгүүлбэрт тайвширах хэрэггүйг "Монголын арилжаа

эрхлэгчдийн холбоо"-ны тэргүүн, "Монгол-999 үндэсний нэгдэл" ХК-ийн ТУЗ-ын Ажлын албаны дарга Б.Аюуш онцолж байгааг дуулгая.

Та юуны өмнө сүүлийн үед ашигтай бизнес байж магадгүй гэж монголчуудын хошуураад байгаа брокер, дилерийн компаниудаас аль нэгийг нь сонгож, хувьцааны харилцах данс нээлгэх учиртай. Ингэснээр иргэн Та 536 ширхэг хувьцаагаа эзэмших эзэмшлийн эрхээ албан ёсоор баталгаажуулж байгаа гэдгийг Б.Аюуш хэлж байна. Тэрбээр "Сүүлийн үед брокерийн компаниудад данс нээлгэхээр хандах хүмүүсийн идэвх суларсан. Ингэж тайвшрах нь уг нь буруу юм. Монголчууд хувьцаа эзэмших асуудалд цагийг нь тулгачихаад яарч сандардаг зангаараа хандаж болохгүй. Анх 536 ширхэг хувьцааг эзэмшүүлэхээс өмнө Тавантолгойн хувьцааг тараах тухай цуурхал нийгэмд гарах үед ҮЦТТХТ-д урт дараалал үүссэн. Тэрхүү ачааллын үед хоногт дунджаар 2500 данс нээж байсан. Гэтэл энэ эрчээр явлаа гэж бодоход бүтэн 3.6 жилийн хугацаа шаардагдахаар байгаа. Өнөөдрийн байдлаар манай улсын нийт хүн амын 400 мянга гаруйхан нь данстай. Үлдсэн 2.3 сая иргэн данс нээлгэх ажилд идэвх чармайлттай оролцоход дээр дурдсан цаг хугацаа шаардагдахаар буй юм" гэж тайлбарлав.

Харин одоо малчин Доржид хувьцааг яаж хүргэх вэ гэдэг асуудал руугаа эргээд орёе.

Монгол хүн бүр нэгэнт төрөөс эзэмших эрхийг нь өгсөн 536 ширхэг хувьцааныхаа жинхэнэ эзэмшигч

нь яаж болох вэ гэдэг асуултад хариулт олъё. Б.Аюуш "Ногдол ашиг хуваарилах үйлчилгээний хялбар боломж нээгдэж байгаа. Онлайн сүлжээ ашиглаж, мэдээллийг эх орны аль ч өнцөг буланд хүргэх боломжтой. Электрон гарын үсгийн хууль гаргахаар ажиллаж байгаа. Тэгэхээр электрон гарын үсгийн тусламжтайгаар цахим мэдээллийн санд нэвтэрч, төлбөр тооцоо хийж, арилжаанд оролцох боломжтой болно. Иргэний цахим үнэмлэхийг Улсын бүртгэлийн газар энэ оны эцсээр бэлэн болгохоор төлөвлөж байгаа юм билээ" хэмээв.

Мэдээллийн эрин зуунд гарч ирсэн гайхамшигт боломжийн нэг нь маргаангүй гар утас мөн. Хөдөө, орон нутгийн иргэд гар утастай болсноос хойш нэлээд хугацаа өнгөрч, малчин Дорж ч 2-3 төрлийн гар утас хэрэглэж байгаа нь яахын аргагүй үнэн. Электрон гарын үсгийн хууль гаргаж, хэрэгжүүлэх юм бол зөвхөн тухайн хүн өөрөө нэвтэрдэг хувийн нууц кодоо ашиглан гар утаснаасаа хувьцааны ногдол ашгийн мэдээллийг хүссэн үедээ авах бүрэн боломжтой болох аж. Мэдээж үүнийг нэвтрүүлэхтэй холбоотой хийх ажил багагүй байх нь ойлгомжтой.

Хувьцааны нэрлэсэн үнийг мартаж хэрэггүй

Хувьцаа эзэмшигч болсон эсэхээ шалгаж, данс нээлгүүлэхээс урьтаж иргэдийн бодолд сум шиг харван орж ирж байгаа нэг зүйл нь 536 ширхэг хувьцаа нийтдээ хэдэн төгрөг болох бол оо. Нэрлэсэн үнэ нь хэд байх юм бэ? гэдэг чухал байгаа. Дотоод, гадаадын хөрөнгийн зах зээлд ажиллаж, их бага хэмжээгээр туршлага хуримтлуулсан мэргэжилтнүүд "Иргэдэд хувьцааны нэрлэсэн үнэ танд огт хамаагүй гэдгийг хэлээд өгөөч ээ, сэтгүүлчид ээ" хэмээн учирлаж байна. Энэ үгийг "Монголын хөрөнгийн бирж"-ийн ТУЗ-ын дарга Б.Болд, "Монголын арилжаа эрхлэгчдийн холбоо"-ны тэргүүн Б.Аюуш гэх мэтийн хөрөнгийн зах зээлийн учир начрыг сайн мэдэх хүмүүс учирлаж байгаа юм. Тухайлбал, Б.Болд "Нэрлэсэн үнэ ард түмэнд огт хамаагүй, тэрийг бүр мартчих хэрэгтэй. Хувьцаа нь эрэлт, нийлүүлэлт дээр тогтог санхүүгийн бараа учир иргэдэд зах зээлийн үнэ л хамгийн чухал гэдгийг хөрөнгийн зах зээлийн талаарх сэтгүүлчдэд зориулсан сургалтын



» үеэр онцоллоо.

Мөн иргэдэд энэ удаагийн хувьцаа цэнхэр, ягаан тасалбар шиг болохгүй гэсэн баталгаа байна уу гэсэн болгоомжлол бий. Тэгвэл Төрийн өмчийн хорооны дарга Д.Сугар “Ягаан, цэнхэр тасалбар шиг болгохгүйн тулд эхний ээлжинд тодорхой хугацаанд зарахыг нь хязгаарлаж байгаа юм. Энэ хязгаарласан хугацаанд хоёр ажил хийнэ. Иргэдэд олон улсын хөрөнгийн зах зээлийг шинжилж чаддаг мэдлэг чадвар шаардлагатай. Мөн хувьцаа гэж ямар учиртай, яаж хэрэглэвэл амьдралд хэрэгтэй талаар мэдлэг, мэдээлэлтэй болгох хэрэгтэй. Энэ бол төрийн үүрэг” хэмээн ярьсан. Б.Аюуш ч иргэдэд хувьцаагаа нэг хэсэгтээ зарах хөдөлгөөн хийхгүй байх боломж нөхцөлийг нь төр юуны өмнө бүрдүүлж өгөх ёстой гэж үзэж байгаа юм. Тэр нь юу вэ гэхээр эхний ээлжийн ногдол ашиг хуваарилж, иргэдэд хувьцаа эзэмших нь ашигтай юм байна гэсэн итгэл үнэмшлийг бодитоор мэдрүүлэх явдал юм. Ингэснээр зарж үр шимийг нь хүртэхгүй өнгөрөхөөс сэргийлнэ гэж үзэж байна.

Харин сүүлийн үед арилжааны банк брокерийн үйлчилгээ эрхлэх тухай яриа гарч байгаа нь Б.Аюушийн санааг зовоож байгаа гэнэ. Тэрбээр “Арилжааны банкаар дамжуулж ногдол ашиг олгодог туршлага зарим хөгжилтэй оронд байдаг. Жишээ нь, ХБНГУ-д бий. Манай орны хувьд энэ нь тийм ч тохиромжтой сайн зүйл биш. Учир нь, банк бол андеррайтерийн үйлчилгээг эрхэлж болно. Харин брокерийн үйл ажиллагааг эрхэлж болохгүй. Хэрвээ банк брокерийн үйлчилгээг эрхлэх юм бол харилцагчийн мөнгө, үнэт цаасыг захиран зарцуулах эрхтэй болно гэсэн үг. Хөрөнгийн зах зээлийн бүх үйлчилгээг банкинд даатгах хэрэггүй. Банк дангаараа ноёрхсон гаж санхүүгийн тогтолцоо нь манай санхүүгийн системийг эрсдэлд оруулах магадлалтай. Харин харилцагч өөрөө кастодиан банк буюу мөнгөн хөрөнгөө итгэмжлэн дамжуулах арилжааны банкиг сонгож, үйлчлүүлж болно. Кастодиан банкны үйлчилгээ бол үнэхээр өнөөдрийн цаг үед манайд зайлшгүй шаардлагатай байгаа” гэж ярьсан. Түүний нэг болгоомжлоод байгаа зүйл нь банк нь брокерийн үйл ажиллагааг эрхлэх юм бол

иргэдийн хувьцааг худалдаж авах нөхцөл бүрдэхийг үгүйсгэхгүй гэж үзэж байгаа юм.

50 сая төгрөг. Гэтэл санхүүгийн орчин өөрөө өөрчлөмтгий байдаг учраас хуулинд яаралтай өөрчлөлт

...Хувьцаа эзэмшигч болсон эсэхээ шалгаж, данс нээлгүүлэхээс урьтаж иргэдийн бодолд сум шиг харван орж ирж байгаа нэг зүйл нь 536 ширхэг хувьцаа нийтдээ хэдэн төгрөг болох бол оо. Нэрлэсэн үнэ нь хэд байх юм бэ? гэдэг чухал байгаа. Дотоод, гадаадын хөрөнгийн зах зээлд ажиллаж, их бага хэмжээгээр туршлага хуримтлуулсан мэргэжилтнүүд “Иргэдэд хувьцааны нэрлэсэн үнэ танд огт хамаагүй гэдгийг хэлээд өгөөч ээ, сэтгүүлчид ээ” хэмээн учирлаж байна...

Унтаа брокерийн компаниуд үнэд оров уу?

ҮЦТТХТ-д бүтгэлтэй 47 компаниас гадна Санхүүгийн зохицуулах хороонд брокерийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүссэн өргөдөл олноороо ирж байгаа мэдээлэл бий. Өнөөдрийн ҮЦТТХТ-ийн цахим хуудсанд дурайж байгаа 50-иад брокер дилерийн компаниас хэд нь хөдөө, орон нутагт салбартай вэ? Энэ асуудлыг Тавантолгойн хувьцаа тараах тухай шуугианы үеэр сонирхоход “Би Ди Сек” компани Төв аймаг, Эрдэнэтэд салбартай гэхээс илүү мэдээлэл байдаггүй байсан. Харин хүн бүр хувьцаа эзэмшигч болсонтой холбоотойгоор “Eurasia Capital” групп өнгөрсөн дөрөвдүгээр сарын сүүлчээр Орхон, Дархан-Уул, Даланзадгадад салбараа нээсэн дуулдав. ТӨХ-ны дарга Д.Сугар ч “1990-ээд оны үед цэнхэр, ягаан тасалбар тараах үед брокерийн компаниудыг бүх орон нутагт нээж байсан. Одоо ч нэмж нээх ёстой” хэмээн ярьсан байсан.

Брокерийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл хүссэн хүсэлтийн талаар Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Д. Дүгэржаваас тодруулахад, “Сүүлийн үед брокер дилерийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл хүссэн өргөдөл Санхүүгийн зохицуулах хороонд олноор ирж байгаа нь үнэн. Хуулинд заасан нөхцөлүүдийг бүрдүүлээд ирж байгаа болохоор татгалзах үндэслэл гарахгүй байгаа. 2002 оны хуулинд зааснаар бол брокерийн компанийн дүрмийн сан

оруулах шаардлагатай байна” гэв.

Брокер дилерийн компани зөвхөн данс нээгээд амар баяжиж болохоор юм байна гэсэн бодлоор энэ бизнес рүү хошуурч, брокерийн компани борооны дараах мөөг шиг олшрох хандлага нийгэмд бий болжээ. Төрийн өмчийн хорооноос брокер, дилерийн компаниудын босгыг өндөрсгөх шаардлагыг холбогдох байгууллагуудад тавьж эхэлсэн нь сайшаалтай.

Мөн монгол хүн бүр хувьцаа эзэмшигч болсонтой холбоотойгоор брокерийн компаниудын эрэлт ихэсч, 50-иад брокерийн компанийн ихэнх нь худалдагдаж байгаа гэсэн мэдээлэл чих дэлсэв. Гэхдээ энэ бол хэн нэгэн албаны хүний амнаас сонссон үг биш, албан бус мэдээлэл гэдгийг хэлэх нь зүйтэй байх.

Хөрөнгийн биржтэй хамт 20 жил унтсан манай брокерийн компаниуд өмнө нь огт санаж бодож байгаагүй боломжийн үнээр борлогдсон гэсэн мэдээлэл үнэн байх талтай. Учир нь, хүн бүр хувьцааны арилжаанд оролцоод, хөрөнгийн зах зээл хөгжөөд ирэхээр хүссэн хүсээгүй брокерийн үйлчилгээ мөнгө ахиу олдог чухал байгууллага болж хувирна гэж ярих хүн цөөнгүй. Бодоод үзэхээр, тийм үндэслэл байх талтай учраас бизнесийн гүйлгээ ухаантай зарим нь боломжийг урьдчилж хараад, худалдаж авч байхыг үгүйсгэхгүй. Энэ нь гэхдээ буруу нь юу байх вэ? Хамгийн гол нь брокерийн компаниудын шаардлага шалгуурыг өндөрсгөж, үйлчилгээг нь өргөжүүлэн чанаржуулж, зөв хөгжүүлэх учиртай. ■

Ашигт малтмал

Алдагдсан боломж буюу алтны ралли

Дэлхийн зах зээл дэх алтны үнэ хүн төрөлхтнийг алмайруулж байна. Дөрөвдүгээр сарын 29-нд унци алт 1565 ам.доллараар арилжаалагдсанаар түүхэн дээд түвшиндээ хүрчээ. Гэтэл нэгэн үед алтаар аврагдаж байсан Монгол оронд шар металлын олборлолтын хэмжээ гэрлийн хурдаар буурч буй. Төвбанкинд тушаах алтны хэмжээ таван жилийн дотор долоо дахин багассан байх жишээтэй. Уг металлын үнэ тэнгэр чиглэн түргэлж буйгаас олон улсын алтны зах зээлд урд хожид үзэгдээгүй өөрчлөлт бий болжээ. Харин Монгол оронд 68 хувийн татвар үгүй болсон ч оронд нь урт нэртэй хууль гарч ирснээр алтны үнийн өсөлтийг ардаа орхиж, “алтан боломж”-оо алдах шинжтэй.

Амьдралд ойрхон ховор эрдэнэ

Эрчүүд хайртай бүсгүйдээ гэрлэх санал тавихдаа юу өгдөг билээ? Мэдээж алтан бөгж! Энэ ч утгаараа шар металл хайр дурлалын бэлгэ тэмдэг хэмээн тооцогддог биз ээ. Гэвч олон мянган жилийн турш алт нь хайр дурлал төдийгүй хагацал зовлонгийн ужиг шалтгаан болж ирсэн. Алтнаас болж энэ ертөнцөд дайн дажин хэчнээн болсныг хэлэхэд хэцүү.

6000 жилийн тэртээ алтаар анх гоёл чимэглэлийн бүтээгдэхүүн хийж байсан гэх. Үүнээс хойш алтны хэрэглээ хүрээгээ тэлсээр анагаах ухаан, өндөр технологийн нэгдэхэн бүрэлдэхүүн болсон байдаг. М.э.ө. 600 онд алтаар хиймэл шүд хийж эхэлсэн бөгөөд энэ нь эрүүл мэндийн салбарт шар металлыг ашиглах анхны туршилт болж байв. 1985 онд эмийн үйлдвэрлэлийн “SmithKline & French” компани “Auranofin” гэдэг эмийг уг шар металаас гаргаж авсан бол 2001 оноос алтыг ангиографийн салбарт ашиглаж, зүрхний мэс



засалд хэрэглэх болсон байна.

1961 онд АНУ-ын “Bell Labs” микрочипийн утаснуудыг алтаар холбож туршсан бөгөөд эдүгээ зөөврийн компьютер, гар утас хийхэд ч уг металлыг ашиглах болсон ажгуу. Шинжлэх ухааны хувьсгалын хөдөлгүүр алт болж, нанотехнологи, химийн үйлдвэрлэлд хүчтэй нэвтрэн ороод буй.


Нөгөө талаас алтыг дэлхийн санхүүгийн барилгын тулгуур ч гэдэг. Уг металлыг олон улсын валютын зах зээлд хамааруулсан байвал гайхах зүйлгүй. XAU бол олон улсын стандартын байгууллагаас алтанд оноосон валютын код юм. Тийм ч учраас санхүүгийн зах зээлд алтны данс гэсэн ойлголт бий. Өөрөөр хэлбэл, алтаар нэгж нь илэрхийлэгддэг төлбөр тооцооны дансыг арилжааны банкууд ашигладаг. Ийм дансанд хадгалагдаж байгаа алт нь биет бус байдаг бөгөөд чөлөөтэй хөрөнгө оруулалт хийх боломжийг олгодог ажээ.

Дэлхийн санхүүгийн тогтолцооны нэгэн бүрэлдэхүүн болж, хүний амьдралын байнгын хэрэглээнд хамгийн ойр байдаг гэдэг утгаараа алт аль ч металлыг араасаа дагуулахгүй. Тэгсэн атлаа энэ нь тун ч ховор эрдэнэ ажээ. Нэг унци алт олох нь таван карат алмас эрдэнэ олохоос ч түвэгтэй байдаг гэнэ. Ер нь хүн төрөлхтөн түүхэндээ 165 мянга гаруй тонн алт ухаж гаргасан гэх тойм тооцоо бий аж. Энэ нь химийн элемент учир устаж үгүй болохгүй,

оршин тогтносоор байна гэсэн үг.

Энэтхэгийн чамирхал хийгээд Төвбанкуудын айдас

Дэлхийн алтны нийт эрэлт 2010 онд есөн хувиар нэмэгдэж, 3813.2 тоннд хүрсэн нь сүүлийн 10 жилийн дээд үзүүлэлт болсон байна. Алтны нийт эрэлтийн талаасилүүхвийг гоёл чимэглэлийн үйлдвэрлэл бий болгож иржээ. Энэтхэгийн гоёл чимэглэлийн бүтээгдэхүүний хэрэглээ өнгөрсөн онд 69 хувиар суга өсөж, 746 тоннд хүрснээр рекорд тогтоов. Дэлхийд үйлдвэрлэгдэж буй нийт алтны тав хуваасны нэг нь энэтхэгчүүдийн эзэмэг, бөгж болж хувирдаг гэсэн үг л дээ. Тус улс дэлхийн алтны эрэлтийн гол зүтгүүр болж ирсэн бол сүүлийн үед Хятадын хэрэглээ асар ихээр нэмэгдэж байгааг шинжээчид онцолж байна. 2010 онд зөвхөн энэ хоёр орон дэлхийн зах зээлд нийлүүлсэн алтан гоёл чимэглэлийн бүтээгдэхүүн, гулдмай, зоосны 51 хувийг худалдаж авсан аж.



» Ер нь алтны эрэлтээрээ Энэтхэг, Хятад, Турк, Дундад Ази дэлхийд тэргүүлнэ. Үүнийг тухайн орнуудын онцлог, түүх соёл, шашин шүтлэгтэй холбон тайлбарлаж болно. Тухайлбал, Энэтхэгийн хүн амын 80 хувь нь Хинди шашинтай бөгөөд алтыг бурхны бэлэг гэж үздэг. Уг шар металл бол бэл бэнчин, хөгжил цэцэглэлтийн бэлгэ тэмдэг гэж шашинд нь номлодог ажгуу. Тийм ч болохоор энэтхэгчүүд үндэсний баяр наадам, хурим найр болгоноор л гэр бүл, ойр дотныхондоо алт бэлэглэх заншилтай.


2010 онд улс орнуудын Төвбанк алт ихээр худалдан авах болсон нь эрэлт нэмэгдсэний бас нэгэн шалтгаан. Энэ нь сүүлийн 21 жилд анх удаа тохиолдож буй үзэгдэл юм. 100 гаруй жилийн турш албан сектор буюу Төвбанкууд алтны гол эзэмшигчид байж иржээ. Харин 1971 онд Ерөнхийлөгч Никсон “Алтан цонх”-ыг хааснаас байдал өөрчлөгдөж, Төвбанкууд алтаа ихээр зарах болсон байна. Энэ нь ханшийн савлагаа бий болгож, зах зээлд сөргөөр нөлөөлөхөөс хамгаалах хэрэгтэй боллоо. Ингээд 1999 онд Европын орнууд CBGA (Central Bank Gold Agreement) гэрээг үзэглэснээр албан секторын зах зээлд нийлүүлэх алтны хэмжээг жилийн 400 тонноор хязгаарлажээ. Үүнийг 1999 оны Вашингтоны пакт ч гэж нэрлэдэг. 1989-2007 онд Төвбанкууд жилдээ 400-600 тонн алт зардаг байсан бол 2009 онд ердөө 30 тонныг борлуулсан байна. Харин өнгөрсөн жил албан сектор алтны томоохон худалдан авагч болж хувирсан нь гайхалтай.

Өнгөрсөн онд ОХУ 135 тонн алт авч, дэлхийг алмайруулсан бол Хятад, Тайланд, Бангладеш, Венесуэл, Филиппин зэрэг олон орон уг металлыг ихээр төвлөрүүлэх болсон нь гадаад валютын нөөцөө хамгаалах сонирхолтой нь холбоотой байлаа. Санхүү, эдийн засгийн хямрал цаашилсан ч дэлхий айдаст автсан хэвээр. Европын өр, Японы гамшиг, Хятадын инфляци гээд олон шалтгааны улмаас улс орнууд валютын нөөцөө дундрахаас сэргийлж, алт ихээр авах болжээ. Тийм ч учраас Олон улсын валютын сангийн зарсан 403.3 тонн алтыг ихэвчлэн Төвбанкууд худалдаж авсан байдаг.

Харин техник технологи буюу үйлдвэрлэлийн салбарт 2010 онд 419.6 тонн алт хэрэглэсэн нь уг металлын нийт эрэлтийн ердөө 10 хувийг л бий болгожээ.

Өмнөд Африк байр сууриа Хятадад алджээ

XX зууныг хүртэл Өмнөд Африк дэлхийн зах зээл дэх алтны гол нийлүүлэгч байв. 1970-аад оны эхээр тус улс жилдээ 1000 тонн алт олборлодог байсан нь дэлхийн нийт үйлдвэрлэлийн 70 орчим хувийг эзэлж байлаа. Гэхдээ өнгөрсөн 20 жилд байдал эрс өөрчлөгдсөн байна. Эдүгээ алтны олборлолтоороо Хятад орон дэлхийд тэргүүлэх болов. 2009



онд тус улс 330 тонн шар металл олборлосон бол Австрали 223 тонноор удаалж, Өмнөд Африк 222 тонноор гуравдугаарт шидэгдсэн байх жишээтэй.

Ер нь сүүлийн жилүүдэд алтны үнэ тасралтгүй өсч байгаагаас шар металл олборлох сонирхол нэмэгдэж, хөрөнгө оруулагчид ч хөрснөөс энэхүү эрдэнэсийг олохыг тулд мөнгөө харамгүй цацах болж. 2010 онд алтны олборлолт өмнөх жилийнхээсээ есөн хувиар нэмэгдэж, 2543 тоннд хүрчээ.

Гэхдээ сүүлийн таван жилийн байдлаас үзэхэд уурхайнуудаас


алтны нийлүүлэлтийн 59 хувийг л хангадаг аж. 31 хувийг нь алтыг дахин боловсруулах замаар гаргаж авдаг юм байна. Алт өөрөө химийн элемент учир устаж алга болохгүйг бид мэднэ. Тийм ч учраас алтыг дахин боловсруулах нь нийлүүлэлтийн нэг чухал бүрэлдэхүүн бөгөөд 2010 онд 1672 тонн алт дахин боловсруулжээ.

Харин өнгөрсөн жилүүдэд нийлүүлэлтийн 10 хувийг албаны салбар буюу Төвбанкууд алт зарах байдлаар бий болгодог байлаа. Гэвч санхүү, эдийн засгийн хямралаас хойш буюу 2008 оноос Төвбанкууд алт зарахдаа хойрго хандаж, эсрэгээрээ бүр худалдан авагч болж эхэлснийг дээр дурдсан билээ.

Алтаар аврагдсан Монгол

1990-ээд оны эхээр Монголын эдийн засаг маш хүнд нөхцөлд орсон үед хамгийн бага зардлаар, хамгийн богино хугацаанд эдийн засгаа тогтворжуулах шаардлагатай болсон. Ерөнхийлөгч П.Очирбат 1991 онд “Алт” хөтөлбөрийг баталж, энэ хүрээнд тусгай зөвшөөрөлтэй 120

гаруй аж ахуйн нэгж байгуулагдан, олборлосон алтаа Төвбанкнд тушааж, Монголын валютын нөөцийг нэмэгдүүлсэн билээ. Тэр үеэс алт олборлолтын хэмжээ асар ихээр өсөж, 2005 онд 24.1 тонноос даван рекорд тогтоож байв. Монголбанкнд тушаасан алтны хэмжээ ч 15.2 тоннд хүрч байсан удаатай. Гэвч 2006 оноос эдгээр үзүүлэлт навс унасан байгааг графикаас харахад ойлгомжтой болов уу. “Энэ бол 68 хувийн татвараас үүдсэн хэрэг, түүнээс л болж ил, далд хар захаар борлуулахад хүрсэн гэж алт олборлогчид ярьдаг юм билээ” хэмээн ШУТИС-ийн “Экологи-



Уул уурхай

» тогтвортой хөгжлийн төв"-ийн захирал П.Очирбат учирлаж байлаа. Харин өнөөдөр Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар хүчингүй болсон. Ингэснээр Монголын алтны салбар сэргэж, Монголбанкинд тушаах алтны хэмжээ нэмэгдэв үү? Энэ оны гуравдугаар сарын 21-ний байдлаар Төвбанк дотоодын алтны зах зээлээс 270 кг алт худалдан авсан нь өнгөрсөн оны мөн үеэс 64.7 хувиар өссөн үзүүлэлт ажээ. Гэхдээ энэ нь найдлага төрүүлэхээр тоо биш юм. Өнгөрсөн онд Төвбанкинд тушаасан алтны хэмжээ шалдаа буусантай харьцуулахад л бага зэрэг өссөн хэрэг болохоос биш 2005 оныхтой зүйрлэх ч аргагүйг мэргэжилтнүүд онцолж байна.



Эх сурвалж: kitco.com

Алтны үнэ оргил цэгтээ хүрсний зэрэгцээ 68 хувийн татвар "Буе буе" болчихсон байдаг. Тэгвэл яагаад Монголын алтны салбар сэргэхгүй байна вэ гэдэг асуулт зүй ёсоор гарч ирнэ. Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварыг хүчингүй болгосон хэдий ч УИХ-ын гишүүд маань дахиад нэгэн хууль санаачилж, алт олборлогчдоо сюрприз барьсан билээ.

"Эхний ээлжинд 254 лиценз цуцлах шийдвэр гарсан, цаашид уул уурхайн 1700 орчим тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно" хэмээн Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт мэдэгдсэн нь Монголд төдийгүй дэлхийд сенсаац дэгдээж байв. Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль буюу "Урт нэртэй" хэмээн өхөөрдөн нэрлэсэн хуулийг хэрэгжүүлж эхэлсэн нь энэ ажгуу. Дээрх 254 тусгай зөвшөөрөл нь зөвхөн алтны шороон ордынх бөгөөд нэр нь нэгэнт тодорхой болсон тухай салбарын сайд нь онцолж байсан. Энэ нь манай орны алтны нийт нөөцийн 40 орчим хувийг эзэлж

байгааг тэрбээр мөн тайлбарласан юм.

Уг нь Төвбанк дотоодын алт олборлогчдоос уг шар металлыг худалдан авахдаа дэлхийн зах зээл дэх ханшаас ердөө хоёр ам.доллар доогуур үнэлдэг юм. Түүнийгээ цэвэршүүлж, олон улсын санхүүгийн зах зээлд арилжаалан гадаад валютын нөөцөө нэмэгдүүлдэг. Гэвч амьдрал дээр хэрэгжүүлэхэд бэрх нэг хуулийг нөгөө нь орлосоор алтны салбарт үйл ажиллагаа явуулдаг 100 гаруй компанийг хиар цохижээ. Тийм ч болохоор монголчууд дэлхийн зах зээлд алтны үнэ тэнгэрт хадсан аятай үеийг ардаа орхиж байгаа юм.

Үнэ өссөөр байх уу?

2001 онд 250 ам.долларт хүрэхтэй, үгүйтэй байсан унци алтны үнэ эдүгээ зургаа дахин өсөж, 1500 ам.долларт хүрснийг графикаас харна уу. Өнгөрсөн жил уг шар металлын ханш 35 удаа түүхэн дээд амжилтаа эвдэж, нийт 26 хувиар дээшилсэн бол он гарсаар ч мөчөөгөө өгөхгүй, тэнгэр өөд тэмүүлсээр. Энэхүү гайхамшигт явдлын талаар шинжээчид янз бүрийн байр сууритай байгаа юм.

"Инфляци гаарч буй өнөө үед трейдерүүд цаасан мөнгө өөртөө байлгахыг хүсэхгүй байна. Тэгэхээр алтнаас өөр сонголт алга байна даа" хэмээн "OptionsXpress" холдингийн түүхий эдийн ахлах шинжээч Роб Курзатковски онцолжээ. Харин GFMS компанийн захирал Филип Клапвийк "Алтны үнэ цаашид ч өссөх болов уу. Хөрөнгө оруулагчид инфляцид санаа зовсоор байгаа бол Засгийн газрууд мөнгөний бодлогоо чангаруулах тал дээр хөдлөх шинжгүй. Тиймээс оны эцэст унци нь 1600 ам.долларт хүрвэл бид гайхахгүй" гэжээ.

"Энэтхэг, Хятадын алтны эрэлт нэмэгдэж, Америкийн бодлогын хүү сул байгаа учраас 2014 он хүртэл алтны ралли үргэлжилж мэднэ. Техникийн үндсэн дээр гаргасан бидний судалгаагаар бол 2014 онд унци алт 2107 ам.доллар, 2020 он гэхэд 4869 ам.доллараас давж мэднэ" хэмээн "Standard Chartered" банкны шинжээчид тэмдэглэсэн тухай "The Telegraph" мэдээлэв.

Харин HSBC банкны шинжээчдийн гаргасан таамаглал амьдралд арай ойрхон тусаж магадгүй юм. Тус банкны мэргэжилтнүүдийн үзэж буйгаар энэ онд унци алтны дундаж

ханш 1525 ам.доллар байх бол 2012 онд уг үзүүлэлт 1500, 2013 онд 1450 ам.доллар болж буурахаар байгаа юм. Хөгжингүй орнуудын эдийн засаг бүрэн сэргэж, Төвбанкууд дэлхийг айдасг автуулж буй инфляцитай тэмцэхийн тулд мөнгөний бодлогоо чангаруулаад эхлэхээр хөрөнгө оруулагчид алтанд "нүд унагах" нь багасна хэмээн шинжээчид тайлбарлаж байна.

Ер нь дэлхийн эдийн засгийн байдал доройтох, тогтворгүй болох үед алтны үнэ цэнэ нэмэгддэг нь амьдралаар батлагдсан билээ. Санхүү, эдийн засгийн хямралын үеэр бүх таваарын үнэ шалдаа бууж байхад гагцхүү алтны ханш л дээшээ цойлж байсан нь үүнтэй холбоотой. Харин өнөөдөр дэлхийн улс орнуудыг баян, ядуу хэмээн ялгалгүй хиар цохиж эхэлсэн инфляци алтны үнийн раллигийн гол хөшүүрэг болоод байгаа аж. Гэхдээ бидний урд, хойд хөршөөс эхлээд Европын Төвбанк хүртэл инфляцийг "чөдөрлөх"-ийн тулд бодлогын хүүгээ нэмж эхлээд буй. Энэ байдал цааш үргэлжилж, томоохон орнууд мөнгөний бодлогоо чангаруулах аянд гарваас шар металлын ханшид сайнаар лав нөлөөлөхгүйг шинжээчид онцолж байна.

1981 онд алтны ханш тэнгэрт хадаж, унци нь 873 доллар болсон удаатай. Дараа нь дэлхийн эдийн засгийн өсөлт эрчимжиж, хөрөнгийн захзээлсаярхурданөргөжинтэлснээр 20 жилийн турш уг металлын үнэ тасралтгүй унасаар 1999 онд унци нь 253 доллар болтлоо шалдаа буусан гээд бод доо. Тиймээс АНУ, Европын орнуудын эдийн засаг сэргэхэд алтны үнийн ирээдүй бүрхэг болохыг хэн ч үгүйсгэхгүй. Энэ тохиолдолд бид алтны үнэ дээд цэгтээ тулсан үе буюу "алтан боломж"-ийг ашиглаж чадалгүй үлдэх билээ.

Эх сурвалжууд:

1. World Gold Council, "Gold Demand Trends Full Year 2010", "An investor's guide to the gold market"
2. АМГ, "Алт олборлолт, зах зээлийн хэтийн төлөв" судалгаа
3. Монголбанк
4. Монголын санхүүгийн зах зээлийн холбооны ерөнхийлөгч Ө.Ганзориг, "Алтны үнийн хандлага" нийтлэл
5. Kitco
6. "Bloomberg", "Reuters", "The Telegraph", "Ведомости" ■

Бэлгэдэл төдий ТУЗ минь


Б.Санжааханд

“Mongolian Economy” сэтгүүл энэ дугаараасаа эхлээд “Хууль” гэсэн шинэ булан нээж байна. Манай энэ буланд хуультай холбоотой олон асуудлыг хөндөж болохоос гадна ямар хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулах гэж байгаа талаар байнга сонирхуулж байх юм. Бид шинэ булангийнхаа эхний сэдвээр Компанийн тухай хуулийг сонголоо.

Хамгийн сүүлд 1999 онд шинэчлэн баталсан Компанийн тухай хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулахаар Ажлын хэсэг гарч ажиллаад, УИХ-ын хаврын чуулганаар батлуулах төлөвлөгөөтэй байгаа юм билээ. Хөрөнгийн зах зээлийн хөгжлийн шанг татаж, Монголд орж ирэх гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ үлэмж ихээр нэмэгдэж байгаагийн сацуу үндэсний компаниуд ч мөнгөжиж, төсвийн орлого ч өсөх хандлагатай. Манай орны эдийн засаг энэ жил 10 хувиар томорч, цаашдаа өсөлтийн хурд саарахгүй төлөвтэй. Энэхүү хөгжлийн хурд, цаг үеийн шаардлага нь Компанийн тухай хуулийг шинэчлэн найруулахад хүргэж байгаа гэж хэлж болно.

Уг хуулийн өөрчлөлтийн тухай Ажлын хэсгийн гишүүн Б.Аюуш хэлэхдээ, “Компанийн засаглалыг сайжруулах, ил тод байдлыг хангах, удирдлагыг чадваржуулах, тэдний үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх, хувьцаа эзэмшигчдийн эрхээ эдлэх боломжийг хангахад чиглэнэ. Нэг үгээр хэлбэл, компанийн эрхийг

Хувьцаат компани



Шог зургийг А.Амарсайхан

дээгүүрт тавьсан хууль болж өнгөө засах юм. Хуулийн боловсруулалт нэлээд хурдтай явж байгаа. УИХ-ын Эдийн засгийн байнгын хороогоор энэ долоо хоногт /тавдугаар сарын 9-нөөс 13-н/ хэлэлцэгдэх гэж байгаад хойшилсон. Ажлын хэсэгт багтсан УИХ-ын гишүүн Р.Буд, Д.Зоригт, Ц.Баярсайхан, Ц.Мөнх-Оргил, З.Энхболд нар Компанийн тухай хуулийг эдийн засгийн суурь хууль гэдэг үүднээс авч үзэж, маш сайн болгохын төлөө идэвх чармайлттай ажиллаж байгаа” хэмээн онцолсон.

Дээрх хуульд олон нарийн зүйл заалт шинээр орж байгаа юм билээ. Гэхдээ хуулийн төсөл одоогоор Эдийн засгийн байнгын хороогоор ч хараахан орж амжаагүй, Ажлын хэсгийн түвшинд яригдаж байгаа

учраас хуулинд орох нэмэлт, өөрчлөлтүүдийг зүйл, заалтаар нь нарийн сонирхуулахад эртдэх учраас гол гол өөрчлөлтийн талаар сонирхуулъя.

Хуулийн шинэчлэл бол ХХК-ийн асуудлаар нэг их оролдоогүй, харин олон хүний эрх ашиг, сонирхлыг хөнддөг гэдэг утгаараа ХК-ийн асуудлыг нэлээд чухал авч үзэж байгаа ажээ. Нэг үгээр хэлбэл, ХК-ийн шүүсийг сайтар шахсан хуультай болно гэсэн үг. Тухайлбал, ХК-ийг дотор нь хаалттай, нээлттэй гэж ангилж авч үзэж байгаа гэнэ. Ингэснээр ХК-тай холбоотой хуулийн нарийн заалтуудыг мөрдүүлэх, компанийн засаглалыг сайжруулах, ил тод байдлыг хангах, компанийн удирдлага хариуцлага хүлээдэг

► байх зэрэгт нэлээд анхаарсан хуулийн зүйл заалт оруулж байгаа аж. Хувьцаат компанийг дотор нь хаалттай, нээлттэй гэж ангилж өгч байгаа нь тухайн нээлттэй компани заавал хувьцаа гаргахдаа гол нь биш, гаргахгүй ч байсан болох юм. Хамгийн гол нь банк, санхүүгийн байгууллага, даатгал мэтийн олон нийтийн эрх ашгийг хөнддөг компанийн хариуцлагыг өндөрсгөх, хуулийг мөрдүүлэх үүднээс ийн ангилж байгаа аж. Нэг үгээр хэлбэл, ХХК-аас ХК илүү их үүрэг, хариуцлага хүлээдэг учраас, түүнийг нь ойлгуулах цаг болсон гэдгийг хуулиар мэдрүүлэх нь.

Дараагийн чухал өөрчлөлт нь хувьцаа эзэмшигчдийн эрхийн асуудал юм. Өнөөдөр манайд олон ХК үйл ажиллагаа явуулж байгаа ч жижиг хувьцаа эзэмшигчдээ хохироосон банк, санхүүгийн байгууллага цөөнгүй бий. Энэ алдаа нь Компанийн тухай хуулийг эдүгээ сайжруулан чангатгахад сургамж болж байгаа нь дамжиггүй. Хувьцаат компанийн хувьд хувьцаа эзэмшигчдийг том, жижиг гэлтгүй, хуулиараа бол бүгдийн эрхийг хүндэтгэх учиртай. Хэрвээ манайхан өмнөх гашуун туршлагаасаа суралцахгүй том хувьцаа эзэмшигчдийг хүндэтгээд, жижгүүдийн эрх ашгийг уландаа гишгэсэн хэвээр байх юм бол нийгэмд маш муу үр дагавартайг мэргэжилтнүүд онцолж байгаа юм. Тэгэхээр Компанийн тухай хуулиар энэ асуудлыг нэлээд нарийн чанад болгох гэнэ. Хууль эрх зүйн эрүүл орчин бүрдүүлсэн нөхцөлд иргэд хамгийн том хөрөнгө оруулагч байдаг жамтай. Өөрөөр хэлбэл, хөгжилтэй орнуудын иргэд улсынхаа эдийн засгийн хөрөнгө оруулагч нь байдаг гэсэн үг. Тиймээс ч “Иргэн баян бол төр баян” гэсэн үг зүгээр ч нэг гараагүй бололтой. Манайхан энэ үгийг хэлэх дуртайгаас цаашгүй. Гэтэл хөрөнгийн захын онолоороо бол хамгийн том, хамгийн найдвартай хөрөнгө оруулагч бол иргэд байдаг гэж үздэг. Онол ч гэж дээ энэ нь манайхаас бусад улсад дагаж мөрддөг зүйл.

Мөн өнөөдөр манайд гаднын санхүүжилттэй компани томорч, өргөжин дэвжиж байгаа болохоос үндэсний хөрөнгө оруулалттай компаниуд төдийлөн өсөн дэвжиж

чадахгүй байгаа нь хувьцаа эзэмшигчдийн эрх, зөв засаглал, компанийн ил тод байдалтай холбоотой. Тэгвэл өнгө зүсээ сайжруулан дахин төрөх Компанийн тухай хуулинд энэ асуудлыг шийдвэрлэсэн цөөнгүй зүйл заалт оруулахаар ажиллаж байгаа нь олзуурхууштай.

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй ч ямар ч үйл ажиллагаа эрхэлдэггүй, хаана яваа нь мэдэгддэггүй 100-гаад компани бий гэх. “Тэдгээрийг биржийн бүртгэлээс шууд автоматаар хасчихаар яадаг байна аа” гэж шүүмжлэх хүн олон. Гэтэл эдгээрийг эрхлүүлж байгаа мэт чимээгүй байлгаад байдаг нь цаанаа учиртай бололтой. Хэрвээ тэдгээр компанийг биржийн бүртгэлээс шууд хасах юм бол шийтгэж байгаа биш, харин ч шагнасан хэрэг болох гэнэ. Тиймээс тэднийг амар хялбар тавилгүй, хуулийн хариуцлагыг нь хүлээлгэх нь зөв гэж холбогдох албаныхан болоод мэргэжилтнүүд үздэг байна. “Компаниуд хуулиар хүлээсэн үүргээ хүлээж байж л хөрөнгө татаж чадна. Харин энэ нөхцөлийг компанийн засаглал бүрдүүлж, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалдаг гэх үү дээ. Угаасаа мэдээллийн ил тод, бодитой байдал нь хөрөнгийн зах зээлийн хөгжилд маш чухал. Хөрөнгө оруулагчид мэдээллээр тэжээгдэж байдаг юм. Үүнд л компанийн засаглалын ачаа холбогдол оршино. Компанийн засаглал нь зөвхөн хувьцаат компани гэлтгүй банк, олон нийтийн болон төрийн байгууллага гээд бүгдэд хамаатай ” гэж Монголбанкны ерөнхийлөгч асан Ж.Үнэнбат ойлгомжтой тайлбарласан удаатай. 1990-ээд оноос дэлхий даяар тархаж эхэлсэн компанийн засаглал гэх ойлголт манайд өнөөдөр дөнгөж эхлэл төдий байгаа гэж хэлж болох. 2007 оны сүүлчээр Монголд “Компанийн засаглалын кодекс”-ыг гаргасан ч хэрэгжилтийн тал дээр хэлэхэд нүүр улаймаар дүр зураг ажиглагддаг юм билээ.

Тухайлбал, “Санхүүгийн жил дуусгавар болсноос хойш дөрвөн сарын дотор Хувьцаа эзэмшигчдийн хурлаа хийж, санхүүгийн тайлангаа ирүүлнэ” гэж хуулинд заасан байдаг ч манайхан үүнийг огтхон ч тоодоггүй. Энэ хурлыг хийх

нь хувьцаа эзэмшигчдийн хувьд мэдээлэл авах, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад маш хэрэгтэй зүйл байдаг гэдгийг Б.Аюуш цохон тэмдэглэж байна. Түүнчлэн Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй 336 компанийн 33 нь л 2010 оны санхүүгийн тайлангаа ирүүлсэн бол ердөө 19 нь ногдол ашгаа тараасан байх жишээтэй. Энэ таагүй байдал шинэ хуулиар засагдана гэж найдъя.

Хуулийн шинэчлэлийн дараагийн асуудал ТУЗ-ийн тухай юм. Өнөөдөр манайд зөвхөн компани ч гэлтгүй, банк, олон нийтийн болон төрийн гээд ТУЗ томилоогүй аж ахуйн нэгж, байгууллага ховор. Чухам ТУЗ-ийг хэн, ямар шалгуураар томилдог билээ? ТУЗ өөрийн үүрэг харицлагаа ухамсарлах гэж оролддог бил үү? Ямар нэгэн хариуцлага хүлээдэг бил үү? Эдгээрт сайн мэдэхгүй, үгүй гэсэн хариулт л олдоно. Цөөн тооны засаглалыг сайн хэрэгжүүлдэг, ТУЗ-дөө сайн хуульч, сайн санхүүч зэрэг мэдлэг чадвартай хүн оруулах нь зөв гэж үздэг, ил тод үйл ажиллагаатай компани бийг үгүйсгэхгүй л дээ.

Энэ удаагийн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр ийм үүрэг хариуцлагыг ухамсарласан компанийн тоог олшруулах зорилготой. ТУЗ-ийн гуравны нэгийг хараат бус том хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх удирдлага гэсэн зарчим суулгаж өгч байгаа аж. 1999 оны Компанийн тухай хуулиар ТУЗ есөөс доошгүй гишүүнтэй байна гэж заасан нь ТУЗ-ийг үүрэг хариуцлага мэддэггүй, мэдэхийг хүсдэггүй олон орон тоо бөглөсөн хүнтэй болгосон нь утгагүй зүйл болсон гэдгийг холбогдох мэргэжлийн хүмүүс шүүмжилдэг. Манайхан ТУЗ-ийн гишүүний үүрэг хариуцлагыг ойлгодоггүй, ач холбогдол өгдөггүй учраас гишүүний тоо ес байна гэдгийг нь л ягштал мөрдөхийг хичээдэг байна. Тиймээс аливаа компанийн том хувьцаа эзэмшиж байгаа хүн ТУЗ-ийн тоог хуулинд заасан тоонд хүргэхийн тулд ойр дотныхоо хүмүүсийг оруулдаг. Тэр битгий хэл, 18 нас хүрсэн л бол ач охиноо ч бичих нь энүүхэнд гэнэ.

Тэгэхээр бэлгэдлийн шинжтэй ТУЗ-ийг тун удахгүй баяртай гэж хэлэх нь ээ. ■

PPP түншлэл

Улаанбаатар хот ба PPP

Төр, хувийн хэвшлийн харилцан ашигтай хамтын ажиллагааг өрнүүлэх, Засгийн газар болон Улаанбаатар хотын өмнө тулгарч байгаа бэрхшээлийг шийдвэрлэх зорилгоор “Улаанбаатар хот-төр, хувийнхэвшлийн түншлэл” зөвлөлдөх уулзалтыг хоёр дахь удаагаа зохион байгууллаа. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Г.Мөнхбаярын санаачилгаар чуулдаг энэхүү уулзалтад Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд, Элчин сайдууд, олон улсын байгууллагуудын суурин төлөөлөгчид, хувийн хэвшлийнхэн болон нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын удирдлагуудын төлөөлөл нийт 120 хүн оролцсон юм.

Ерөнхий сайд С.Батболд тус уулзалтыг нээж “Сая гаруй хүн амтай Улаанбаатар хотын хөгжил дэвшлийн асуудал Засгийн газрын анхаарлын төвд байх ёстой. Олон улсын стандарт, шинээр хөгжиж байгаа хотуудын эрх зүйн орчин, төлөвлөлт, хөгжлийн бодлогын судалгааг авч, тодорхой ажил хэрэгжүүлж байна. Хөгжлийн банкны 500 сая ам.долларын санхүүгийн зээлийг зам, орон сууц зэрэг нийслэлийн бүтээн байгуулалтад зориулахаар төлөвлөж байгаа. Төрийн зүгээс хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх бодлогыг нээлттэй, хяналттай дэмжиж байгаа. Энэ тал дээр шаардаж, хариуцлага үүрүүлж ажиллана” гэв.

Өнгөрсөн жил нийслэлийн өмнө тулгамдаж буй асуудлыг цогцоор нь шийдвэрлэх “Улаанбаатар хот - Түншүүдийн зөвлөлдөх уулзалт”-ыг хийж 47 төсөл танилцуулж байсан бол энэ жил 44 багц төслийг хэлэлцлээ. Эдгээр багц нь хэрэгжих байршлынхаа хувьд задран нийт 71 ажил болж, найман чиглэлээр хийгдэх юм байна.

Нийслэлд 2010 онд хэрэгжүүлэхээр НИТХ-аас баталсан 44 багц ажлаас өнөөгийн байдлаар Яармагийн гүүрээс Нисэхийн товчоо, Сонсголгогийн гүүрээс



Яармагийн товчоо хүртэлх 18 км зам, Нисэхийн товчоо-Биокомбинат-Шувуун фабрик хүртэлх 22.5 км зам, Ар зайсан-Их Монгол Улсын гудамжны 3.8 км зам, Шарга морьтын уулзвараас Гүнтийн даваа хүртэлх таван км зам, Сонгинохайрхан дүүрэгт байгуулах Нийслэлийн ахмадын сувилал, Багануур дүүрэгт байгуулах Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, хүүхдийн цэцэрлэгийн төслүүдийн уралдаант шалгаруулалтыг зарлажээ. Түүнчлэн Нийслэлийн цагдаагийн газрын барилгыг концессын гэрээгээр барих зөвшөөрлийг НИТХ-ын тэргүүлэгчдээс Нийслэлийн Засаг даргад олгожээ. Цаашид хотын нийтийн тээврийн автобусны зарим эцсийн буудлуудыг үйлчилгээний төвийн хамт цогцоор нь шинэчлэх, цэцэрлэг байгууламжийн төслүүд, нягтрал ихтэй төв замын нүхэн гарц, дүүргүүдэд хоккей мөсөн гулгуурын заал, хүүхдийн цэцэрлэг сургуулийг байгуулах төслүүдийг концессын гэрээгээр хэрэгжүүлэх, концесс олгох уралдаант шалгаруулалтыг зарлахаар бэлтгэл ажлыг хангасан байна.

Уралдаант шалгаруулалтын шаардлагын талаар Улаанбаатар хотын Ерөнхий менежер Ч.Батаас тодруулахад “Нэгдүгээрт, тухайн компани зээл авахгүйгээр хөрөнгө

мөнгөтэй байна. Хоёрдугаарт, тухайн ажлыг гүйцэтгэх мэргэжлийн хүний нөөц, техник тоног төхөөрөмж, ажлын туршлагатай байх. Гуравдугаарт, гэрээт ажлыг зөвхөн зоосны нүхээр харах бус, нийгмийн хариуцлага ба иргэдэд үйлчилгээ үзүүлэх санаачилга гаргаж байгаа байдлаар нь тус бүр дүгнэнэ” гэлээ.

Төр, хувийн хэвшлийн түншлэл гэж урт хугацааны хамтын ажиллагааг хэлдэг бөгөөд 10, 20, 30, 40 жилийн төсөл хэрэгжүүлэх гэрээнүүд хийгддэг юм байна. Англи улсад 56 жилийн настай замын ажлын гэрээ байгуулсан жишээ ч бий. Төрийн өмчийн хорооны Концессын газрын дарга Б. Заяабал “Тухайн төслийн онцлог, хөрөнгө оруулалт, зарцуулсан мөнгөө нөхөхөөс гэрээний хугацаа хамаарна. Олон улсын жишгээр бол 40, 50 жил үргэлжилдэг. Манай орны хувьд гэрээг хэрэгжүүлэх хамгийн богино хугацаа хоёр жил, хамгийн урт нь 30 жил байх болно” хэмээсэн бол Улаанбаатар хотын Захирагч Г.Мөнхбаяр “Концессын ажлыг олон улсын туршлага дээр үндэслэн хийх хэрэгтэй. Хувийн хэвшлийн оролцоог тодорхой, оновчтой болгоно гэдэгт итгэлтэй байна. Бидэнд туршлага дутаж болно, санаачилга харин дутаж болохгүй” гэж онцолсныг энд тэмдэглэе. ■

Бизнес зөвлөгөө

Шинэ санаагаа том бизнес болгохын тулд багаа яаж сонгох вэ? Найз нөхөдтэйгээ хамтрах нь зөв үү?

Т.Лхагвадорж /“Хүннү коал” компанийн захирал/:

20 минут ярилцахад л хангалттай

-Австрали түнш Матью Вүүд маань хамтарч компани байгуулах санал тавих үед шийдвэр гаргахад нэлээд бэрх байсан. Гэхдээ зөн совин гэж байдаг даа. Матью анхнаасаа л итгэж болох хүн шиг санагдсан юм. Тэгээд л бид компаниа байгуулж, Австралийн хөрөнгийн биржид IPO хийсэн нь амжилттай болсон.

Ер нь аливаа хүнд итгэж болох уу, үгүй юү гэдгийг 20 минут ярилцахад л мэдэж болно гэж би боддог. Ямар ч хамаагүй сэдвээр ярилцахад л тэр хүний үзэл бодол тодорхой болоод ирнэ шүү дээ. Тухайн хүнээ таньж мэдэж байж л хамтарч ажиллаж болох, эсэхээ эргэцүүлэх хэрэгтэй болов уу.

Л.Ариунболд /“Монгол 999 үндэсний нэгдэл” ХК-ийн гүйцэтгэх захирал/:

Харилцан бие биенээ хүлээн зөвшөөрсөн оюуны нэгдэл юм


- Бизнес гэдэг бол санхүүгийн зах зээлтэй адилхан итгэлцэл дээр тогтдог зүйл. Тийм болохоор хамгийн нэгдүгээр асуудал нь харилцан бие биенээ хүлээн зөвшөөрсөн оюуны нэгдэл байх нь чухал. Баг болж ажиллахад мэдлэг мэргэжил, англи хэл гээд олон зүйл шаардана л даа. Гэхдээ хэчнээн мундаг хэлтэй байлаа гээд тэр хүн бизнесийг сайн удирдаад явж чадахгүй. Тэгэхээр биенээ хүлээн зөвшөөрдөг дотоод хүсэл эрмэлзэл нэгтэй, нэг зүгт харсан баг байх ёстой. Илтгэлцэл гэдэг асар том юм цаана нь явж байгаа учраас.

Хоёрдугаар асуултын тухайд, найз нөхөдтэйгээ хамтрах нь буруу гэсэн юм байхгүй л дээ. Удирдлага хүн дайсантайгаа ч ажиллаж чаддаг байж үр дүнд хүрнэ. Өөрөөр хэлбэл, удирдлагын чармайлтаас шалтгаална.

С.Мижиддорж /“Эрд маш” группийн ерөнхийлөгч/:

Хамгийн чухал суурь асуудал боловсон хүчин

-Баг бүрдүүлнэ гэдэг ажиллах хүчний тухай асуудал юм. Үйлдвэрлэл, бизнесийн шинэ санаа төрлөө. Ажил юунаас эхлэх вэ хүнээс эхэлнэ. Хүн нийгмийн хөдөлгөгч хүч. Улс орныг хөгжил дэвшилд хэн хүргэдэг билээ, хүн



л хүргэнэ. Тэгэхээр шинэ санааг том бизнес болгоё гэж зорьж, мөрөөдөж байгаа хүнд бол хамгийн үндсэн суурь асуудал нь боловсон хүчин юм. Сэтгэл санаа, зорилго нийлсэн баг байх ёстой. Тэгээд бизнесийн туршлага байх хэрэгтэй.

Англи, АНУ-ын том компаниудад ажиллаж байгаад Монголдоо бизнес эрхлэхээр ирээд, надаас зөвлөгөө авч байсан залуучууд байдаг. Тэдний бизнес одоо амжилттай яваа.

П.Болдгэрэл /“New voice” ХХК-ийн захирал/:

Хэн нь тууштай, хэн нь надад үнэн ч байх билээ...

-Юуны түрүүн тухайн сонгосон төслийн чиглэлээр ажиллахад хэр зэрэг мэргэшсэн хийгээд туршлагыг нь харгалзан үзэх хэрэгтэй болов уу.

Найз нөхдөө сонгож болно л доо. Гэхдээ мэдээж хэн нь шударга билээ, хэн нь зорилгодоо тууштай явж чадах билээ, хэн нь надад үнэнч байх билээ гэдгийг сайтар тунгаан бодох хэрэгтэй. Нэгэнт чиний найз нөхөр учраас дээрх шалгуурт хэн нь тэнцэхийг андахгүй учраас сонголт хийхэд харьцангуй хялбар байх талтай.

Л.Бат-Өлзий /“Сектех сервис” ХХК-ийн ерөнхий захирал/:

Хамгийн сайн мэргэжилтнүүдийн зөвлөгөөг ав

-Багаа бүрдүүлнэ гэдэг нь бизнес цааш хэрхэн явахын гол үндэс болж өгдөг. Тиймээс миний хувьд тухайн бизнес эрхлэх салбарынхаа хамгийн сайн шилдэг мэргэжилтнүүдийн зөвлөгөөг авч, тэдний туршлагыг судална. Өөрөөр хэлбэл, мэдлэг чадавхитай боловсон хүчнийг олж багаа бүрдүүлэхийг хичээнэ. Түүнээс найз нөхдөө сонгохгүй. Учир нь, найз нөхдийн хүрээнд бизнес бүтэл муутай гэж боддог. Гэхдээ найз нөхдийнхөө сайн мэддэг бизнес эрхлэх гэж байгаа бол хамтраад ажиллах чадвартай, ирээдүйтэй, зангаа мэддэг, үнэнч, шударга байж чадах найзуудаараа багаа бүрүүлж болно л доо. ■

Бизнесийн завсарлага

Та ямар ном уншиж байна вэ?


Д.Ганхуяг

/УИХ-ын гишүүн/:

-Коносукэ Мацушитагийн монгол хэл дээр хөрвүүлбэл “Амьдралаа өөрөө удирдах нь” нэртэй философийн чанартай ном уншиж байгаа. Агуулга нь амьдралынхаа замыг өөрийн онцлогт хэрхэн тохируулж нээхийг харуулсан. Япончууд эл зохиолчийг маш их хүндэлдэг юм билээ” хэмээв.

“Менежментийн эцэг” хэмээгдэх Коносукэ Мацушита нь /1894- 1989 он/ Японы Осака хотод байрлах “Панасоник” компанийн үүсгэн байгуулагч бөгөөд амьдралынхаа турш олон ном зохиол бичиж туурвижээ.

Анх 1968 онд хэвлэгдэн гарсан цагаас хойш уг номыг үе үеийн уншигчид амтархан уншсан хэвээр байна. Энэхүү номноос Та компанийн удирдлагын талаар мэдлэг олохоос гадна амьдралын мөн чанарыг ухамсарлан тунгааж, даж давшгүй мэт санагдах өндөр ханын ард хэрхэн гарах, түүнчлэн аливаа шинэлэг зүйлийг сэдэж олох талаар хэрэгтэй мэдээлэл олж авах боломжтой аж.


<http://www.mongolianeconomy.mn>

Д.Дүгэржав

/Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга/:

Тэрбээр Жон Перкинсийн “Хитмэний өчил” гэсэн номыг уншиж байгаа аж.


“Confessions of an economic HitMan” ном анх 2004 онд хэвлэгдэн гарчээ. “Нью-Йорк таймс”-ийн шилдэг номоор шалгарч, олон долоо хоног бестселлерийн жагсаалтыг тэргүүлсэн Жеймс Бондын адал явдалтай адил зохиолыг Г.Ундрал, А.Ганбаатар нар “Хитмэний өчил” хэмээх нэрээр монгол хэлнээ орчуулан гаргажээ.

Энэхүү ном нь Америкийн их гүрний нууц, олон улсын явуулга, авилгын ертөнцийг уудлан илчилснээрээ нэрд гарсан байна. Жон Перкинс тус номоо анх 1982 онд бичиж эхэлсэн ч 20 жилийн турш дуусгалгүй дөрвөн удаа сүрдүүлэг, хахуулиас болж хойшлуусан түүхтэй. Түүнд 1990-ээд оны эхээр Стоун-Уэбстэр нэртэй томоохон барилгын концерн номоо бичихгүй байхыг нь ятаж, хагас сая ам.долларын хахууль өгч байсныг зохиолч

ярилцлагадаа дурдсан байна.

Эдийн засгийн алуурчид нь дэлхийн янз бүрийн улс орнуудаас тэрбум тэрбумаар нь доллар салгадаг, маш өндөр цалинтай нарийн мэргэжлийн хүмүүс юм. Тэдний ажлын зэвсэг нь хуурамч тайлан, сонгуулийн булхай, хээл хахууль, хар тамхи, эрх мэдэл юм. Жон Перкинс олон жил нууцлагдсан энэ бүх мэдээллийг яаж, хаанаас олж авсаныг Та мэдэхийг хүсэж байна уу? Мөн түүний бичсэн ном бодит тохиолдсон явдал дээр үндэслэсэн эсэхт уншигч Та эргэлзэх хэрэггүй.

Учир нь Жон Перкинс өөрөө цагтаа ХитМэн-ээр ажиллаж байж...




Б.Алтангэрэл

/Peabody компанийн байгаль орчны зохицуулагч/:

Английн BBC телевизийн сэтгүүлч, продюсер Жессика Уильямсын бичсэн энгийн юмнаас өөрчлөлт эхэлж болдгийг харуулсан “Ертөнцийг өөрчлөх ёстой 50 баримт” номыг уншиж байгаа гэнэ.

Энэхүү номонд хөгжилтэй орнууд болон дайн, өлсгөлөн, ДОХ өвчинд нэрвэгдсэн хөгжиж буй орнуудын дүр зургийг хооронд нь харьцуулсан юм. Дэлхий ертөнцийн соёлжилт, нийгэмд гарч буй өөрчлөлтийн тухай өгүүлдэг уг ном нь хүнд нэлээд юм бодогдуулахаар сонирхолтой бичжээ. Зохиолчийн жишээ болгож дурдсан статистикийн тоо баримттай танилцсан хүн бүрийн нүд нээгдэж, өдөр тутмын амьдралыг өөр өнцгөөс хардаг болно. Зарим баримтаас

сонирхуулбал, дэлхийн хүн амын гуравны нэг нь дайнд оролцож, Африк тивийн 30 сая хүн ДОХ-ын халдвар тээгч, таван хүн тутмын нэг нь өдөрт нэг ам.доллараас бага мөнгөөр амь зууж, жил бүр дэлхийн 10 хэл устаж үгүй болдог, дэлхийд 27 сая хүн боолчлогдож, нэг минут тутам автомашины ослын улмаас хоёр хүн нас бардаг байна. ■



Валютын зах

Дотоодын бэлэн бус валютын зах

| Валют | Код | 5/16 | | 4/15 | | Өөрчлөлт (авах ханш) |
|--------|--------|-------|-------|-------|-------|----------------------|
| | | авах | зарах | авах | зарах | |
| Доллар | USDMNT | 1,221 | 1,235 | 1,209 | 1,216 | 1.0% |
| Евро | EURMNT | 1,711 | 1,745 | 1,725 | 1,773 | -0.8% |
| Иен | JPYMNT | 15 | 15.45 | 14.3 | 14.78 | 4.9% |
| Юань | CNYMNT | 187.7 | 192 | 184 | 186.5 | 2.0% |
| Фунт | GBPMNT | 1,947 | 2,037 | 1,946 | 2,030 | 0.1% |
| Рубль | RUBMNT | 42.9 | 44.4 | 42.4 | 43.9 | 1.2% |
| Вон | KRWMNT | 1.1 | 1.15 | 1.09 | 1.17 | 0.9% |

Дотоодын бэлэн валютын зах

| Валют | Код | 5/16 | | 4/15 | | Өөрчлөлт (авах ханш) |
|--------|-------------|----------|----------|----------|----------|----------------------|
| | | авах | зарах | авах | зарах | |
| Доллар | USDMNT | 1,225.00 | 1,231.00 | 1,213.00 | 1,215.00 | 1.0% |
| Евро | EURMNT | 1,730.00 | 1,755.00 | 1,750.00 | 1,755.00 | -1.1% |
| Иен | JPYMNT | 15.20 | 15.40 | 14.65 | 14.75 | 3.8% |
| Юань | CNYMNT | 189.50 | 190.70 | 185.30 | 186.00 | 2.3% |
| Фунт | GBPMNT | 1,960.00 | 2,000.00 | 1,975.00 | 1,990.00 | -0.8% |
| Рубль | RUBMNT | 44.20 | 44.60 | 42.80 | 43.20 | 3.3% |
| Вон | K R W - MNT | 1.16 | 1.19 | 1.14 | 1.16 | 1.8% |

Монгол банкнаас зарласан ханш

| Валют | 5/16 | 4/15 | Өөрчлөлт |
|--------|----------|----------|----------|
| Доллар | 1,219.85 | 1,205.89 | 1.16% |
| Евро | 1,744.75 | 1,748.42 | -0.2% |
| Иен | 15.15 | 14.44 | 4.9% |
| Юань | 187.76 | 184.66 | 1.68% |
| Фунт | 1,987.93 | 1,971.09 | 0.9% |
| Рубль | 43.86 | 42.74 | 2.6% |
| Вон | 1.12 | 1.11 | 0.9% |

Олон улсын валютын зах

| Суурь валют | 5/16 | | 4/15 | | Өөрчлөлт |
|-------------|---------|-----|--------|-----|----------|
| 1 EUR = | 1.413 | USD | 1.443 | USD | -2.1% |
| 1 USD = | 80.94 | JPY | 83.13 | JPY | -2.6% |
| 1 GBP = | 1.6204 | USD | 1.6328 | USD | -0.8% |
| 1 EUR = | 114.52 | JPY | 119.96 | JPY | -4.5% |
| 1 USD = | 6.5 | CNY | 6.53 | CNY | -0.46% |
| 1 USD = | 28.12 | RUB | 28.13 | RUB | 0.0% |
| 1 USD = | 1091.18 | KRW | 1089.8 | KRW | 0.1% |

М нг ний зах зах

Монголын санхүүгийн зах зээлийн холбоо, "Thomson Reuters"-ын хамтран гаргадаг UBIBOR буюу Улаанбаатарын банк хоорондын захын суурь хүү дөрөвдүгээр сарын 15-наас тавдугаар сарын 16-ны хооронд огцом өөрчлөлтгүй байлаа. UBIBOR (Overnight)-ын зарах хүү 10 хувьтай байгаа нь Монголд зээлийн хүү өндөр байгааг харуулж байна. Учир нь ам.долларын LIBOR буюу Лондоны банк хоорондын захын суурь хүү 0.77 хувьтай байгааг мэргэжилтнүүд тайлбарлав.


Гэхдээ жилийн хугацаатай UBIBOR оны эхний улиралд зургаан хувиар буурсан нь цаашид бизнес эрхлэгчдийн зээлжих зардлыг багасгах сайн нөлөөтэй аж. UBIBOR нь банкуудын хадгаламж, зээлийн хүүг таамагладаг индикатор болдог буюу уг үзүүлэлтийн хэлбэлзлийг дагаад банкуудын хадгаламж, зээлийн хүү өөрчлөгддөг зүй тогтолтой. Гэхдээ энэ нь дунджаар дөрвөн сарын хугацааны хоцролттой явагддаг байна. Өөрөөр хэлбэл, UBIBOR хүү өөрчлөгдсөнөөс дөрөв орчим сарын дараа банкуудын хадгаламж, зээлийн хүү дагаж өөрчлөгддөг юм.

Таван тэрбум юанийн своп хэлцэл хийлээ

Монголбанкны ерөнхийлөгч Л.Пүрэвдорж, Хятадын Ардын банкны ерөнхийлөгч Жоу Шиао Чуан нар үндэсний мөнгөн тэмдэгт солилцох своп хэлцлийн гэрээ хийсэн билээ. Энэ нь монголчуудын хувьд шинэлэг ойлголт боловч бусад орны хүмүүст, ялангуяа хятадуудад бол огтхон ч тийм биш юм. Санхүүгийн хямралын дараа Хятадын Ардын банк БНСУ, Хонконг, Малайз, Беларусь, Индонези, Аргентин, Исланд, Сингапур, Шинэ Зеланд, Узбекистан болон Монголтой нийт 834.2 тэрбум юанийн своп хэлцэл байгуулаад буйг "Синьхуа" агентлаг мэдээлжээ.

Гурван жилийн хугацаанд үйлчлэх дээрх гэрээний хүрээнд манайх Хятадын Ардын банкинд төгрөг өгөөд, оронд нь юань авах боломж бүрдэж буй. БНХАУ нь Монгол Улсын гадаад худалдааны гол түнш бөгөөд тус улсын юань манай валютын зах зээлд идэвхтэй арилжаалагддаг хоёр дахь гадаад валют билээ. 2010 оны байдлаар Монголын экспортын 84, импортын 30 хувийг урд хөрш дангаараа эзэгнэж байв. Гэвч Хятадтай хийж байгаа нийт худалдааны 35 хувийн төлбөрийг юаниар, үлдсэн 65 хувийг нь ам.доллараар хийдэг ажээ. Тэгэхээр своп хэлцлийн гэрээ байгуулснаар цаашдаа юаниар хийх гадаад худалдаагаа сайжруулах нөхцөл бүрдэж буй хэрэг. Тодруулбал, бид БНХАУ-тай хийх гадаад худалдааныхаа 30 хувийг төгрөгөөр төлж юань аваад санхүүжүүлэх боломжтой болсныг Монголбанкны Санхүүгийн зах зээлийн хэлтсийн захирал Ж.Батаа тайлбарласан юм. Ингэснээр гадаад зах зээлийн янз бүрийн эрсдэлээс өөрсдийгөө тодорхой хэмжээгээр хамгаалж, дархлаажуулж байгааг тэрбээр онцлов. Түүнчлэн төгрөгийн тогтвортой байдлыг хангахад ч дээрх гэрээ чухал үүрэгтэй юм байна. Арилжааны банкуудын юаниар төлбөр түргэн гүйцэтгэх чадвар муудсан тохиолдолд Төвбанк зах зээлд Хятадын үндэсний валютыг шуурхай нийлүүлэх боломж бүрджээ.

UBIBOR (Overnight)



Бондын зах

| Улс | Валют | Хугацаа | Купон | Өгөөж | Өгөөж | |
|--------|--------|---------|-------|-------|-------|-------|
| | | | 5/16 | | 4/15 | |
| Монгол | Төгрөг | 3 сар | - | 11.86 | - | 11.86 |
| АНУ | Доллар | 3 сар | - | 0.02 | - | 0.06 |
| | Доллар | 2 жил | 0.75 | 0.52 | 0.75 | 0.69 |
| | Доллар | 5 жил | 2.12 | 1.82 | 2.12 | 2.12 |
| | Доллар | 10 жил | 3.37 | 3.16 | 3.37 | 3.41 |
| Герман | Евро | 3 сар | - | 0.92 | - | 0.76 |
| | Евро | 2 жил | 1.25 | 1.80 | 1.25 | 1.84 |
| | Евро | 5 жил | 2.50 | 2.44 | 2.50 | 2.71 |
| | Евро | 10 жил | 3.25 | 3.09 | 3.25 | 3.38 |
| Англи | Фунт | 6 сар | - | 0.84 | - | 0.76 |
| | Фунт | 2 жил | 3.25 | 0.99 | 3.25 | 1.20 |
| | Фунт | 5 жил | 5.00 | 2.04 | 5.00 | 2.32 |
| | Фунт | 10 жил | 4.50 | 3.36 | 4.50 | 3.60 |
| Япон | Иен | 6 сар | - | 0.12 | - | 0.13 |
| | Иен | 2 жил | 0.30 | 0.19 | 0.30 | 0.21 |
| | Иен | 5 жил | 0.70 | 0.44 | 0.70 | 0.54 |
| | Иен | 10 жил | 1.30 | 1.15 | 1.30 | 1.29 |

Хувьцааны зах

Топ 20



Nikkei 225



DAX



РТС индекс навс унав

ОХУ-ын голлох индекс болох РТС болон ММВБ өнгөрсөн дөрөвдүгээр сард оргил цэгтээ хүрч байсан бол тавдугаар сарын дунд үед 2011 оны доод цэгтээ тулаад байна. Дэлхийн зах зээл дэх газрын тосны эрэлт хумигдаж, үнэ буурч, АНУ-ын нефтийн нөөц тогтмол нэмэгдэж байгаа нь Оросын зах зээлд сөргөөр нөлөөлжээ. “Сбербанк”, ВТБ, ЛУКОЙЛ, “Газпром” зэрэг хойд хөршийн томоохон компанийн орлого нэлээд нэмэгдсэн талаар мэдээлэл цацагдсан нь ч нэмэр болсонгүй. Дөрөвдүгээр сарын 15-наас тавдугаар сарын 16-ны хооронд РТС индекс 9.3 хувиар огцом унасныг хүснэгтээс харна уу. Нефтийн ханшаас гадна энэ оны эхний улиралд хойд хөршийн ДНБ ердөө 4.1 хувиар өссөн нь индексийн

уналтад тодорхой хэмжээгээр нөлөөлсөн байх магадлалтайг шинжээчид тайлбарлав. Тус улсын Эдийн засгийн хөгжлийн яам ДНБ-ээ 4.5 хувиар өснө гэсэн хүлээлттэй байжээ. Үүний хажуугаар Их Британийн ВР болон хойд хөршийн “Роснефть” компанийн хувьцаа солилцох хэлэлцээ тасалдсан нь хөрөнгө оруулагчдын Оросын зах зээлд итгэх итгэлийг алдагдуулсан хэмээн мэргэжилтнүүд дүгнэж байна.

RTS



Market Data

FTSE 100



Shanghai



Hang Seng



Dow Jones



Kospi



Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй Топ 20 компанийн хувьцааны хани

| Нэр | Код | IV.15 | Нэг сарын өөрчлөлт (хувиар) | Зах зээлийн үнэлгээ (тэрбум төгрөг) |
|-------------------------------|-----|--------|-----------------------------|-------------------------------------|
| Багануур | BAN | 18,300 | -22.1% | 383.87 |
| Шивээ-Овоо | SHV | 24,000 | -15.2% | 322.06 |
| АПУ | APU | 2,980 | -0.7% | 221.38 |
| Шарын гол | SHG | 17,000 | -22.7% | 122.93 |
| Монголын цахилгаан холбоо | MCH | 2,930 | -5.5% | 75.8 |
| Би ди сек | BDS | 4,000 | 0.0% | 44 |
| Говь | GOV | 5,300 | -1.9% | 41.35 |
| Адуун чулуун | ADL | 9,390 | -35.2% | 29.59 |
| Могойн гол | BDL | 41,000 | 0.0% | 34.01 |
| Монголиа девелопмент ресурсез | MDR | 1,900 | 11.8% | 23.38 |
| Хөх ган | HGN | 187 | 0.5% | 18.95 |
| Улаанбаатар зочид буудал | ULN | 46,000 | 31.4% | 15.42 |
| Ремикон | RMC | 118 | -9.2% | 15.06 |
| Баянгол зочид буудал | BNG | 24,900 | -14.1% | 10.53 |
| Улсын их дэлгүүр | UID | 350 | -25.5% | 12.88 |
| Женко тур бюро | JTB | 94 | -3.1% | 9.4 |
| Дархан нэхий | NEH | 7,000 | 42.8% | 7.74 |
| Махимпэкс | MMX | 1,555 | -22.3% | 5.91 |
| Ээрмэл | EER | 1,701 | -45.1% | 5.92 |

Уул уурхайн компаниудын үнэлгээ буурчээ


Монголд үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн компаниудын хувьцааны ханш дөрөвдүгээр сарын 15-наас тавдугаар сарын 16-ны хугацаанд огцом буурсныг хүснэгтээс харна уу. Торонто болон Нью-Йоркийн биржид хувьцаагаа арилждаг “Айвенхоу Майнз” компанийн үнэт цаас 9.2 хувиар хямдарч, 23.13 ам.доллар болсон бол төмрийн хүдрийн хайгуулын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Харанга ресурсез” компанийн Австралийн хөрөнгийн бирж дэх үнэт цаасны ханш хамгийн ихээр буюу 34.7 хувиар унажээ. Харин “Сентерра гоулд”-ын хувьцааны үнэ 9.1 хувиар өссөн нь дэлхийн зах зээл дэх алтны ханш өндөр хэвээр байгаатай холбоотойг мэргэжилтнүүд тайлбарлав.

Монголд үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн компаниудын хувьцааны ханш

| Нэр | Бирж | Код | V.16 (ам. доллар) | Нэг сарын өөрчлөлт (хувиар) | Зах зээлийн үнэлгээ (сая ам.доллар) |
|-----------------------------|-----------|-----------|-------------------|-----------------------------|-------------------------------------|
| Ivanhoe Mines | NYSE, TSX | IVN | 23.13 | -9.2% | 16,356.9 |
| Centerra Gold | TSX | CG | 19.68 | 9.1% | 4,577.7 |
| Mongolian Mining Corp | HKEx | 975 | 1.2 | -6.3% | 4,621.3 |
| SouthGobi Energy Resources | TSX, HKEx | SGQ, 1878 | 11.65 | -10.5% | 2,036.3 |
| Mongolia Energy Corp | HKEx | 276 | 0.21 | -26.9% | 1,404.8 |
| Aspire Mining Limited | ASX | AKM | 0.76 | -28.0% | 518.8 |
| Petro Matad | LSE | MATD | 2.4 | -26.0% | 505.5 |
| Hunnu Coal | ASX | HUN | 1.57 | -10.8% | 286.4 |
| Entrie Gold | TSX, AMEX | ETG, EGI | 2.38 | -13.8% | 283.3 |
| Erdene Resource Development | TSX | ERD | 1.08 | -25.5% | 116.5 |
| Xanadu Mines | ASX | XAM | 0.54 | -15.0% | 90.2 |
| Haranga Resources | ASX | HAR | 0.34 | -34.7% | 63.4 |
| Khan Resources | TSX | KRI | 0.31 | -14.3% | 18.8 |

Таваарын зах

Хонгон цагаан (тн/ам.доллар)




Цайр (тн/ам.доллар)




Хар тугалга (тн/ам.доллар)




Никель (тн/ам.доллар)




Газрын тос (баррель/ам.доллар)



Алт (унци/ам.доллар)



Байгалийн хий (MMBtu/ам.доллар)



Зэс (тн/ам.доллар)



Мөнгөний зах зээлд үүссэн хөөс хагарав

Энэ оны эхний улиралд өсөлтөөрөө дэлхийг гайхуулж, сүүлийн 31 жилийн дээд цэгтээ тулаад байсан мөнгөний үнэ цэнэ буурав. Хоёрхон долоо хоногийн дотор 30 гаруй хувиар хямдарсан нь мөнгөний зах зээлд 1983 оноос хойш тохиолдсон үнийн хамгийн огцом уналт болохыг “Bloomberg” онцолсон юм.

Европын өрийн хямрал хийгээд валютын зах зээл дэх тогтворгүй байдал, инфляцийн айдастай холбоотойгоор мөнгөнд асар ихээр хөрөнгө оруулж байсан хүмүүс гэнэт ухаан орж, хэт туйлширснаа ойлгосноос үнэ унасан тухай мэргэжилтнүүд тайлбарлав. Өөрөөр хэлбэл, мөнгөний зах зээлд бий болсон хөөс хагарчээ. Өнгөрсөн дөрөвдүгээр сарын 15-наас

тавдугаар сарын 16-ны хооронд унци мөнгөний ханш 19.4 хувиар буурч, 34 ам.доллар болсныг графикаас харна уу. Дөрөвдүгээр сарын сүүлчээр уг металлын үнэ бүр 50 ам.долларт дөхөж очоод байсныг сануулах юун.

Алт, мөнгөний худалдаанд эцсийн хэрэглэгч гэхээсээ илүү хөрөнгө оруулагчид идэвхтэй оролцох болсон. Үүнээс үүдэн эрэлт, нийлүүлэлтийн хандлага буюу суурь үзүүлэлтүүдээс гадна зах зээлд оролцогчдын сэтгэл санааны байдлаас үнэ ихээхэн шалтгаалах хандлагатай болсныг “Natixis” банкны шинжээчид тайлбарлав байна. Тус банкны 2010 онд явуулсан судалгаагаар мөнгөний нийт эрэлтийн 26 хувийг хөрөнгө оруулагчид үүсгэж


байсан нь хямралын өмнөхөөс гурав дахин өссөн үзүүлэлт аж. Өнгөрсөн жилийн байдлаар мөнгөний хөрөнгө оруулалтын эрэлт түүхэн дээд түвшиндээ хүрч, 210 сая унци болсныг “Грандис Капитал” компанийн шинжээч Денис Барабанов ч мөн тэмдэглэжээ.

Харин үйлдвэрлэлийн бодит эрэлтийг авч үзвэл нийлүүлэлтээсээ нэлээд доогуур байгаа юм. GFMS компанийн үзүүлэлтээс харахад өнгөрсөн онд мөнгөний зах зээл дэх илүүдэл 5450 тоннд хүрсэн нь нийт үйлдвэрлэлийн эрэлтийн тавны нэгтэй дүйцэж байсан юм. “Natixis”-ийн шинжээчдийн тооцоолсноор энэ жилийн эхний дөрвөн сарын байдлаар 1224 тоннын илүүдэл байсан бөгөөд уг үзүүлэлт 2011 оны эцэс гэхэд 4900 тоннд хүрэх төлөвтэй. Түүнчлэн мөнгөний үнэ өндөр байгаагаас уурхайн хөрөнгө оруулалт нэмэгдэж, олборлолт ихсэх хандлага байгаа аж. Өөрөөр хэлбэл, нийлүүлэлт өсөх хүлээлт бий.

Энэ оны хоёрдугаар улиралд унци мөнгөний ханш 37 ам.доллар, гуравдугаар улиралд 29, оны дундаж үнэ нь 31.5 ам.доллар байна хэмээн “Natixis” дүгнэж буй. Харин “Silver Standard Resources” компанийн ерөнхийлөгч Жон Смит мөнгөний үнэ эргээд өснө гэсэн бодолтой байгааг “Kitco News” мэдээлжээ.

Алтны үнэ өндөр хэвээр байгаа нь мөнгөний ханшид эергээр нөлөөлөх учиртай аж. Түүнчлэн орчин үеийн хүмүүс хэтэрхий үнэтэй алтан гоёл чимэглэлийн эдлэлээс зайлсхийж, мөнгөн эдлэл сонгох нь элбэг болсон байна. Мөнгөний үйлдвэрлэлийн эрэлтийн талаас илүү хувийг аж үйлдвэрлэлийн салбар, 20 орчим хувийг гоёл чимэглэлийн салбар бий болгодог юм. Гэвч сүүлийн үед анагаах ухаан, электроник, автомашины үйлдвэрлэлд уг цагаан металлыг өргөнөөр ашиглах болжээ. Үүний хажуугаар нарны эрчим хүчний салбарт мөнгөний хэрэгцээ их гарч буй. Эдийн засгийн өсөлтөөрөө дэлхийд тэргүүлж буй Энэтхэг болон Хятад орон нарны эрчим хүчний чадлаа нэмэгдүүлэхэд нэлээд анхаарч байгаа нь мөнгөний эрэлтийг нэмэгдүүлэх хандлагатайг шинжээчид онцолж байна.

Мөнгө (унци/ам.доллар)



able to save more than MNT100 billion," the head of the Energy Authority Ts. Bayartsogt said.

When will the tender bid be announced?

The technical and economic feasibility study of the project is now in its final stage. The ADB's significant efforts in conducting relevant analysis and studies on building new sources of power up until today should not pass unnoticed. The bank cooperates in the thermal power station No.5 project by conducting studies within the framework of the government-private sector partnership. ADB has selected and signed an agreement with the U.S. Company H&J as a consulting company to conduct the technical and economic feasibility study. After the completion of the technical and economic feasibility study, the State Property Committee is planning to conduct many activities - including the selection of the type of concessions, announce and conduct the tender bid, evaluate and sign a concession agreement with the company that wins the tender, and consequently, start construction works. This time the draft of the tender proposal will be clear, profitable, and open to investors. The first tender bid for the thermal power station No.5 had been announced in 2008 by the former Ministry of Fuel and Energy. Out of the 26 parties interested which obtained the tender bid materials, only China Datang Corporation sent its proposal. However, the tender was cancelled as the company's financial proposal did not meet the requirement. The basis for the large scale operations were initiated only with the second tender bid.

The thermal station which shall be built within the decade will require in total USD1.4 billion. The consulting company advised on the basis of its studies for a financial scheme to either be a joint financing scheme gathering the ADB and other donor organizations, either be fully financed with governmental funds, or be a commercial project within the framework of government-private sector partnership. In addition, they pointed out that, a low interest aid from the ADB and donor organizations will result in a cheaper investment, due to lower capital expenditure and tariffs. On the other hand, a government and private sector loan will raise the expenses of the project.

It is now up to the State Property Committee to decide on the type of financial scheme and financial plan of operations. In any case, the building of a new source of thermal power has been put on paper and has been approved after going through all levels of governmental meetings. Now the only thing left is to announce the tender bid, to establish the agreement with the investors, and start the first phase of construction works.

NEW COMBINED HEAT AND POWER PLANT IN ULANBAAT



The answer could easily be 'why not?' The construction of the thermal power station No.5 - or extension of the thermal power station No.3 - is a good thing and will constitute the base for the vast construction and building work which face Mongolia at the dawn of this new century. It will allow the renewal of techniques and technologies which are obsolete.

Between 1995 and 1999, USD48.8 million was used to renovate the thermal power station No.3. USD39.6 million low interest loan from the ADB was spent on the high pressure furnace renovation, USD5.8 million from the Nordic Development Fund were used to renovate the turbine reconstruction, and USD3.3 million for the renovation of the thermal supply network were financed by the DANIDA grant aid. Thanks to this renovation work, the thermal power station was able to reliably supply power to certain districts of the capital city. However, these equipments are once again starting to wear off and it has been estimated that the thermal power station No.5 is the most acceptable alternative economically. "By choosing the foundation of the thermal power station No.3 we are

New Development for the Thermal Power Station No.5

Mongolian government officials say nothing but "yes" to the building of new plants or new sources of thermal power, which are required by the current development needs of the country.

Nevertheless, the project has been put on hold for many years - like the Oyu Tolgoi mining project - before to be approved.


Since 2005 up until today, many talks and studies on the matter of new sources of thermal power have taken place. At the beginning, the thermal power station No.5 was planned to be built to the East of Ulaanbaatar or in the Uliastai region. However, expert organizations came to the conclusion that the soil freezes on this location, which would contribute to the air pollution of the capital city and negatively affect its water reserves. The search for a new location site was launched.

Later, it was concluded that if the thermal power station was to be located near the Honkhonor radio station, it would be too close to the Bogd Mountain, a natural conservation area and exclusion zone. In addition, it was also stated that the location was too remote - around 27 to 28km away from the thermal power line - and that the uneven elevated ground which lays at an altitude of about 100 meters above the city level will create difficulties for the water cycle in the thermal power line.

Finally, after many studies on a possible location, it was decided that the new power plant would be built as an extension to the thermal power station No.3.

What kind of station will it be?

The large-scale thermal power station shall be fully operative by 2020. The station will have a capacity of 1,101 kilocalories per hour, and an electric power production capacity of 820 Megawatts. 2,500 to 2,800 tons of coal will be burned annually to produce three times more electricity and heating than currently generated. Due to higher



technology, the thermal station will have less impact on the environment. It will refine with 100% efficiency the gas emissions resulting from the burning of coal and will filter with 99.8% efficiency the ashes which will be used for construction materials. 70% of the coal to be supplied to the new plant will come from the Shivee-Ovoo mining site and the remaining 30% from the Bagannur region. Mongolia's current installed power plant capacity is 850 Megawatts and around 5 to 6 million tons of coal are burned annually.

This is Mongolia's largest construction project over the last 20 years, and the nation should without hesitation roll up its sleeves and invest itself fully into the project - which received the approval from the Government - in order to stay in line with global development. The project will be implemented in two phases: the construction of a 450 Megawatts capacity site first - to be operational in 2015 - followed by the construction of a second site with a 370 Megawatts capacity.

Why the thermal power station No.5?

Oyu Tolgoi Investment Agreement: The Facts



Oyu Tolgoi is restating details about the Oyu Tolgoi Investment Agreement today to give Mongolians a better understanding of the terms and reassure them of the benefits it will deliver to the country.

Oyu Tolgoi wants to clearly explain the Investment Agreement so that there is no doubt about the fairness and transparency of the deal with the Government of Mongolia.

Oyu Tolgoi is spelling out the facts to clearly explain the key aspects and underline the transparency of the Investment Agreement. The main points of the landmark Investment Agreement are:

- Oyu Tolgoi is one of the world's greatest copper-gold orebodies and could support mining for more than 60 years based on mineral resources identified by current studies;

- Rio Tinto and Ivanhoe Mines will have invested US\$4.5 billion into the Oyu Tolgoi project by the end of 2011, including more than US\$1 billion on exploration and evaluation before the Investment Agreement was finalized;

- The Oyu Tolgoi Investment Agreement was signed by the Government of Mongolia, Rio Tinto and Ivanhoe Mines on 6 October 2009 and negotiated in accordance with Mongolia's Minerals law;

- Under the Investment Agreement, the Government of Mongolia acquired a 34 per cent interest in the Oyu Tolgoi project, which cannot under any circumstances be reduced. It also has an option to increase its share to 50 per cent;

- The Government of Mongolia will receive the majority of the economic benefits generated by the Oyu Tolgoi project through taxes, royalties and dividends;

- The Government of Mongolia has not and will not be required to contribute any cash from its own resources to fund the development costs of the project. Ivanhoe and Rio Tinto will provide the finance needed for Mongolia's share of the project's capital expenditure; Oyu Tolgoi will create thousands of jobs and business opportunities for Mongolians. Oyu Tolgoi is one of the biggest private sector employers in Mongolia with more than 8000 employees and a wide range of job and training opportunities;

- Hiring and training Mongolians is a priority. As set out in the Investment Agreement, during the life of the mine nine out of 10 workers will be Mongolian;

- Many Mongolian businesses are supplying goods and services to the Oyu Tolgoi project;

- The mine will significantly contribute to the economic development of the Southern Gobi region through infrastructure like roads, power, water and air links.

Cameron McArae, President of Oyu Tolgoi LLC said "The development of the Oyu Tolgoi project has only been made possible by the significant financial commitment of shareholders after the resource was discovered by Ivanhoe Mines. Rio Tinto and Ivanhoe have invested heavily to get the project where it is today. We will continue to spend billions of dollars to get the mine into production and operating at world-class standards.

"The Government of Mongolia and its citizens will receive significant economic and social benefits from Oyu Tolgoi. Extensive independent analysis of the Oyu Tolgoi Investment Agreement by international financial institutions and academics confirms that it represents global best practice.

"The benefits for Mongolia arising from Oyu Tolgoi are built on the bedrock of the Investment Agreement, which provides a firm foundation for the development of the Mongolian economy over many decades.

"It is crucial that the Investment Agreement is supported by the Government to provide confidence for investors and deliver the certainty required for investment in the project. It also sends an important message to international investors that Mongolia is open for business.

"A steadfast commitment to honouring legal agreements and contracts, fairly negotiated in good faith, will place Mongolia in a strong position to raise finance for large-scale projects. The benefits from these projects in turn provide essential funding for government programmes, building national infrastructure and improving the quality of life of all Mongolians."

Mongolia's Biggest & Best Bank

Your Partner of Choice

Differential strength and vision

- Mongolia's largest bank in terms of Total Assets per 2010 audited accounts;
- Mongolia's leading corporate bank with > 30% market share;
- Only Mongolian bank enjoying direct Tier 2 equity related capital from leading commercial entities;
- Credit Suisse and Abu Dhabi Investment Council;
- Only bank to enjoy zero weighted credit risk premium from The Bank of Mongolia (Central Bank);
- Selected by Amex and IATA as exclusive partner in Mongolia (secured after competitor evaluation);
- The pioneer within the Mongolian banking system introducing card services, IT, electronic banking, private banking and investment banking to the market.

Industry leader with the highest market share

- Assets > 25%
- Individual deposits > 30%
- Corporate deposits > 30%
- Corporate loans > 30%
- Card transactions > 60%
- International payments > 60%
- International trade finance > 50%
- Foreign exchange transactions > 40%

The strongest financial structure in the system


- Capital adequacy ratio 13.4%
- Return on Equity 26.6%
- Highest Liquidity 51.2%
- Lowest loans/deposit ratio 59.6%
- Lowest NPLs (Non Performing Loans) 1.5%

Key financial data for last five years

| | 2010 | 2009 | 2008 | 2007 | 2006 |
|------------------------------|--------------------|-----------|---------|---------|---------|
| Assets | 1,573,936 | 1,013,109 | 697,179 | 652,051 | 353,161 |
| Deposits | 1,317,499 | 795,251 | 505,171 | 512,485 | 283,707 |
| Net Loans | 784,605 | 505,299 | 447,787 | 323,026 | 174,700 |
| Capital | 128,072 | 78,471 | 63,548 | 54,871 | 35,794 |
| Post tax profit | 20,053 | 13,170 | 12,201 | 7,378 | 2,520 |
| Return on Average Assets (%) | 1.7 | 1.6 | 1.8 | 1.6 | 0.8 |
| Return on Average Equity (%) | 26.6 | 22.5 | 24.3 | 17.3 | 10.7 |
| MNT=Mongolian Tugrug | USD 1=MNT 1,257.18 | | | | |
| | 31/12/10 | | | | |

CONTACT DETAILS

Golomt Bank of Mongolia, 3 Sukhbaatar Square, P.O.Box 22, Ulaanbaatar 210260A, Mongolia
 Phone: +(976)-11-311971, 311530, Fax: +(976)-11-313155, 312307, E-mail: mail@golomtbank.com
 Treasury Division: +(976)-9911-8212
 Investment Banking Division: +(976)-9911-5444
 Corporate Banking Division: +(976)-9911-8302




MAKE SALKHIT A REALITY

In 2004, Newcom set up its "Clean Energy" company to survey potential wind power generation sites, eventually settling on Salkhit Mountain, 70 km southeast of Ulaanbaatar, as the site for the first project in the renewable energy sector. In 2010 Clean Energy LLC has been incorporated as a foreign invested company at Foreign Investment and Foreign Trade Agency (FTA) with development investments coming from EBRD and FMO. Mongolia faces a challenge in shortage of electricity with large mining operations starting from year 2012 nationwide and energy demand is expected to increase by 5-10% each year. Such demand can be met through the newly established domestic production of electricity including from renewable and non-polluting sources such as Salkhit Wind Park. The Mongolian name of the site "Salkhit Uul" means "Windy Mountain" in English. Bogd Mountain is located in northern part of the area, which is the most southern end of Hentii Mountain range.

The project site is located just in alteration zones between mountains and steppes and occupies 12,000-hectare land in Sergeien soum of Tuv Aimag, the nearest province to Ulaanbaatar. The site wind resource has been identified during several studies and wind measurements. The area locates about 9 km from the railway, 11 km from the paved road, 13 km from the 35 kW grid line and 22 km from the 110 kW grid line in Nalaikh, an older coal mining town 45 km east from Ulaanbaatar.

The Salkhit Wind Park is expected to save 1.40-1.90 million tonne of fresh water and 160-190 thousand tonne of coal every year, thus preventing the emission of 150,000-200,00 tonne of CO₂ equivalent into the atmosphere. To put this figure in perspective, one hectare of forest absorbs 10 tonne of CO₂ per year, which means that the wind park would be equivalent to 15,000 hectares of forest.

The Wind Park will be connected to the Central Regional grid and will produce electricity from clean and renewable energy resources. The renewable energy initiative will pioneer the energy sector of Mongolia towards the long term sustainable economic development of Mongolia led primarily by mining sector meeting the rising demand in energy sector while protecting our environment.



ENERGY
MINING INFRASTRUCTURE

BUSINESS ACTIVITIES

- Power plant
- Power supply
- Power transmission and distribution system
- District heating system
- Renewable energy
- Instrumentation and Control
- Industrial automation

SERVICES

- Project management
- Engineering, designing
- Feasibility study
- Consultancy
- Procurement
- Construction and Commissioning
- Operation and After sales service

Ukhakhudag 18MW Coal Fired Power Plant.
Construction period: 2009-2011
EPC contractor: MCS International Co.,Ltd



MCS International Co.,Ltd, Central Tower, 16 floor, Sukhbaatar district 8, 2 Sukhbaatar Square,
Ulaanbaatar, Mongolia
Tel: (976-11)77226363, Fax: (976-11)77206030,
E-mail: mcsinter@mcs.mn, Web: www.international.mcs.mn

05/15/2011



Mongolia: The Smart Investor's Choice

2011, May, № 004

Mongolian economy and business magazine

ECONOMY
E MONGOLIAN

For a green development



Will the investment boom facilitate
Mongolia's development?

Manufacturing that Puts
Determination and Patience to the Test